



КОВИД 19 БОЛОВСРОЛД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ (МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН)



UIH.MN
СУДАЛГААНЫ САН



КОВИД 19 БОЛОВСРОЛД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ (МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2021 он

Эмхэтгэлийн агуулга : Ковид 19 цар тахлын улмаас боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг зайнаас (цахим, теле) зохион байгуулж буй өнөө үед хүүхэд, залуусын сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн гишүүд 4 сэдэвчилсэн мониторинг, нэг бие даасан судалгаагаар дамжуулан хөндөж, асуудал дэвшүүлэхийг зорилоо.

Сэдэвчилсэн мониторингийн ажлын хэсгийн гишүүд:

- Б.Ардак (“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн Налайх дүүргийн салбар зөвлөлийн зохицуулагч)
- Б.Батжаргал (“Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг” ТББ-ын Гүйцэтгэх захирал)
- Б.Батчимэг (“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн хөтөлбөрийн ажилтан)
- Б.Болорсайхан (Хүний эрхийн шинжээч)
- Г.Ганцэцэг (“Сургуулийн эцэг эх, багшийн үндэсний нэгдсэн холбоо” ТББ-ны зохицуулагч)
- Б.Оюундарь (“Хөөрхөн зүрх” ТББ-ын зохицуулагч)
- С.Сэлэнгэ (“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо” ТББ-ын Гүйцэтгэх захирал)
- Ц.Цогзолмаа (“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн Багануур дүүргийн салбар зөвлөлийн зохицуулагч)
- Д.Энхтуяа “Өсвөр үеийхний хөгжлийн төв” ТББ-ын Тэргүүн)

Редактор

Я.Мөнхчимэг, Д.Тунгалаг

(“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл)

ИИМН
СУДАЛГААНЫ САН

Дизайнер: Халиунцэцэг
Цаасны хэмжээ: 60x84 1/12
Хэвлэлийн хуудас: 11.6 х.х
Хэвлэсэн тоо: 300 ш

“КОВИД 19 ЦАР ТАХЛЫН БОЛОВСРОЛД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ”

(сэдэвчилсэн мониторингийн тайлан)

*Дэмжигч: ASPBAE (Суурь болон насанд хүрээсдийн боловсролын
төлөө Ази, Өмнөд Номхон далайн нийгэмлэг)*

Санхүүжүүлэгч: Боловсролын төлөө чанга дуугарцгаая!

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТАРЧИГ

Өмнөх үг	5
Эрх тэгш, тэгш хамруулах боловсрол ба Ковид 19 (сэдэвчилсэн мониторингийн тайлан)	6
• Теле болон цахим хичээлийн тэгш хамруулсан байдал	11
• Тодорхой бүлгийн хүүхэд, залуусын боловсролд тэгш хамрагдсан байдал	16
• Дүгнэлт	25
Хүүхэд хамгаалал ба Ковид 19 (сэдэвчилсэн мониторингийн тайлан) ..	28
• Хоол тэжээлийн хүрэлцээ, эрүүл мэндийн нөхцөл байдал	32
• “Ковид-19” цар тахлын үе дэх хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн нөхцөл байдал	34
• Хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхан байдлын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	38
• Дүгнэлт	42
Боловсролын салбарын нийгмийн эгэх хариуцлага ба Ковид 19 (сэдэвчилсэн мониторингийн тайлан).....	45
• Иргэд, иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагаа	51
• Мэдээллийн ил тод нээлттэй байдал	56
• Төр – Иргэний харилцааны талбар	57
• Дүгнэлт	58
Боловсролын санхүүжилт ба Ковид 19 (сэдэвчилсэн мониторингийн тайлан).....	62
• СӨБ ба ЕБС-ийн зардлын санхүүжилтийн өнөөгийн байдал.....	64
• Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд, Их дээд сургуулиудын төсөв санхүүжилт	66
• Хувийн хэвшлийн цэцэрлэг, ЕБС, коллеж, их, дээд сургуулиудын төсөв санхүүжилт	66
• Боловсролын салбарын төсөв санхүүжилтийн ил тод байдал, эрсдэл ...	69
• Дүгнэлт	74

Өмнөх үг

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн гишүүн байгууллагууд хамтран гүйцэтгэсэн “Ковид-19 халдварын боловсролд үзүүлж буй нөлөө” сэдэвт “тэгш хамруулах боловсрол”, “хүүхэд хамгаалал”, “төсөв санхүүжилт”, “нийгмийн эгэх хариуцлага” гэсэн 4 хүрээний сэдэвчилсэн мониторинг, мөн түүнчлэн Монголын боловсрол, шинжлэх ухааны ҮЭ-ийн Холбоотой хамтран гүйцэтгэсэн “Багшлах, суралцах үйлд “КОВИД-19”-ийн үзүүлсэн нөлөө” судалгааны үр дүн, зөвлөмжийг та бүхэнд танилцуулж байна.

Боловсрол эвсэл хүн бүрийн сурч боловсрох эрхийг эдлүүлэхийн төлөө бодлогод нөлөөлөн ажилладаг ИНБ-ын хувьд ямар ч үед хүүхэд, залуус, насанд хүрэгчдийн сурах үйл явц тасалдах, зогсох ёсгүй гэж үздэг.

КОВИД 19-ын халдварын үед Монгол улс анх удаа анги танхимын сургалтыг урт хугацаанд зогсоож, зайны сургалтад бүрэн хэмжээгээр шилжсэн нь салбарын хувьд гэнэтийн шийдвэр байсан ч боловсролд хамаатай хэн бүхний хамтдаа суралцах, хөгжих, хамтын хариуцлага хүлээх үйл явц байлаа. Тиймээс иргэний нийгмийн байгууллагын хувьд өөрсдийн хүлээсэн үүргээ биелүүлж, хөндлөнгөөс хяналт мониторинг хийж, төрд хандсан зөвлөмж гаргах нь зүйтэй гэдэг шийдвэрийг Удирдах зөвлөлөөс гаргасан юм.

2020 оны 1 дүгээр сараас 2020 оны 7 дугаар сарын 31 хүртэлх хугацаанд гишүүн байгууллагуудын цуглуулсан мэдээлэлд үндэслэн боловсролын бүх шат түвшинг хамарсан бодлогын хэрэгжилтийн мониторинг хийсэн нь анхны тохиолдол бөгөөд Боловсрол эвсэл бага дунд боловсролын түвшинд илүүтэй анхаарч, үйл ажиллагаа явуулж ирсэн байдаг.

Теле, цахим хичээлийн хүртээмж, чанар зөвхөн салбарын бодлого, сургалтын орчин нөхцөл, бэлэн байдлаас зөвхөн шалтгаалахгүй байдалд орсон бөгөөд эрх зүйн орчны хувьд ч, төсвийн төлөвлөлт, дэд бүтцийн хангамжийн хувьд ч бэлэн биш байсан нь илэрхий болов. Гэрт сургалтын үйл явц өрнөснөөр эцэг эхийн үүрэг роль эрс нэмэгдэж, олон жил эцэг эхийн оролцоог үл ойшоож ирсны үр дагавар ч илрэв. Өмнө бий болсон боловсрол эзэмших тэгш бус байдал улам нэмэгдэх эрсдэл байгааг мониторинг тод харуулав.

Дараа дахин ийм нөхцөл байдал ирэхэд салбараараа, улсаараа бэлэн байхын тулд бидний хийсэн мониторингийн үр дүн, зөвлөмжийг анхааран үзэж, эрх тэгш, тэгш хамруулсан чанартай боловсролыг хүүхэд залуус, насанд хүрэгч хүн бүрт олгохын төлөө гаргах бодлого, шийдвэртээ тусгана гэдэгт найдаж байна.

Хэрэгжилтийн мониторинг хийхэд идэвхийлэн ажилласан гишүүн байгууллагууддаа талархаж байгаагаа илэрхийлье.

*“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн
Ерөнхий зохицуулагч Д.Тунгалаа*

ЭРХ ТЭГШ, ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ БА КОВИД 19

(Сэдэвчилсэн мониторингийн тайлан)

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2020 оны 03 дугаар сарын 12-оос корона вирусын халдварыг цар тахал гэж зарласан бөгөөд манай улс 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн Улсын онцгой комиссын хурлаар 12 сарын сүүлээр улирлын амралт, үргэлжлээд томуугийн дэгдэлтийг таслан зогсоох зорилгоор түр завсарлаад байсан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 1 сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 2 өдөр хүртэл түр зогсоох, энэ хугацаанд сургалтыг зайнаас зохион байгуулахыг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдад үүрэг болгожээ. Түүнчлэн сургууль, цэцэрлэгийг түр хаах хугацааг дахин 3 удаа сунгаж, 9 дүгээр сарын 1-нээс хичээл орж эхлэх шийдвэр гаргасан юм.

Монгол Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд СӨБ-д 263,333 сурагч, ЕБС-д 640,499 сурагч, насан туршийн боловсролын 6,917 сурагч, их дээд сургуульд 148,446 оюутан сурагчид теле болон цахимаар хичээл үзэх шаардлагатай болсон¹. Цахим болон теле сургалтын гадна үлдэх эрсдэлт бүлгүүд болох нийгмийн үйлчилгээ, төрийн бодлогын нөлөөнөөс хол, алслагдмал газар суурьшсан, дэд бүтцийн хүртээмжгүй нөхцөлд амьдардаг, хүнд нөхцөлийг даван туулах, шинэ нөхцөлд дасан зохицох чадавх хязгаарлагдмал, дижитал технологийн хүртээмжгүй нөхцөлд амьдардаг, албан бус эдийн засгаас хамааралтай өрхийн хүүхдүүдэд боловсрол түгээж буй хэлбэр хүртээмжтэй байж чадсан эсэх талаар мониторинг хийлээ. Тодруулбал, малчин өрхийн хүүхдүүд, ядууралд өртсөн гэр бүлийн хүүхдүүд, хэл соёлын цөөнх хүүхдүүд, ЕБС-д дөнгөж явж эхэлж байсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших нөхцөл байдал ковид 19 цар тахлын үед хэрхэн хангагдсан талаар мониторинг хийсэн юм.

Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотойгоор ковид 19-ын боловсрол, сургалтын үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөллийг судлах мониторингийн хүрээнд бид дараах зорилгыг тавьсан. Үүнд:

1. Ковидын үеийн боловсрол олгох үйл явцыг баримтжуулах
2. Боловсролд үзүүлсэн шууд үр нөлөөг судлан тогтоох
3. Боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа сэргэх, эсвэл дахин хямралт нөхцөл бий болоход зохих бодлого, хөтөлбөр, дэмжлэг бий болоход нөлөөлөх зөвлөмж боловсруулах

Үндсэндээ сурагчид 2019-2020 оны хичээлийн жилд 4 сар танхимаар, үлдсэн

бүх хугацаанд хичээлийг зайн сургалтаар үзсэн. Иймд Боловсролын тэгш хамруулсан байх хүрээнд тусгайлан танхимаар хичээл ороогүйтэй холбоотой ямар асуудлууд тулгамдаж байгаа талаар судалж үзсэн болно. Тухайлбал зайны сургалтаас орхигдсон, гадуурхагдсан бүлгүүдийг тодорхойлох, шалтгаан нөхцөлийг олж тогтоох, үзүүлсэн нөлөө, өндөр технологийн, нам технологийн, технологийн биш шийдэл хийсэн эсэх, хүүхэд, залуучууд бие даан суралцах удирдамж, чиглүүлэг хангалттай өгсөн эсэх, сургууль эргэн нээгдэхэд тулгамдах асуудлыг урьдчилан харах, урт хугацаандаа тэгш хамруулах боловсролд хэрхэн анхаарах талаар санал зөвлөмж боловсруулахад чиглэсэн.

Мониторингийн хүрээ:

- Гарсан тушаал шийдвэр
- Боловсролын оролцогч талуудад өгсөн удирдамж, чиглэл
- Зохицуулалт, хэрэгжилтийн байдал
- Тулгамдсан асуудлууд/сорилтууд
- Боломжууд
- Цаашид авах ёстой арга хэмжээний зөвлөмж

Мөн боловсролын тэгш хамралт, эрх тэгш байдлыг хангахад цаашид гарч болох эрсдлүүд, тухайлбал, цахим болон теле хичээл сургалт явагдахад нөлөөлж байгаа цахилгааны хангамж, интернетийн сүлжээ зэрэг дэд бүтцийн нөхцөл байдал, боловсролын салбар эрүүл мэнд, хүүхэд хамгааллын зэрэг бусад салбаруудтай хамтрах байдал, эцэг эхийн боловсрол, оролцоо, дэмжлэг, гэх мэт асуудлуудад анхаарсан болно.

Бид боловсролын 4 шат түвшинг хамрах зорилт тавьсан боловч мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал ХНХЯ-д харьяалагддаг, их, дээд сургууль, коллежийн төсөв, санхүүжилт салбарын яамны түвшинд шийдэгддэггүй тул мэдээлэл хомс судалгааны хувьд хязгаарлагдмал үр дүн гарлаа.

Сэдэвчилсэн багийн гишүүд дараах бүлгийн хүүхдүүд орхигдох магадлалтай хэмээн үзэж, мэдээлэл цуглуулах явцдаа анхаарсан болно.

- Малчдын хүүхэд, (сурагч ба оюутнууд)
- Нийгэм эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхэд/залуус-ядууралд өртсөн хүүхдүүд
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд/залуус
- Эмзэг бүлгийн, сурлагаар хоцрогдож байгаа, бие даах чадвар сул, гэр бүлийн таагүй орчинд өсч буй хүүхдүүд
- Хэл/соёлын цөөнх
- Эрэгтэй/эмэгтэй хүүхдүүд
- Эцэг, эхийнхээ аль нэгтэй нь хамт амьдардаг хүүхэд

Гарсан тушаал шийдвэр

Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, шинэ коронавирусийн халдварын эрсдэлээс сэргийлэх зорилгоор бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоож, улмаар Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаас Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн чиглэл, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтэд үндэслэн бүх шатны сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон хугацааг 2020 оны 6 сарын 1-ний өдрийг хүртэл сунгаж шийдвэрлэсэн.

Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, их дээд сургууль, коллежийн мянга мянган оюутнууд хөл хорио, зорчих хөдөлгөөний хязгаарлалтад орж, 2019-2020 оны хичээлийн жилийн хичээл сургалтын үйл ажиллагааг 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл теле болон цахим хэлбэрээр зохион байгуулсан билээ.

Одоогийн байдлаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын байгууллагуудын нийт 32 төрлийн судлагдахуунаар 4800 гаруй цагийн хичээлийг 426 гаруй багш ажиллагсад зааж бэлтгэн Монгол Улсын өргөн нэвтрүүлгийн 18 телевизээр нэвтрүүлж байна. Боловсролын яамнаас теле хичээлд эцэг, эхчүүдийн оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “Теле хичээлийн эргэн тойронд” нэвтрүүлэг болон 10 төрлийн шторк бүтээн олон нийтэд сурталчлан түгээсэн.

Монгол Улсын Засгийн газраас “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”² тушаалаар өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, хүүхэд харах төв, ерөнхий боловсролын сургууль, коллеж, их дээд сургуулийн хичээл сургалтын үйл ажиллагааг 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд түр хугацаагаар зогсоосон бөгөөд халдварт өвчний талаар мэдээлэл, зөвлөгөөг өгөх, оюутан, суралцагч, багш, эцэг эхчүүдэд зориулсан зөвлөмж чиглэлийг хүргэх, хүүхдийг хараа хяналттай байлгах, аюулгүй байдлыг хангах, гэрийн нөхцөлд халдвараас сэргийлэх арга замыг мэдээллийн хэрэгслээр болон албан байгууллагаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагч нарт чиглэл зөвлөмж өгч ажиллахыг аймаг нийслэлийн Засаг дарга нар, их дээд сургуулийн захирал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны бодлогын газрын дарга нарт тус тус үүрэг болгосон байна. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар засаг дарга, харьяа бүх байгууллагуудад яамнаас чиглэл зөвлөмж хүргүүлжээ.

Үүний үр дүнд цэцэрлэг, ЕБС-ын орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө, удирдамж³ баталсан. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах, хөгжих онцлогийг дэмжсэн

сургалтын гарын авлага, постер, зурагт карт боловсруулж хэвлүүлэх, брайл болон сонсдог аудио хэлбэрээр бэлтгэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх зөвлөмж боловсруулан түгээх
- Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд зориулан ганцаарчилсан сургалтын видео хичээлийн сан бүрдүүлэх
- Хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан зайны сургалт, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид зориулсан зөвлөгөө, мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр боловсруулах

Мөн,

- Үндэстний цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан агуулга, бүхий хичээл сургалтын хуваарийг боломжтой сувгаар, олон давтамжтайгаар хүргэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ, хоол хүнсний хөтөлбөр, эмчилгээ, заслын үйлчилгээ зэрэг цэцэрлэг сургууль дээр үзүүлдэг үйлчилгээг гэрт нь үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн тулд нийгмийн халамж үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээ болон нийгмийн эмзэг бүлгийн иргэд халдварт өвчин түүний хоёрдогч нөлөөлөлд илүү их өртөмтгий байна гэдгийг анхаарч төлөвлөлт хийх
- Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа зогссон үед гэртээ өвчтэй хүн харах үүрэг хүлээх, аливаа хүчирхийлэл, халдлага, мөлжлөгт өртөх зэрэг эрсдэл хүүхдэд, ялангуяа охидод нэмэгдэж болзошгүйг анхаарах талаар тусгажээ.

2020 оны 4 сарын 17-ны өдрийн БСШУС-ын сайдын “Цэцэрлэг, ЕБС-ийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” А/194 тушаалаар аймаг, нийслэлийн БСУГ-ын дарга нарт хичээлийн жилийг дуустал зохион байгуулах теле хичээл, цахим сургалтыг суралцагч бүрт хүрч буй эсэхэд хяналт тавьж, хариу арга хэмжээ авахыг үүрэг болгосон байна.

УИХ-аас 2020 оны 4 сарын 29 өдөр батлагдсан “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуульд “бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулсан, хязгаарласан тохиолдолд цахим, эсхүл бусад хэлбэрээр зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй хүргэх, багш болон суралцагчийн оролцоо, түүнд тавих хяналтыг сайжруулах; (7.1.9.) цар тахлын үед орон гэргүй, нэн ядуу иргэдийг орон байр, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах, халдвараас сэргийлэх ажлыг зохион байгуулах; (7.1.12.) төрөлжсөн асрамжийн газар, түүнчлэн эрүүлжүүлэх, баривчлах, цагдан хорих байр, хорих ангид байгаа болон бусад хэлбэрээр эрх чөлөө нь хязгаарлагдсан иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах; (7.1.13.)

гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээ, түр хамгаалах байранд шаардлагатай хөрөнгө оруулалт болон 24 цагаар ажиллуулах утасны санхүүжилтийг шийдвэрлэх; (7.1.20) цар тахлын үед арга хэмжээ авахдаа хүүхэд болон өндөр настай, хууч өвчтэй, эрүүл мэндийн тогтмол тусламж, үйлчилгээ шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эмзэг бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх; (7.1.22.) зэрэг арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлэхийг үүрэг болгожээ.

Мөн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргах шийдвэр, арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд “хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор болон бусад шинжээр нь ялгаварлан гадуурхахгүй, нэр төрийг нь доромжлохгүй байх” (11.1.5.) шаардлага тавьжээ.

ЕБС-ийн удирдлага, багш, эцэг эх, асран хамгаалагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих, сурах, эрүүл, аюулгүй амьдрах эрсдэлээс хамгаалах нөхцөлийг дэмжсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмж гаргаж, 4 сарын 29-ны өдөр БСШУС-ын яамны сайтад байршуулсан байна. Мөн “ЕБС-ын хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”⁴-ийг баталж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшихэд тулгарч байгаа бэрхшээлийг бууруулахад дэмжлэг тусалцаа үзүүлэх үйл ажиллагааг ЕБС-ын орчинд зохион байгуулахаар болжээ.

Монгол улсын Засгийн Газрын 2020 оны 06 сарын 1-ний өдрийн 208 тоот тогтоолоор Засгийн газрын 2012 оны 5 сарын 03-ны өдрийн 187-р тогтоолын 4-р хавсралтаар баталсан “тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам”-ын 2 дах хэсэгт 2.8 ба 2.9 дэх заалтыг нэмсэн байна. Ердийн цэцэрлэг, ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх нэмэгдэл хөлс олгохоор шийдвэрлэж, 2021 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтжээ. 2020 оны 06 сарын 25-ны өдрийн БСШУС-ын Сайдын А/296 тушаалаар дээр дурдсан тогтоолын хэрэгжилтийг хангах “Нэмэгдэл хөлс олгох заавар”-ыг баталсан. Цэцэрлэгийн багш, туслах багш, бага, дунд, ахлах анги удирдсан болон хүүхэд хөгжлийн танхимын багшид нэмэгдэл хөлс олгохоор шийдвэрлэсэн байна

2020 оны аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авахтай холбоотой ажлын үр дүнг тооцохоор 5 заалт оруулсан. 2019 оны БСШУС-ын сайдын “Журам батлах тухай” А/803 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам”-д тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн

4 2020 оны 05 сарын 21-ны өдрийн БСШУС-ын Сайдын А/249 тушаал

бэрхшээлийн онцлогт нийцсэн орчин бүрдүүлж, тэдэнд үзүүлэх дэмжлэгийг хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж байгаа байдлыг үнэлэхээр тусгасан.

Сургуулийн өмнөх ба бага дунд боловсролын салбарын 2020-2021 оны хичээлийн жилийн зорилго, зорилт батлагдсан ба “Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт, чанарт ахиц гаргах зорилго дэвшүүлж, энэхүү зорилгыг хангах чиглэлээр “танхимын сургалт удаан хугацаагаар зогссоны улмаас хүүхдийн дунд үүсэж болзошгүй түгшүүр, хөгжлийн ялгаатай байдал, сурлагаар хоцрох, сургууль завсардах зэрэг эрсдэлээс сэргийлэх хариу арга хэмжээ авч, тэгш бус байдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлж үр дүнг тооцох; гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, сургалтыг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дэмжин тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулах; цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжихэд эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлийг өргөжүүлэх гэх мэт зорилтыг хэрэгжүүлэхээр тусгажээ.

ТЕЛЕ БОЛОН ЦАХИМ ХИЧЭЭЛИЙН ТЭГШ ХАМРУУЛСАН БАЙДАЛ

БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Монголын телевизүүдийн холбоотой хамтран “Теле хичээл”-ийг зохион байгуулж, бүх хичээлийг дохионы орчуулгатайгаар, Баян-Өлгий аймагт үндэсний цөөнхийн казах, тува хэлээр болон насанд хүрэгчдэд зориулсан насан туршийн боловсролын хичээлүүдийг бэлтгэн түгээсэн байна. Мөн тусгай хэрэгцээт боловсролын теле хичээлийг (тусгай сургуулийн сурагчдад) I-IX ангийн монгол хэл, математик, нийгэм, ахуйн баримжаа хичээлүүдээр 3 сарын 16-ны өдрөөс 5 сарын 31-ны хооронд нийтдээ 189 удаагийн /4725 минутын/ хичээл Сүлд ТВ-ээр орон даяар нэвтрүүлжээ. Теле хичээлийн хуваарийг долоо хоног бүр салбар яамны албан ёсны цахим хуудас болон бусад мэдээллийн сайтаар дамжуулан түгээсэн билээ.

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед зохион байгуулагдсан теле хичээлийн чанарыг сайжруулах талаар болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, боловсролд тэгш хамран сургахад тулгамдаж байгаа бусад асуудлын талаар тандан судалгаа явуулж, Боловсролын хүрээлэнгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, боловсрол, арга зүйн сектор”, БМДИ, 25, 55, 29, 63, 70, 116-р сургуулийн удирдлага, холбогдох мэргэжилтэнтэй уулзалт зохион байгуулж, теле хичээлийн бэлтгэл, чанар, үр дүнг сайжруулах, хүүхэд эцэг эхчүүдийг зөвлөгөө, мэдээллээр хангах ажлыг 4 сарын 1-ээс 10-ний өдрийн хооронд зохион байгуулав.⁵ Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа харааны

5 БСШУСЯ-ны 4 сарын үйл ажиллагааны мэдээ

бэрхшээлтэй болон сонсголын бэрхшээлтэй хүүхдийн суралцах орчин, нөхцөлийг дэмжин сайжруулах арга хэмжээ⁶-ний хүрээнд 4-12 дугаар ангийн 27 нэрийн сурах бичгийг брайл үсгээр хэвлэх, 6-12 дугаар ангийн 18 нэрийн сурах бичгийг харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох үүднээс цахим мэдээллийн систем /DAISY/ хэлбэрт хөрвүүлэх, холбогдох сургалтын хэрэглэгдэхүүнд шаардагдах 70 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэсэн байна.⁷

Сургуулийн өмнөх боловсрол

Монгол Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд СӨБ-д 263,333 хүүхэд хамрагдсан бөгөөд БШУЯ-ны өгсөн мэдээллээр теле хичээлийн хамрагдалт 89.1% байсан гэж үзжээ. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9.9 дэх хэсэгт хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно гэж заасан. 2019-2020 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар тусгай 4 цэцэрлэгт 252, ердийн цэцэрлэгийн тусгай бүлэгт 159, ердийн 280 цэцэрлэгийн 488 бүлэгт 665 хүүхэд, нийт 1076 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшсэн хэмээн бүртгэлтэй байсан бөгөөд хамран сургалт 57.2 хувьтай байна.

Цэцэрлэгүүдийн сургалтын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан 2020 оны 2 сарын 3-ны өдрөөс эхлэн сургуулийн өмнөх боловсролын теле хичээлийг бэлтгэн хүргэжээ. Теле хичээлийг 2 дугаар сарын эхний долоо хоногт 150 минутын 15 хичээл, 2 дугаар долоо хоногт 150 минутын 15 хичээл, 3 дугаар долоо хоногт 10 минутын 10 хичээл, 4 дүгээр долоо хоногт 10 минутын 10 хичээл, нийт 500 минутын 50 хичээлийг бэлтгэн зайны сургалтыг зохион байгуулсан. Теле хичээлийг нийслэлийн цэцэрлэгүүдийн 12 багш, БМДИ, БХ-ийн арга зүйч ажилтнуудын бүрэлдэхүүнтэй зохион байгуулан NTV телевизээр өглөө 10:00, орой 16:30 цагт 2 удаагийн давталттайгаар үзүүлж байна. Теле хичээлийг мөн тус телевизийн цахим сайт, боловсролын эрхтэй цахим сайтуудаар дамжуулан хүргэсэн байна.

Сургуулийн өмнөх боловсролын теле хичээлийн онцлог нь эцэг эх, насанд хүрэгчийн дэмжлэг, чиглүүлэгтэй хэрэгжих бөгөөд хичээлийн агуулгыг эцэг эх, асран хамгаалагчдад өгөх зөвлөмж, хүүхдийн хийх үйлийн уялдааг хангаж, эрүүл мэндээ хамгаалах дадал олгох, хөдөлгөөн, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, Монгол зан заншил, өв уламжлалыг эзэмшүүлэх зорилгыг хангахаар тодорхойлон хичээлийг бэлтгэн үзүүлсэн. Теле хичээлтэй холбоотой асуудлаар аймаг, нийслэлийн Боловсролын газруудад 2 удаа зөвлөмжийг БШУЯ-наас хүргүүлсэн хэмээн мэдээлжээ.

Бага, дунд боловсрол

6 БСШУС-ын сайдын 2020 оны «Зардал батлах тухай» А/283 дугаар тушаалын хавсралтаар

7 БСШУСЯ-ны 6 сарын үйл ажиллагааны мэдээ

Ерөнхий боловсролын сургуульд 2019-2020 оны хичээлийн жилд 6053 суралцагч суралцаж байгаагаас ердийн хэв шинжийн ерөнхий боловсролын сургуульд 4302 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өөрийн оршин суух газартаа хамт олонд түшиглэн хөгжүүлэх үзэл баримтлалыг дэмжиж, тухайн суралцагчид хувьсах зардлыг 3 дахин нэмэгдүүлэн, 10.8 тэрбум төгрөгийг сургалтын байгууллагуудад олгосон байна. Дээрх зардлаас ХБХ-ийн сурах орчин, тохирох хэрэглэгдэхүүнийг шийдвэрлэн ажиллаж байгаа.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах журам”⁸-д тухайн хүүхдийг оршин суугаа нутагт нь боловсролын үйлчилгээнд хамруулахыг тусгасан. Харин багшид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хуваарилан сургахад сургуулийн “Дэмжлэгийн баг” -ийн хамт олон дэмжлэг үзүүлж, хамтаар ажиллахаар заасан. 2019-2020 оны хичээлийн жилийн эхний улиралд 398 хөгжлийн бэрхшээлтэй сурагч ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллэсэн байна. БШУЯ-ны мэдээлснээр 640,499 сурагч ЕБС-д суралцдаг бөгөөд теле хичээлийн хамрагдалт 86-90% хэмээжээ.

“Телевизийн хичээлээ бүрэн ойлгохгүй байгаагаас хамаарч бидэнд хоцрогдол үүсч, эргэлзээ төрүүлсэн зүйлээ тодруулж асуух ямар ч харилцаа байхгүй учир сургуульдаа л хурдан буцаж явмаар байна. Эсвэл Засгийн Газрын зүгээс теле хичээлийн чанарыг сайжруулаад, илүү хүртээмжтэй ойлгомжтой болгоод өгвөл сайн даа. Тэгэхгүй бол ахлах ангийн сурагч учир их хоцрогдож, нөхөхөд хэцүү болох байх.”

*16 настай Ч (хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд)
Ковид залуусын амьдралд үзүүлсэн нөлөөлөл 2020*

Засгийн газрын 2012 оны “Журам батлах тухай” 185 дугаар тогтоолын дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсах зардлыг 3 дахин нэмэгдүүлэн олгож байна. Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймгийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын албан сургалтад хамрагдаж байгаа нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативын цалин, түүнд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 4 хувиар, бараа, үйлчилгээний бусад хувьсах зардлыг 3 хувиар тус тус нэмэгдүүлэн тооцох зохицуулалт үйлчилж байна.

2018-2019 оны хичээлийн жилд Насан туршийн боловсролын үндэсний төв болон аймаг, дүүргийн Насан туршийн боловсролын төв, сумын нэгжээс зохион байгуулсан бичиг үсгийн сургалтын 4 түвшинд нийт 2602 иргэн суралцсанаас хийдэд шавилж буй 191 лам хүүхэд хамрагдаж, 2019-2020 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрийн бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд нийт 157 лам хүүхэд суралцаж байна. Насан туршийн боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар телевизийн хичээл зохион байгууллаа. Бага, дунд ангийн монгол хэл, математик, иргэний ёс зүйн боловсрол, насанд хүрэгчдэд зориулсан хичээлээр

8 2019 оны БСШУС-ын сайдын А/292 дугаар тушаалаар батлагдсан

15 минут нийт 14 хичээл боловсруулан “Star” телевизээр түгээсэн. Энэ нь холимог бүлгийн сургалтын арга зүй ашиглан зайны хэлбэрээр олон нийтэд түгээсэн анхны хичээл байсан бөгөөд агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүний хувьд дүйцсэн хөтөлбөрийн суралцагч, үзэгчдийн сайшаал хүлээсэн үйл ажиллагаа боллоо.


Цэцэрлэг, ЕБС-ийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотойгоор Насан туршийн боловсролын үндэсний төвөөс дүүрэг, аймгийн Насан туршийн боловсролын төвүүд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран эрүүл мэнд, амьдрах ухаан, санхүү, мэдээллийн технологи, онцгой байдал зэрэг чиглэлээр теле хичээл боловсруулан “Стар” телевизээр нэвтрүүлж байна. Нийт хичээлийн тоо 43, цагийн хэмжээ 645 минут болж байна.

Цаашид ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, насан туршийн боловсрол, үндэсний цөөнхөд зориулсан хичээлийн бүх агуулгыг буюу 1, 2 дугаар улирлын хичээлүүдийг теле хичээл болгон бэлтгэж, эрсдэлт нөхцөл байдалд Монгол Улсын боловсролын салбарт хичээл, сургалтын үйл ажиллагааг теле болон цахим хичээл хэлбэрээр үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах ажлыг зохион байгуулсан.

Мэргэжил, Сургалт Үйлдвэрийн төв

МБС-ын тухай хуулийн 8.5, 8.6 дугаар заалт, ХНХ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А326 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, МБС-ын ҮМАЗТ-ийн дүрмийн 1.3, 1.4, 3.1.9 дүгээр заалтыг тус тус үндэслэн МБСҮМАЗТ-ийн даргын 2020 оны 05 дугаар сарын 05 ны өдрийн А/48, 2020 оны 5 дугаар сарын 12 ны өдрийн А/51 тоот тушаалаар батлагдсан удирдамж, хуваарийн дагуу Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын цахим сургалтын явц, агуулга, арга зүйн чиглэлээр зөвлөн туслах үйл ажиллагааг 2020 оны 05 дугаар сарын 11, 14-18, 29 ний өдрүүдэд Улаанбаатар хот, орон нутгийн нийт 32 МСҮТ, Политехник коллежийн 350 гаруй мэргэжлийн багш нарыг хамруулан зохион байгуулжээ. Боловсрол эвсэл 2020 оны 6 сарын 10-ны өдрийн 21 тоот албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам руу МСҮТ, коллежуудад ямар хэлбэрээр сургалтын үйл ажиллагааны явагдсан, талаар мэдээлэл өгөхийг хүсэхэд хариу ирүүлээгүй. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвөөс цахим сургалттай холбоотойгоор багш нарт 5 сарын 11, 14-18, 29-ны өдрүүдэд багш нарт зориулж хийсэн сургалтын үйл ажиллагааны тайлан болон 1 сарын 27-оос 3 сарын 30-ны өдрийн хугацаанд сургалтын төвүүдэд явуулсан судалгааг ирүүлсэн. Энэ мэдээллээс харвал хичээлийн жил бараг дуусч байхад багш нарт зориулж сургалт явуулсан бөгөөд үүнээс өмнө ямар удирдамжийн дагуу, ямар платформ ашиглан, яаж хичээл явуулж байсан нь тодорхойгүй хэвээр үлдсэн юм.


Мөн Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвөөс ирүүлсэн судалгааны тайлангаас үзэхэд 80 сургууль оролцсоны 43 сургууль буюу



53,7%-ны цахим хичээл явуулжээ. Энэхүү цахим хичээл явуулсан сургуулиудын хичээл хамрагдалт 53.9%-77.3%-тай байна. Тэгэхээр зөвхөн судалгаанд хамрагдсан 80 сургуульд суралцдаг 38.630 оюутнуудын 28.9%-41.5% нь цахим сургалтад хамрагдаж гэж харж болохоор байна.

Нийт орох цагийн 71% ийг цахим хичээлээр орсон бөгөөд нийт хамрагдвал зохих суралцагчдын 76,3% цахим сургалтад хамрагдсан бөгөөд нийт суралцагчдын 51% нь явцын үнэлгээнд хамрагдсан байна. Цахим хичээлийн 67,2% МБС-ын 2,5 жилтэй ангийн, 21,3% МС-ын 1 жилийн ангийн, 9% ТБС-ын 1,5 жилтэй ангийн, 2,5% ТБС-ын 3 жилтэй ангийн чадамжийн нэгж эзэлж байна⁹.

Хуваарийндагуу ажилласан арга зүйчид багш нэг бүрт зөвлөгөө өгсөн ба сургуулийн удирдлагад нэгдсэн зөвлөмжийг тайлан болгож хүргүүлсэн байна. Зөвлөн туслах



үйл ажиллагаанаас дүгнэж үзэхэд сургалтын байгууллага бүр өөрсдийн дотоод нөөцдөө тулгуурлан цахим хичээл, хэрэглэгдэхүүн байршуулах групп нээж байршуулан суралцагчдад хүргэн ажиллаж байна. Зөвлөн туслах үйл ажиллагаанд хамрагдсан багш

нар Moodle, google classroom, socrative.com, Exelearning.elp, Articulate, StoryLine, Camstudio, Powerpoint, Ocam, Adobe flash, Google form, Google Docs, Camtasia, photoshop гэсэн програм болон компьютер, бусад тоног төхөөрөмж, хэрэгсэл, гар утас ашиглан цахим хичээл, хэрэглэгдэхүүн бэлтгэсэн боловч дийлэнх нь Powerpoint ашиглан хийсэн цахим хэрэглэгдэхүүн байгаа ба видео бичлэг, цахим тест зэрэг нь цөөн тоотой ашиглагдаж байна. Ихэвчлэн Facebook групп, чат ашиглан суралцагчидтай харилцжээ.

Их, дээд сургуулиуд

БСШУС-ын сайдын “Их, дээд сургууль, коллежийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зарим зохицуулалт хийх тухай”¹⁰ тушаал гарч, тушаалыг Монголын их, дээд сургуулиудын консорциум, Хувийн их, дээд сургуулиудын холбоо болон их, дээд сургууль, коллежийн захирлуудад хүргэж, шуурхай зохион байгуулалтыг хангаж ажиллажээ.

Цахим сургалттай холбоотойгоор БСШУС-ын яамнаас оюутан залуучуудын сурч боловсрох эрх зөрчигдөхгүй байх журам, шийдвэрийг гаргаагүй бөгөөд их, дээд

⁹ МБСҮМАЗТ-ийн ирүүлсэн мэдээлэл

¹⁰ БСШУС-ын сайдын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/195 дугаар тушаал

сургуулиудад хяналт тавьж ажиллахгүй байна гэж МОНголын Оюутны Холбоо (МОХ) үзжээ. Тухайлбал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 13-р зөвлөмжийн дагуу төр нь хүн бүрт боловсрол олгохын тулд боловсрол нь хүн бүрт хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, цаг үетэйгээ зохицсон, хүрэлцээтэй байх ба «4А»-ийн зарчмийг баримтлах ёстой. Иймд Монголын оюутны холбооны зүгээс 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдөр 1а/013 тоот албан бичгээр БСШУСЯ-нд мэдэгдэж, шаардлага хүргүүлэхдээ цахим сургалт нь цахим сургалтанд шаардлагатай техник хангамж, интернет сүлжээгүй, хурд удаан, багтаамжгүй, давтан үзэх боломжгүй зэргээр хүртээмжгүй байсан бөгөөд сургалтын арга зүй, стандарт, агуулга тохиромжгүйгээс үүдэн чанаргүй; уян хатан бус, амьдралын бололцоо, боломжийг харгалзахгүй байх, орон нутаг, алслагдсан байдлыг тооцохгүй цаг хугацаагаар шахах зэргээр цаг үетэй зохицоогүй; оюутан бүрд цахим сургалтын гарын авлага, ном, товхимол, техник хэрэгсэл байхгүй учраас хүрэлцээгүй байна гэж үзээд зарим нэг шийдлүүдийг санал болгосон байна.

БСШУСЯ-ны Дээд боловсролын газраас 2020 оны 02 дугаар сард ИДСК-ийн цахим хичээлийн үйл явцтай танилцах ажлыг Боловсролын хүрээлэнгийн Дээд боловсролын сектортой хамтран зохион байгуулж, 9 сургуулийн үйл ажиллагаатай танилцах зэрэг ажлуудыг хийжээ.

ТОДОРХОЙ БҮЛГИЙН ХҮҮХЭД, ЗАЛУУСЫН БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРАГДСАН БАЙДАЛ

БСШУС-ын яамнаас өгсөн мэдээгээр теле хичээлд хамрагдалтын хувьд эхний 2 сар 81%-тай байсан бол дараагийн сараас 66% болон буурсан үзүүлэлттэй гарчээ. Хүүхдүүдийн 10-15% интернэтийн сүлжээгүй, хөдөөгийн алслагдмал газар амьдарч байна гэжээ. Салбар яамнаас боловсролын салбарын мэдээллийн сангаас хүүхдийн амьдралын нөхцөл байдлын судалгааг 4 үзүүлэлтээр авч үзэхэд амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд амьдардаг 8542, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхөд амьдардаг 1608, эцэг эх нь хоёулаа ажилгүй өрхөд амьдардаг 12774, нэн ядуу өрхөд амьдардаг 2227 хүүхэд гарсан байна. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 24 цагийн цэцэрлэгүүдэд суралцаж буй зорилтот бүлгийн хүүхдүүдийн нөхцөл байдлын судалгааг хийж үзэхэд 24 цагийн цэцэрлэгт 2716 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд үүнээс зорилтот бүлгийн 371 хүүхдийн 134 нь хагас өнчин, бүтэн өнчин 16, хоол хүнсээр дутмаг 236, өдрийн цагаар харах хүнгүй гэртээ үлддэг 123, эцэг эх, асран хамгаалагч нь үл хайхардаг 58, хамаатан болон айлд амьдардаг 42 хүүхэд тус тус байжээ.

Мөн БСШУСЯ-ны сайдын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/626 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүд БНЭУ-ын 3 дацанд шавилан сууж байгаа лам хүүхдийн суралцах орчин нөхцөл, эрүүл мэнд, эрх хамгаалал, монгол бичиг үсэг болон ерөнхий боловсролын асуудлаар судалгаа хийж, тайлан боловсруулан гаргасан байдаг.

Хичээл хааснаас хойш 2020 оны 2-5 дугаар саруудын дунджаар гаргасан боловсролын яамны судалгаанаас СӨБ-ын ба бага, дунд боловсролын суралцагчдын теле хичээлийн хамрагдалтын хувийг харахад улсын дундаж 74.7%, аймгийн дундаж 75%, сумын дундаж 69,5%-ийн ирцтэй байсан байна. Сэлэнгэ аймгийн төв 95.2 хувийн, сумд нь 87.75 хувийн ирцтэй буюу хамгийн өндөр, Баянхонгор аймгийн 54.5 хувийн ирцтэй буюу хамгийн доогуур ирцтэй байна. Улаанбаатар хотын 9 дүүргийн хувьд дунджаар 88.4 хувийн ирцтэй байсан байна. Улаанбаатар хотын хувьд төвийн дүүргүүд болох Баянгол - 93.5 хувь, Сүхбаатар-92 хувь, Хан-Уул-92.7 хувийн ирцтэй байсан бол бусад захын дүүргүүд болох Налайх дүүрэг 87.7 хувь, Сонгино хайрхан 86.5, Багахангай 84,4, Баянзүрх 83.2 хувийн ирцтэй байсан бөгөөд Чингэлтэй дүүрэг хамгийн доогуур буюу 82.3 хувийн ирцтэй байна. Цөөн сумтай, хүн амын нягтаршилтай буюу хотын шинжийг агуулсан аймгуудын нэг болох Орхон аймгийн хувьд ирц 93.5 ба 90,9 хувьтай байхад адил нөхцөлтэй Дархан-Уул аймагт ирц 55 хувь ба 49.6 байгаа нь анхаарал татна. Архангай, Дорнод, Өвөрхангай, Төв зэрэг аймгууд 82-85 хувийн ирцтэй байхад Булган аймаг 74 хувийн ирцтэй байх зэргээр ялгаатай байдал ажиглагдаж байна. Нийтлэгээр аймгийн төвийн сурагчдын ирц сумаас өндөр байгаа нь харагдаж байтал Говьсүмбэр аймгийн хувьд аймгийн ирц 71.1 хувь байхад сумдын ирц нь 82.8 хувь байна. Булган аймгийн хувьд аймгийн төв, сумд нь ялгаагүй 74 хувьтай байжээ.

Дээрхи мэдээллээс харахад салбарын яамны судалгаа мэдээллийн найдвартай, баталгаатай байдал сул, мэдээлэл цуглуулах арга зүй, аргачлалын хувьд дутмаг байгаа нь харагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд

Монголд хөгжлийн бэрхшээлтэй 11600 хүүхэд бүртгэлтэй байдаг. Боловсролын мэдээлэл удирдлагын системд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг 6 бэрхшээлийн төрлөөр бүртгэж байна. Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй 1,076 хүүхэд цэцэрлэгт, 6,053 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд тус тус суралцаж байна. 2-5 насны хөгжлийн бэрхшээлтэй 1,585 хүүхэд байгаа бөгөөд бүх хүүхдийн 67,8%, 6-18 насны хөгжлийн бэрхшээлтэй 8,209 хүүхдээс 6,053 буюу 73,7% ерөнхий боловсролын сургуульд хамрагдсан байна. Үүнээс 1,700 хүүхэд нь тусгай ЕБС-д сурч байна.

“Нээлттэй Нийгэм форум” ТББ болон “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо”-той хамтран судалгаа хийж үзэхэд боловсролын үйлчилгээ хамгийн их шүүмжлэл дагуулжээ.¹¹ Теле хичээлийн чанар, хүртээмж муу байгаа тул “боловсролын асуудал орхигдож байна”, “маш хүнд асуудал болж байна”, “сурлагын хоцрогдол үүсэж байна” гэж оролцогчид онцолжээ. Теле хичээл зааж байгаа багшийн хурдыг гүйцэхгүй тул ойлгохгүй байгаа тухай шүүмжлэл хамгийн

11 “КОВИД-19 БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ” Нөхцөл байдлын судалгаа, 2020 оны 4 ба 5 сар

олон байна. Сургууль, багш нь хүүхэд, эцэг эхтэй холбоо тасалдаж, эцэг эх нь санаачилга гаргахгүй бол ангийн багш асууж сурагладаггүй байдал нийтлэг байгаа ажээ. Тэр тусмаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тохирох хэрэглэгдэхүүн, нэмэлт дэмжлэгээр хангаж, эцэг, эхэд хүүхэдтэйгээ ажиллах мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч байхыг сургууль, багш нараас хүсэж байна. Хүүхэд хөгжүүлэх хичээлийн бус цагийн нэмэлт сургалт, заслын үйлчилгээ бүгд зогссон нь хүүхдийн ерөнхий хөгжилд сөргөөр нөлөөлөх вий гэсэн зовнил эцэг эхчүүдийн дунд өсжээ.

Сургуулийн насны 86 хүүхдээс 9 нь ТВ хичээлээр амжилттай суралцаж байна. 77 хүүхэд ТВ хичээлээр суралцаж чадахгүй байгаагаас 68 нь огт үзэхгүй, эсвэл үзсэн ч ойлгохгүй; 6 нь хааяа үздэг; 3 нь ТВ хичээлийг ашиглахгүй, тусгай сургуулийн багшаас ганцаарчилсан даалгавар авч суралцаж байна. ТВ-ээр хичээлийн хүртээмжийг хязгаарласан зохион байгуулалтын хоёр асуудал хөндөгджээ. Дохионы хэлний орчуулга нь ойлгомжгүй, хэт жижиг дэлгэцтэй тул харагдахгүй байгаа нь сонсголын бэрхшээлтэй сурагчдад томоохон саад болж байна. Нэг өрхийн сургуулийн насны хүүхдүүдийн хичээлийн хуваарь давхцаад, зарим нь хичээлээ “таслах” явдал гарч байна.

69 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нь мэргэжлийн ямар нэг дэмжлэггүй байна. 17 хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч нь ТВ хичээлтэй холбоотой зөвлөгөө авч байгаа бөгөөд 13 нь ангийн багшаас чат, утсаар долоо хоног бүр зөвлөгөө, нэмэлт даалгавар авч; 2 нь Насан туршийн боловсролын төв, 1 нь ТББ-ын мэргэжилтнээс асууж байгаа бол 1 хүн Сүлд ТВ-ээр гарч байгаа тусгай хэрэгцээт боловсролын хичээлийг үзэж байна.

80 хүн хүүхдийнхээ хичээл сурлагад хэр тусалж байгаагаа үнэлжээ. Үүнээс, 16 хүн хүүхдэдээ тусалж чадаж байгаа, 19 хүн чадахгүй байгаа, давхардсан тоогоор 50 хүн бусдаас дэмжлэг авч байгаа гэжээ. Бусад хүний дэмжлэг авч байгаа 50 хүн байгаагаас хүүхдийн багш (23 хүн), эцэг, эх өөрсдөө (22), ах, эгч (2), тэтгэвэрт гарсан багш эмээ (1), багш мэргэжилтэй нагац эгч (1), багш хийдэг ээжийн найз (1), Фейсбүүк дэх ээжүүдийн групп (1), ТББ (1) зэрэг эх сурвалжийг ашиглаж байна.

Эцэг эх, асран хамгаалагч нь өөрөө ажиллаж байгаа тохиолдолд ТВ хичээлийг хамт сууж үзэн тайлбарлах (туслах багшийн үүргээр оролцох), өөрөө эхлээд үзчихээд, дараа нь хүүхдэдээ заах (багшийг орлох), багшаас асууж байгаад хүүхдэдээ заах, эсвэл мэдэхгүй зүйл гарвал багшаас асуух (багштай хамтран ажиллах), мөн ТВ хичээлийг огт ашиглахгүй өөрсдөө тусгай хөтөлбөрөөр сургах зэргээр зохион байгуулж байна.

Судалгааны зарим дүнгээс

2019-2020 оны хичээлийн жилд насан туршийн боловсролын төвүүдээр дамжуулан боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтад нийт 6410 суралцагч хамрагдсаны 896 буюу 14% нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна. Нийт суралцагчдын 29 нь хэвтрийн, 80 нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байна. Аймаг, дүүргийн насан туршийн боловсролын төвөөр

дамжуулан хэвтрийн, хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг үсгийн болон бага, суурь боловсрол эзэмшүүлэх, бичиг үсгийн болон бага боловсрол эзэмшүүлэх үйлчилгээг хүргэж байна.¹²

“Зурагтаар хичээл үзэхээр зарим хичээлээ ойлгохгүй, тодруулж асуух боломжгүй байгаа нь надад хүндрэлтэй байдаг. Мөн хичээлийн цаг дэндүү богино учраас бичиж авч амжихгүйд хүрдэг. Надад бол дэлгэцээр хичээл үзсэнээс танхимд хичээл үзэх нь илүү ойлгомжтой байсан.”

16 настай Т

Ковид залуусын амьдралд судалгаа 2020 он

Үндэстний цөөнх

Баян-Өлгий аймаг 93 мянган хүн амтай, үүний 93 хувь казах үндэстэн, үлдсэн хувийг дөрвөд, урианхай, тува, халх ястангууд эзэлдэг олон үндэстний нутаг билээ. Иймд хос хэлээр заагдаж байгаа хичээлийн хүртээмжийн тухай судлалаа. Боловсролын яамнаас мэдээллэсэн мэдээгээр 75-80 өдрийн танхимын сургалтын агуулгыг теле болон цахим хичээлээр нөхөж байгаа бөгөөд 4773 цагийн 82355 теле хичээлийг бэлтгэж, монгол, казак, тува, дохионы хэлээр хүргэсэн байна.

Баян-Өлгий аймагт зохион байгуулсан теле хичээлийн нэгтгэл¹³ /2,3,4,5-р сар/

№	Теле хичээл	Төрөл	2 сар	3 сар	4 сар	5 сар	Нийт	Бүгд
1	Боловсруулж заасан хичээлийн тоо	Бага анги	45	60	105	85	295	396
2		Дунд анги	15	28	31	27	101	
3	Орчуулсан хичээлийн тоо	СӨБ	50	40	32		122	581
4		Бага анги	95	100	93	90	378	
5		Дунд анги	30	18	33		81	
Нийт			235	246	294	202	977	977

Баян-Өлгий аймагт нийт боловсруулж заасан теле хичээлийг цагаар авч үзвэл бага ангид 5900 цаг, дунд ангид 2020 цаг болох ба СӨБ 2440 цаг, бага ангид 7560 цаг, дунд ангид 1620 цагийн хичээлийг казак хэлээр орчуулан хүргэжээ.¹⁴

Малчин өрхийн хүүхдүүд

2020 оны 1 сарын 26-нд гарсан МУЗГ, УОК-ийн өмчийн бүх хэлбэрийн сургууль, цэцэрлэг ИДС, коллеж, хүүхэд харах төвийн үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр арга хэмжээ авах зөвлөмж 2020 оны 1 сарын 27-ны өдөр Боловсролын яамнаас гаргасан ба Теле хичээл зохион байгуулах, багш теле

¹² Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, 2020 оны хагас жил

¹³ Баян-Өлгий аймгийн боловсролын төв

¹⁴ Мөн тэндээс ирүүлсэн мэдээ

хичээлийг бататгах үйл ажиллагаа зохион байгуулах, малчдын хүүхдэд хүрэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулахаар тусгажээ.

2020 оны 05 дугаар сард малчин өрхийн хүүхдүүд хичээлээ үзэж чадаж байгаа эсэх талаар цахим асуулгад сошиал медиа анализ хийж үзэхэд нийт 186 хүн сэтгэгдлээ үлдээсний 67.2% нь ТВ огт үзэж чадахгүй байгаа, 7% нь үзэх боломжгүй байгаа, 6% аргалаад үзэж байгаа, 19.3% нь бусад байдлаар хариулжээ.

Өөрсдийн бодлоо илэрхийлсэн 186 хүний ТВ хичээлд хамагдаж чадахгүй байгаа саадуудын талаар сэтгэгдлийг ерөнхийлөн дараах 4 гол шалтгаанд хуваан үзсэн бөгөөд хүмүүсийн гаргаж байсан шийдлүүдийг мөн нэгтгэн орууллаа.

Нийт 186 хүн өөрийн санал сэтгэгдлээ илэрхийлснээс доорх байдлаар ерөнхийлөн ангилав.

№	Шалтгаан	Саадууд	Шийдэл
1	Технологитой холбоотой	Аккумулятор байхгүй, ТВ байхгүй, кабель байхгүй, интернэтгүй, датагүй, econtent зэрэг ухраах үйлчилгээ байхгүй.	ДиДиШ, Гэр интернэтээс дата авч үзэх,
2	Ахуй амьдралтай холбоотой	Мал төллөх, ямаа самнах цаг, отор нүүдэл гээд гэрийн ажил их, мал жилбэгүй төллөөд ажил их	Хичээлийг хүүхэд бүрт байгаа газарт нь цаасан хэлбэрээр хүргэж өгөх,
3	Байгаль, цаг уурын нөхцөлтэй холбоотой	Цас орж цаг агаар муу, нарны гэрэлгүй тул цэнэг байхгүй, салхи шуургатай үед ТВ антен тохиргоо алдагддаг, ажиллахгүй болдог, зудтай байгаа.	Хичээлээ орой 21.00-22.00 цагийн үед гаргавал малчдын хүүхэд үзэх боломжтой болно.
4	Шийдвэр гаргагч нартай холбоотой	Хичээлийн хуваарь малчдын амьдралын хэмнэлт тохиромжгүй, хичээлээ биш зааж байгаа багшийн царайг их гаргадаг, дэвших ангийн шалгалт авахгүй гэж эрт мэдээлсэн, ТВ станц эвдэрсэн	Нэг нь утсан дээрээ бичлэг хийгээд бусад хүүхдүүдэд үзүүлэх

“Манай гэр сумаасаа 60 км зайтай байдаг сүлжээ байхгүй тул долоо хоногт 1 л өдөр сумруугаа ороод интернетээр бүх хичээлээ хийж явуулдаг. Даалгавар хийхэд интернет маш удаан уншаад, компьютер байхгүй болохоор утаснаас орохоор маш асуудалтай дэлгэц нь маш жижиг, нүд өвдөөд нулимс гойжино, оройд утас үзвэл өглөө улаан нүдтэй байна.”

20 настай Л

Ковид 19 залуусын амьдралд судалгаа 2020 он

Нийгэм-эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхдүүд

Теле болон цахим сургалт өмнө байсан боловсролын тэгш бус байдлыг улам

гүнзгийрүүлэх хандлага ажиглаж байгаа юм. Жишээлбэл: телевизор, компьютер, утасгүй, болон интернетийн холболтгүй нөхцөлд суралцаж байгаа хүүхдүүд, сүлжээний хурд зэрэг технологийн хүртээмжгүй байдал, дата, интернетийн төлбөр зэрэг холбогдон гарах төлбөрүүдийг төлж дийлэхгүй, хичээл, даалгавраа хийх тайван орчин нөхцөлгүй, туслах багш, дэмжлэгийн ажилтангүй суралцах, эцэг эхийн оролцооны ялгаатай байдал (нийгэм-эдийн засгийн статустай холбоотой) тэгш бус байдлыг гүнзгийрүүлж байна хэмээн үзэж байна.

“Зогсоогоод эсвэл ухрааж үзэж чадахгүй учир бичиж авч ч чаддаггүй. Ойлгоогүй хичээлүүдээ эгч нараараа заалгуулдаг. Заримдаа тэгээд ч ойлгохгүй чигээрээ үлдэнэ. Утас, компьютер байхгүй болохоор хичээл номоо үзэж чаддаггүй.”

15 настай Г

Ковид 19 залуусын амьдралд судалгаа, 2020 он

2019 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 897,427 өрх бүртгэлтэй бөгөөд дунджаар 317,317 өрх буюу 35,3% нь интернэтэд холбогдсон байдаг боловч орон нутагт 72,789 өрх буюу 0.08% л интернэтэд холбогдсон үзүүлэлттэй байгаа юм.

Гэртээ компьютертэй өрхийн тоо 2015-2018¹⁵

Дүүрэг	Нийт өрхийн тоо				Компьютертэй өрхийн тоо			
	2015	2016	2017	2018	2015	2016	2017	2018
Нийслэлийн дүн	376 419	380 828	386 218	387 453	185 512	191 238	197 092	202 219
Багануур	8 462	8 604	8 514	8 569	3 174	2 280	2 616	2 763
Багахангай	1 193	1 187	1 196	1 272	383	393	433	285
Баянгол	57 981	58 241	58 756	59 536	42 945	43 760	44 378	44 600
Баянзүрх	93 097	93 713	94 971	95 714	46 770	49 577	49 293	50 711
Налайх	10 051	10 349	10 547	10 606	3 288	3 008	2 611	2 734
Сонгинохайрхан	82 895	84 924	86 212	84 236	30 386	30 731	33 401	35 635
Сүхбаатар	37 920	38 021	38 272	38 563	19 584	20 845	20 858	20 762
Хан-Уул	43 280	45 200	47 202	48 940	24 031	25 850	27 270	28 650
Чингэлтэй	41 540	40 589	40 548	40 017	14 951	14 794	16 232	16 079

Үндэсний статистикийн хорооны судалгаагаар Улаанбаатар хотод 2018 оны байдлаар 387,453 өрх байгаагийн 185,234 буюу 47.9% нь гэртээ компьютергүй байна.

15 Харилцаа холбооны зохицуулах хороо

“Цар тахлаас өмнө би өглөө хичээлдээ явж өдөр нь найзуудтайгаа тоглодог байсан бол одоо Нарантуул зах дээр тэрэгчин хийж амжиргаагаа залуулж байна. Цар тахлын хөл хорио эхэлж амны хаалт зүүж эхэлснээс хойш тэрэг түрж хол зам туулдаг надад ажиллахад маш хүндрэлтэй болсон.”

17 настай Э

Ковид 19 залуусын амьдралд судалгаа, 2020 он

Мөн бидэнд “Харилцаа холбооны зохицуулах хороо” интернэт идэвхитэй хэрэглэгчийн тоог 2019 оны байдлаар гаргаж өгсөн юм.

Интернэт идэвхтэй хэрэглэгчдийн тоо

№	Аймаг, дүүрэг	Хэрэглэгчийн тоо
1	Архангай	1320
2	Баян-Өлгий	2227
3	Баянхонгор	2303
4	Булган	1122
5	Говь-Алтай	1075
6	Говьсүмбэр	1840
7	Дархан-Уул	13914
8	Дорноговь	6135
9	Дорнод	5060
10	Дундговь	1081
11	Завхан	974
12	Орхон	15314
13	Өвөрхангай	1836
14	Өмнөговь	2679
15	Сүхбаатар	1204
16	Сэлэнгэ	5339
17	Төв	2103
18	Увс	1660
19	Ховд	2614
20	Хөвсгөл	1771
21	Хэнтий	1376
Аймгуудын дүн		72789
1	Баянзүрх	71714
2	Баянгол	54965
3	Сүхбаатар	26985
4	Чингэлтэй	13382
5	Сонгинохайрхан	27932
6	Хан-Уул	42302
7	Багануур	3449
8	Налайх	3513
9	Багахангай	252
Нийслэлийн дүн		244528
Нийт		317317

Зөвхөн Улаанбаатар хотод амьдардаг гэртээ компьютертой 202,219 өрхийн 165,336 буюу 81.7% нь интернэтэд холбогдсон байдаг байна. Гэртээ компьютергүй өрх, компьютертэй ч интернэтгүй өрхийн хүүхдүүд цахим хичээлд оролцох боломж хязгаарлагдмал харагдаж байгаа нь хөдөө алслагдсан газар амьдардаг өрхийн хувьд энэ хүртээмж эрс буурна гэдгийг анхаарах хэрэгтэй.

Интернэтэд холбогдсон өрхийн тоо

Дүүрэг	Компьютертэй өрхийн тоо, бүгд				Интернэтэд холбогдсон өрхийн тоо			
	2015	2016	2017	2018	2015	2016	2017	2018
Нийслэлийн дүн	185 512	191 238	197 092	202 219	133 963	144 349	155 662	165 336
Багануур	3 174	2 280	2 616	2 763	2 617	1 865	1 929	2 213
Багахангай	383	393	433	285	224	246	309	231
Баянгол	42 945	43 760	44 378	44 600	36 919	39 099	40 180	40 940
Баянзүрх	46 770	49 577	49 293	50 711	30 133	36 055	38 062	41 440
Налайх	3 288	3 008	2 611	2 734	2 353	1 984	1 996	2 084
Сонгинохайрхан	30 386	30 731	33 401	35 635	19 811	18 660	21 644	24 499
Сүхбаатар	19 584	20 845	20 858	20 762	15 587	16 402	17 369	17 945
Хан-Уул	24 031	25 850	27 270	28 650	19 489	20 616	23 325	25 272
Чингэлтэй	14 951	14 794	16 232	16 079	6 830	9 422	10 848	10 712

“Асрамжийн төвд маань ганцхан зурагт л байдаг. Гэтэл бид гучин хэдүүлээ амьдардаг. Мэдээж нас насны хүүхдүүдтэй учир хичээлийн цагууд ихэвчлэн давхцаж таардаг. Би хамгийн том нь болохоор дүү нарынхаа хичээлийг түрүүлж хийлгэчихээд дараа нь хийдэг. Гарсан хойно нь нөхөж үзэх боломжгүй. Үзэх боломжтой хичээлүүд нь хагас дутуу, ойлгоход ч бэрх тул хийсэн болоод л орхидог. Үзэх ёстой хичээлийг тухай бүрт нь тогтмол үзээгүйгээс болоод чанаргүй боловсрол эзэмших нөхцөл байдал бүрдэж байгаа.”

16 настай Ч

Ковид 19 залуусын амьдралд судалгаа, 2020 он

Зайны цахим сургалтын нөлөө

Зайны сургалт нь сургалтын үйл ажиллагааны чанар, гүйцэтгэл, эрх тэгш байдалд сорилт авчирч, өмнө байсан боловсролын тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэх эрсдэлтэй байна. Бага дунд боловсролын хувьд судлах ёстой агуулгын 50%-ийг олгосон, суралцагчдын хичээлд хамрагдалтын хувь дунджаар Сургуулийн өмнөх боловсролд 89,1%, Бага, дунд боловсролд 86-90% байсан (эхний 2 сард- 81%, дараагийн сард-66% болж буурсан) зэрэг нь анхаарал татна.

Мөн түүнчлэн дараах хүчин зүйлүүд суралцагчдын гүйцэтгэл, сурлагын амжилтад нөлөөлж байгаа нь эрсдлийг улам нэмэгдүүлж, тэгш бус байдлыг гүнзгийрүүлж байна гэж үзэж болохоор байна. Үүнд:

- Гэр бүлийн дэмжлэгийн ялгаатай байдал: нийгэм-эдийн засгийн статустай холбоотой эцэг эхийн боловсролд хандах хандлага, оролцооны ялгаатай байдал
- Багшийн дасан зохицох чадвар, багшлах ур чадвар, цахим ур чадварын ялгаатай байдал
- Сурагчид, эцэг эхчүүдийн нийгэм-сэтгэл зүйд үзүүлж буй сөрөг нөлөө
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хувьд туслах багш, дэмжлэгийн орчингүй суралцах

Сургуулийн өмнөх боловсролыг теле байдлаар олгох нь зохимжгүй тухай боловсрол судлаач, сэтгэл зүйчид зөвлөдөг. 2 хүртэлх насны хүүхдүүд өдөрт хамгийн ихдээ 15-20 минут өөрсдийнх нь сэтгэхүйд тохирсон телевизийн дүрс үзэж болох бөгөөд 3-5 насныхан 30 минутаас хэтрүүлж болохгүйг сануулж байна. Үүнээс хэтэрсэн тохиолдолд хүүхдэд идэвхгүй байдал, хэл ярианы хөгжлийн хоцрогдол, тайван бус байдал, нойрондоо муудах, анхаарал төвлөрөлтийн хоцрогдолд орох, гадны нөлөөнд амархан автах байдал зэрэг ажиглагддаг байна. Учир нь тэдний уураг тархи тэр дүрс дууны хэт хурдан хөдөлгөөнийг боловсруулж чаддаггүй.

Бага боловсролын түвшинд мөн л зайны сургалт тохиромжгүй, хүүхэд бие даах, анхаарал төвлөрөх, өөрийгөө захирах чадавх бүрдээгүй байдаг тул энэ арга замаар сурахад бэлэн бус байдаг байна.

Дунд, ахлах ангид нарийн төвөгтэй тохируулга бүхий бүтэц, оролцоо, багшлах арга зүй, суралцахуй, багшлахуйг дэмжих нөхцөл, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх, шаардлагатай дэд бүтцүүдэд холбогдох тэгш бус хүртээмж шаардагдах тул мөн л үр дүн муутай гэж үзэж байна. Хүүхдийн суралцах, хөгжих үйл явц харилцаанд суурилдаг тул теле хичээл нь нэг талын урсгалтай мэдээлэл өгч сургалтын үр дүн тааруу байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Анги дэвших шалгалт цуцлагдаж, сургалтын агуулгыг бүрэн эзэмшээгүй нь дараагийн ангид дэвшин сурахад нөлөөлөх эсэх, ер нь эдгээр хүүхдүүдийн дараагийн шатны боловсролын байдал, ажил, амьдралд ямар түвшинд нөлөөлөх вэ гэдэгт эцэг эхчүүд санаа зовж байна.

Сургууль эргэж нээгдэхэд теле болон бусад хэлбэрээр огт хамрагдаагүй, эсвэл бүрэн хамрагдаагүй хүүхдийг ялгаварлах, дарамтлах, цаашлаад сургууль завсардахад хүргэх, ариун цэврийн шаардлага биелүүлж чадаагүйгээс хичээлд ирэхгүй болох зэрэг эрсдлүүд байсаар байна гэж харж байна.

Онцгой байдлын үед үзүүлж байгаа дэмжлэгийн зохицуулалт, давхардалгүй байдал, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааг тухай бүрд шийдвэрлэж хэрэгжүүлж ажиллахгүй бол боловсролын салбарт авилгын эрсдэл үүсэж болзошгүй.

Боловсрол, эрүүл мэнд бол хоорондоо холбоотой хүний суурь эрхүүд тул эдгээр салбарууд нийтийн өмч/баялаг хэвээр байх, тогтолцоог сайжруулах, хямралын

үед үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэх чадавхтай байхад анхаарахгүй бол нийгмийн эмзэг бүлгүүдэд хүрч чадахгүй байх эрсдэл байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын нийт өрхийн 35,3% нь интернэтэд холбогдсон боловч орон нутагт энэ үзүүлэлт 0.08%-тай байдаг бөгөөд Улаанбаатар хотын 387,453 өрхийн 47.9% нь гэртээ компьютергүй байна. Гэртээ компьютертой өрхийн 81.7% нь интернэтэд холбогдсон байдаг байна. Гэртээ телевиз байхгүй, байсан ч кабель байхгүй, кабельтай ч ухрааж үзэх үйлчилгээгүй, компьютергүй, компьютертой ч интернэт байхгүй өрхийн хүүхдүүд зайны сургалт, хичээлээс хоцрох эрсдэлд оржээ. Салбарын яам болон бусад байгууллагуудын хийсэн судалгааны дүнгээс харахад боловсролын бүх шат түвшинд суралцагчдын 20 орчим хувь нь зайны сургалтад хамрагдаагүй дүр зурагтай байна.

Хичээл үзэх технологийн боломж бололцоо хангагдсан ч охидын хувьд гэр цэвэрлэх, дүүгээ харах, дүүгийнхээ хичээлийг хийлгэх, хөвгүүдийн хувьд гэр бүлийнхээ амьжиргааг залгуулахын тулд ажил хөдөлмөр эрхлэх болсон тул хичээл хийж амжихгүй сурагчид байгаа бөгөөд хөдөө амьдардаг малчин өрхийн хүүхдүүд-сурагчдын хувьд дээрх ажил дээр нэмэгдээд нүүдлийн мал аж ахуйн амьдралын хэв маягтай холбоотойгоор мал төллөх, мал хариулах, нүүдэл хийх зэрэгт туслан хичээл хийх завгүй байгаа нь харагдлаа. Мөн хөдөө амьдардаг малчин өрхийн хувьд байгаль цаг уураасаа хараат амьдралтай тул хүчтэй салхи, бороо зэрэг байгалийн үзэгдэл тохиолдоход зарим кабельтай айлуудын кабель салж, ТВ үзэх боломжгүй болох, цас их орсноос нарны зайгаа цэнэглэж чадахгүй болох зэргээр хичээлээ бүрэн үзэх боломжоор хангагдаагүй гэж үзэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байтугай хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдийн хувьд теле хичээл хэтэрхий хурдтай байна гэж ихэнх сурагчид шүүмжилж байсан. Дохионы орчуулгатай хичээл явуулсан нь дэвшилттэй ч дохионы хэлний орчуулга нь ойлгомжгүй, хэт жижиг дэлгэцтэй тул харагдахгүй байгаа нь сонсголын бэрхшээлтэй сурагчид теле хичээл үзэж чадаагүй, үзсэн ч ойлгоогүй өнгөрөх тохиолдол их байна, харааны бэрхшээлтэй болон бусад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд теле хичээлээс гадуур орхигдон үлдсэн байх магадлал өндөр. Мөн үндэсний цөөнхөд зориулж бэлтгэсэн хичээл байхгүй тул аймаг нь теле хичээлийг орчуулан хүргэж байсан ч бүх хичээлийг орчуулан хүргээгүй явдал нь анхнаасаа хүртээмж муутай байгаа теле хичээлийн хүртээмж, чанарыг улам бууруулах нөхцөл бүрдүүлсэн.

2020 оны эхнээс хичээл сургалтын үйл ажиллагааг зайны хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой УИХ, Засгийн газар, салбарын яам, харъяа байгууллагуудаас гаргасан тушаал шийдвэрүүдийг харахад нийгмийн ялгаатай бүлгүүдэд тулгардаг саад тотгоруудыг олж харах, сургалтын онцлог хэрэгцээг хангах чиглэлээр анхаарсан байна. Эдгээр шийдвэрүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг онцлон анхаарсан

байх ба малчдын хүүхдүүд, үндэстний цөөнх хүүхдүүд болон охидын асуудлыг цөөхөн тохиолдолд дурдсан байна.

Салбарын яамны зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулах бодлогын чиглэлийг тууштай барьж, чухал шийдвэрүүдийг гаргаж ирсэн нь сайшаалтай байгаа ч цахим болон теле хичээл явагдах үед тусгайлсан дэмжлэг, зохион байгуулалт хийж чадсангүй.

Малчдын хүүхдүүд ба үндэстний цөөнх хүүхдүүдийн сурч боловсрох тэгш хүрээмжийг хангах асуудлыг орон нутагт хариуцуулан орхисон байдалтай байв. Хамгийн их нэрвэгдсэн бүлэг болох амьжиргааны түвшин доогуур өрхийн нийгэм-эдийн засгийн статус доогуур хүүхдүүдийн асуудал бүрэн орхигдсон байна гэж үзэж болохоор байна.

Мөн теле ба цахим хичээлд хамрагдалтын байдалд тавих хяналт орон нутгаар ялгаатай, яамны түвшинд хичээл-сургалтын үйл ажиллагаанд тоо мэдээлэл цуглуулах, хяналт үнэлгээ хийх байдал сул, тэгш хамруулах чиглэлээр оновчтой шийдэл одоогоор хэрэгжүүлээгүй байна.

Эмзэг болон маргинал бүлгүүдэд тохирох технологи болон арга хэрэгслийг үнэ төлбөргүй, хүртээмжтэйгээр ашиглан зайнаас сурах боломжийг олгож, орон нутагт суурилсан сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, хамгийн эмзэг, гадуурхагдсан бүлгийнхэнд нөхцөл байдалдаа тохирсон чанартай боловсрол, сургалтанд хамрагдах боломжийг олгох чиглэлээр Засгийн Газраас илүү их хүчин чармайлт гаардаж байна. Халдварт өвчний эрсдэлгүй гэж үзсэн алслагдмал орон нутгийн зарим цэцэрдэг сургуулийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадсангүй.

Мөн түүнчлэн гэрээр суралцах үед гэр бүлийн дэмжлэг, оролцооны ялгаатай байдлыг нөхөх, багшийн цахим болон бусад багшлах ур чадварын ялгаатай байдлыг арилгах, сурагчид, эцэг эхчүүдийн нийгэм-сэтгэл зүйд үзүүлж буй нөлөөг бууруулах, ялангуяа өсвөр насны хүүхдүүдийн харилцаа-нийгэмшлийн эрэлт хэрэгцээг хангах зэрэг бусад бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээгүй нь суралцагчдын хамрагдалт, гүйцэтгэл, сурлагын амжилтад нөлөөлж, тэгш бус байдлыг гүнзгийрүүлж байна гэж дүгнэж болохоор байна.

Сургууль, цэцэрлэг хаасан нь багш, эцэг эх, сурагч нэг түвшинд хамтран ажиллах шаардлага тулгарч, хичээл хийх, амжилттай суралцах, шалгалт өгөх, төгсөх зэрэг асуудалд нэгэн зэрэг санаа зовсон, бараг өдөр тутамд хоорондоо харилцаа холбоо барихад хүргэсэн бөгөөд бүх талууд хангалттай дэмжлэггүй, шаардлагатай нөөцгүй, бэлтгэлгүй, бүгд туршиж үзэж байгаа, байнгын хяналт, шалгалтгүй суралцах, багшлах буюу бүгд бие даасан байдалтай боловсрол сургалтын үйл ажиллагааг үргэлжлүүлсэн гэж үзэж байна. Гэтэл боловсролын салбарт ажилладаг талуудад төдийгүй бусад оролцогч талуудад хандсан зөвлөмж, чиглэл, дэмжлэг, үйл ажиллагаа дутмаг байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Эмзэе бүлгийн хүүхдүүдэд тулгаарч байгаа гол асуудлуудыг түүвэрлэв

Шалтгаан	Үр дагавар	Тулгарч байгаа асуудал	Шийдэл	Саад	Бусад
Сургууль, цэцэрлэг хөл хорионд орж хичээллэхгүй болсон,	Ядуурал Түлшний хомсдол, Хоолны хүнсний хомсдол	Сургуулийнхаа хоолоор өдрийг өнгөрөөдөг байсан хүүхдүүд хоолгүй өлсөж байна	Хүүхэд бүрийн суралцах ялгаатай хэрэгцээн дээр суурилсан Оновчтой зөв бодлого журам хэрэгтэй	Ялгаварлан гадуурхах үзэл ихсэж байна Буруу ташаа ойлголт жишээ нь ядуусыг бэлэнчлэх сэтгэлгээнд сургалаа гэх мэт	Гамшгийн үед хоол өгөх тайван цагт эцэг эхийг нь ажлын байраар хангах, архины хамаарлыг эмчлүүлэх, Анхан шатны хороодыг өргөтгөж тэнд ажиллах боловсрон хүчнүүдийг тогтмол сургалтад хамруулах,
Сүмийн үйл ажиллагааг зогсоосон	Хүүхдүүд өлсөж даарч байна	Сүмээс хоол иддэг хүүхдүүд хоолгүй болсон	Захын хорооллын эмзэг бүлгийн хүүхдүүдийг төрөөс дэмжих хэрэгтэй	Хороод нь намд хуваагдаад сонгуульд ашигтай иргэдээ дэмждэг	Хөдөө малчид өвлийн идшээ бэлтгэхдээ хүүхдүүдээ олон сараар гэртээ байлгана гэж тооцоолоогүй гэр бүлүүдэд хоол хүнс, эдийн засаг нийгмийн асуудлууд тулгарч байна,
Зарим ААН-үүдийн үйл ажиллагаа зогссон		Сургууль, цэцэрлэгтээ явж архидалттай ахуйгаас түр холддог байсан ч боломжгүй болсон	ЕБС цэцэрлэгийн хоолны мөнгө, дотуур байрны мөнгө зэрэг хэмнэгдэж байгааг энэ бүлгийнхэнд зориулах	Хүүхэд хамгааллын хамтарсан багийг Зөвхөн хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцуулахгүй, хүүхэд хөгжлийн эрх зөрчигдсөн тохиолдлуудад ажиллаж холбогдох	Нийгэм эдийн засгийн статус доогуур өрхүүдэд ихэнхдээ хүүхэд, хөгшид, өрх толгойлсон хүмүүс, халамжийн хүмүүс байдаг тиймээс түлээ, нүүрсний сав боодолд анхаарч гэр хүртэлээ зөөвөрлөхөд амар болгох хэрэгтэй
Хүмүүс хөл хорионд орсон	Архидалт нэмэгдсэн Гэр бүлийн хүчирхийлэл өссөн	Хичээлд суух хугацаандаа л дулаан газар байдаг байсан даарч байгаа Хогийн цэг дээр очдог хүүхдүүд нэмэгдэж байна Хүүхдүүд хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй	Архины хамааралтай эцэг эх, асран хамгаалагчдыг хөтөлбөрт хамруулах, 5С хөтөлбөр зэрэг цогт арга хэмжээ авах	Төрийн байгууллагуудад зуучилдаг шинэ заалтыг ХХХБагийн журамд оруулах	

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ БА КОВИД 19

(Сэдэвчилсэн мониторингийн тайлан)

“Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний эвсэл 2020 оны 02 сараас дэлхий нийтэд тархсан “Ковид 19” цар тахал боловсролд хэрхэн нөлөөлсөн, ялангуяа улсын хэмжээнд хүүхэд хамгааллын талаар ямар арга хэмжээ авч байсан, боломжууд ямар байсан ба цаашид авах арга хэмжээнд тусгуулах саналаа сонгосон газар нутаг (Багануур, Налайх, Завхан аймаг)-т явуулсан судалгаа, Улаанбаатар дахь зарим олон улсын болон үндэсний төрийн бус байгууллагуудаас авсан арга хэмжээний тайлан мэдээлэл дээр тулгуурлан танилцуулж байна.

Ковид 19 цар тахлын улмаас сургууль цэцэрлэгийг түр хааснаас үүдэн хүүхэд гэртээ хараа хяналтгүй үлдэх, хүүхэд асрах, харах үйлчилгээ байхгүй, гэртээ боловсролын үйлчилгээнд хамрагдах үед туслах, хяналт тавих дэмжлэггүй, гэр бүлийн таагүй орчинд олон цагаар байх, хоол хүнсний үйлчилгээнээс тасрах, дунд, ахлах ангийн хөвгүүд хөдөлмөр эрхлэх зэрэг олон асуудлууд зэрэгцэн үүссэн юм. Мөн урт хугацаагаар хилийн хориг тавих, орон нутгийн хөдөлгөөнийг хязгаарлах, зарим үйлчилгээний газруудыг хаасан зэргээс үүдэн иргэдийн орлого буурах, үүнээс үүдсэн сэтгэл зүйн хямралд өртөх, гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэх, архи дан согтуурах явдал түгээмэл болох зэрэг хүүхдийн эрх хамгаалалд сөрөг үр дагавруудыг олж харахыг хичээлээ.

Ковид 19 халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотойгоор Ковид 19 халдварын хүүхдүүдийн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөллийг судлах хүрээнд дараах зорилгыг тавьсан. Үүнд:

1. Ковидын үеийн боловсрол олгох үйл явцыг баримтжуулах
2. Боловсролд үзүүлсэн шууд үр нөлөөг судлан тогтоох
3. Боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа сэргэх, эсвэл дахин хямралт нөхцөл бий болоход зохих бодлого, хөтөлбөр, дэмжлэг гаргахад нөлөөлөх зөвлөмж боловсруулах

Үндсэндээ 2019-2020 оны хичээлийн жилд 4 сар танхимаар, үлдсэн бүх хугацаанд хичээлийг зайн сургалтаар үзэж байгаа юм. Иймд танхимаар хичээл ороогүйтэй холбоотой хүүхэд хамгааллын ямар асуудлууд тулгамдаж байгаа талаар судаллаа.

Мониторинг хийх хүрээ:

- Гарсан тушаал шийдвэр
- Боловсролын оролцогч талуудад өгсөн удирдамж, чиглэл
- Зохицуулалт, хэрэгжилтийн байдал
- Тулгамдсан асуудлууд/сорилтууд
- Боломжууд
- Цаашид авах ёстой арга хэмжээний зөвлөмж

Мөн хүүхдийн хоол тэжээлийн хүрэлцээ, эрүүл мэндийн нөхцөл байдал, Ковид-19 цар тахлын үе дэх хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн нөхцөл байдал, аюулгүй байдал зэрэг хүүхэд хамгааллын асуудлуудад анхаарсан болно.

Сэдэвчилсэн багийн гишүүд дараах бүлгийн хүүхдүүд орхигдох магадлалтай хэмээн үзэж, мэдээлэл цуглуулах явцдаа анхаарсан болно

НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ (2020 оны 1 сараас 9 сар)

Дэлхий даяар Ковид - 19 цар тахлын тархалтыг зогсоох зорилгоор нийтийн эрүүл мэндийн төлөө авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нэг болох сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосноос үүдэн дэлхий даяар боловсролын тогтолцоонд урьд өмнө байгаагүй их сорилт бэрхшээл тулгарсан билээ. БНХАУ-ын Ухань хот Ковид-19 цар тахлын голомт болсноор иргэдийн эрүүл мэнд, нийтийн сайн сайхныг хамгаалах зорилгоор 1 сарын 24-ны өдрийн Улсын Онцгой Комиссын хурлын 1 дүгээр тогтоолоор 2020 оны 1-р сарын 27-ны өдрөөс сургууль, цэцэрлэгийг түр хугацаагаар хааснаас эхлэн коронавирусын нөхцөл байдалтай холбоотой албан ёсны шийдвэр, төрийн бодлого хэрэгжиж эхэлсэн билээ.

Улс орны хувьд 2020 оны эхний 5 сард гадаад худалдааны нийт бараа эргэлт 3998.7 тэрбум долларт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 28.3 хувиар буюу 1579.7 сая доллараар буурчээ¹. 2020 онд Анхан шатны шүүхэд гарсан гэр бүлийн хүчирхийллийн хэрэг 2019 оны 1-р улиралтай харьцуулахад 42 хэргээр буюу 87.5% -иар өссөн². Мөн 2020 оны 3 сарын 20-ны байдлаар 6000 орчим ажлын байрны тоо буурсан³ бөгөөд 4-р сард “Ажилгүйдлийн даатгалын сан”-гаас 7.5 мянган хүний ажилгүйдлийн даатгалын тэтгэмжид 17.0 тэрбум төгрөг зарцуулсан⁴ байна. Албан бус салбарт ажиллагсдын ихэнх нь хөл хорионы улмаас орлогогүй болж, сургууль хаагдсаны улмаас дижитал технологид холбогдоогүй алслагдмал нутагт амьдарч буй залуус, хүүхдүүд боловсролын системийн цахим болон теле хичээлээс хоцорлоо. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд маш бага төсөвтэйн дээр үйл ажиллагаа нь хаагдсан, теле хичээл явагдаагүй, цахимаар боловсрол олгосон ч нэмэлт дата худалдан авах шаардлагатай учир

1 <https://www.customs.gov.mn/statistics/>, Гаалийн Ерөнхий газар

2 <https://ikon.mn/n/1uzv>, 2020 оны 4 сарын 22-ны мэдэгдэл, Шүүхийн Ерөнхий Зөвлөл

3 Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим, “Ковид 19: Бизнес дэх нөлөөллийн судалгаануудын нэгдсэн тайлан”, 2020 он

4 <http://www.ndaatgal.mn/v1/view/1412>, Нийгмийн Даатгалын Ерөнхий газар

тэнд суралцдаг тодорхой бүлгийн залуус үргэлжлүүлэн суралцах боломжгүй болж боловсролоос хоцорсон. Мөн гадагшаа гарах хөдөлгөөнийг хязгаарласны улмаас зай талбай багатай гэртээ бүгэж, нийгэмших, үе тэнгийхэнтэйгээ харилцаж чадахгүй болсноор сэтгэл зүйн дарамт, айдас мэдэрч, тэдний нийгэм-сэтгэл зүйн хувьд анхаарах шаардлагатай нөхцөл байдал үүссэн. Дэлхийн банк, Үндэсний Статистикийн Хороо хамтран “Коронавирусын нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа”-г хийжээ. Тус судалгааг 5 дугаар сарын 22-ноос 29-ны өдрүүдэд эхний шат болгож хийсэн байна.

Судалгаанаас өрхийн хоол тэжээлтэй хамааралтай хэсгийг түүн үзвэл,

- 2020 оны 1 дүгээр сарын 27-ноос хойш хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 16 хувь нь ямар нэгэн орлого олоогүй, 73 хувь нь бизнесийн орлого буурсан, малчин болон газар тариалан эрхлэгч өрхүүдийн 70 хувь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орлого буурсан,
- Нийт өрхийн 64 хувь нь хүнсний гол нэрийн барааны үнэ өссөн гэж хариулжээ.
- Ядуу дөрвөн өрх тутмын нэг нь (23 хувь) ирэх 7 хоногийнхоо хоол, хүнсний хангалттай байдалд санаа зовж байгаагаа илэрхийлжээ.

Коронавируст цар тахлын үед эмэгтэйчүүдэд гэр бүлийн амьжиргааг залгуулах, хоол хүнсээ зохицуулах, гэр ахуйн ажил, эрүүл мэндийн үүрэг хариуцлагаа биелүүлэхийн зэрэгцээ хүүхдүүдийнхээ теле болон цахим хичээлийг хийлгэх, хяналт тавих давхар ачаалал нэмэгдэж байна. Нийгмийн хамгааллын тор нь эмэгтэйчүүдэд - бэлэн мөнгө шилжүүлэх, хоолны тусламж өгөх болон ажлын байрыг нь хамгаалах зэрэг бусад арга хэмжээ авч тасралтгүй сурах байдлыг хангах зайлшгүй чухал зүйлсээр хангах хэрэгтэй байна⁵. Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид вирус болон түүний хор хөнөөлийн түргэн өөрчлөгдөж байгаа нөхцөлийн талаар мэдлэг ойлголттой байж, хурдан өөрчлөгдөж байгаа, урт хугацааны үр дагавартай нөхцөл байдлыг ганц нэгээрээ болон хамтаар даван туулах, дасан зохицох чадварт суралцах шаардлагатай цаг үе ирлээ.

Коронавируст цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах болон хүүхэд хамгааллын чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг

Монгол улсын Төр засгаас Коронавируст халдвар /КОВИД-19/ - ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм эдийн засагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан хууль, тогтоол шийдвэрүүд ба тэдгээрт хүүхэд хамгааллын талаар онцгойлон заасан байдаг. Тухайлбал,

- Коронавируст халдвар /ковид 19/ - ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм эдийн засагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах

5 ASPBAE (Суурь болон Насанд хүрэгсдийн төлөөх Ази, Өмнөд Номхон далайн нийгэмлэг) Байр суурийн баримт бичиг, 2020

тухай⁶

- Коронавирус халдварын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай⁷
- Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр⁸

Харин Монгол улсын “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн зорилтод “... хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан байдаг хэдий ч нийтийг хамарсан аюул эрсдэл үер, зуд, цар тахлын нөхцөлд хүүхэд хэрхэн яаж хамгаалагдах талаар тодорхой заагдаагүй байна.

Улсын Онцгой Комиссын 1 сарын 27-ны өдрийн шийдвэрээ сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг хаах чиглэлийг БСШУЯ-ны сайдад өгсөн бөгөөд 3 сарын 2 хүртэл хаах шийдвэр гаргасан байдаг. Энэ хугацааг үе шаттайгаар сунгаж 2019-2020 оны хичээлийн жилийг дуустал үргэлжлүүлсэн бөгөөд боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа зогссоноор насанд хүрэгчдийн хараа хяналт суларч, гэртээ хараа хяналтгүй байсан хүүхдүүд эрсдэлд орсон гэдгийг мониторингийн дараа дараагийн хэсгээс харж болох юм.

Шинэ төрлийн коронавирүсийн тархалттай холбоотой цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг түр зогсоосноос хүүхдийг гэр бүлийн орчинд хараа хяналттай байлгах, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тусламж, үйлчилгээ шаардлагатай хүүхдэд цаг алдалгүй хүргэх, шаардлагатай амин дэмийн тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан удирдамжийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 5/938 албан тоотоор хүргүүлжээ.⁹

БСШУС-ын яам, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран “Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг 24 цагийн цэцэрлэгийн 1700 хүүхдийн гэр бүлийн нөхцөл байдлын түргэвчилсэн үнэлгээ” хийсэн бөгөөд үнэлгээний дүнд судалгаанд хамрагдсан 2-5 насны нийт хүүхдийн 17.1 хувь нь хоол тэжээлийн, 14.2 хувь нь хамгааллын, 25.8 хувь нь аюулгүй байдлын дунд буюу өндөр эрсдэлтэй байна. Хүүхэд хамгааллын өндөр эрсдэлд буй, хамгаалал шаардлагатай 43 хүүхдийн судалгааг СӨБГ-ын даргын 2020.03.06-ны өдрийн 5/1325 албан тоотоор ГБХЗГ-т хүргүүллээ. Тус үнэлгээний тайланд үндэслэн нийслэлийн 24 цагийн болон захын дүүргийн цэцэрлэгүүдийн зорилтот бүлгийн 1150 хүүхэд, тэдний гэр бүлд коронавирүсээс

6 Монгол Улсын Их Хурлын 2020.04.29 өдөр

7 Засгийн газрын тогтоол Дугаар 167, 2020.05.06.

8 Монгол улсын Их хурлын 2020 оны 24-р тогтоолын хавсралт. 2020.08.28.

9 БСШУСЯ-ны үйл ажиллагааны 2 сарын мэдээ, 2020 он,

хамгаалах “Цэвэр гар” аяныг БСШУС-ын яам, НҮБ-ын Хүүхдийн сан, Швейцарын хөгжлийн агентлаг, Солонгосын Хүүхдийн сан, Пеопл Ин Нийд ТББ хамтран зохион байгуулж, дэмжлэг үзүүлжээ.¹⁰

НҮБ-ын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг ивээх сантай хамтран 2020-2021 оны хичээлийн жилд ЕБС-д шинээр элсэн суралцах хүүхдийн бэлтгэлийг хангах ажлыг гэр бүлийн орчинд эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр явуулахад зориулсан “Та хүүхдэдээ сургуульд орохын өмнө хэрхэн туслах вэ?” гарын авлагыг 80470 хувь хэвлүүлжээ. Гарын авлагыг аймаг, нийслэлийн БСУГ-аар дамжуулан эцэг эх, асран хамгаалагчдад хүргэх, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх талаарх зөвлөмжийг хүргүүлсэн байна.¹¹

Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогыг БСШУС-ын сайдын 2020 оны 5 сарын 29-ны өдрийн А/194 тушаалаар баталсан байна. Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжийг боловсруулах ажлын удирдамжийг СӨБГ-ын дарга 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлан гаргалаа. Зөвлөмжийг багш нар өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлснээр цэцэрлэгийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар сайжирч, багш, эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс багш хүүхэдтэй зүй бус харилцах хүүхдийн эрхийн зөрчлийг багасгах ач холбогдолтой юм.

ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ, ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Энэхүү сэдэвчилсэн мониторингийн чанарын мэдээллийг Налайх, Багануур дүүрэг болон хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудаас цуглуулсан бөгөөд тоон мэдээллийг бусад байгууллагын хийсэн судалгаанаас ишлэлээ.

Дэлхийн банк, Үндэсний Статистикийн Хорооны судалгаагаар өрхийн хүнсний баталгаат байдлын талаар, “2020 оны 2, 3 дугаар сарын хүнсний бүтээгдэхүүний үнийн огцом өсөлт нь ядуу дөрвөн өрх тутмын гуравт сөргөөр нөлөөлжээ” гэсэн дүгнэлт гарчээ. Тэдний,

- 47 хувь нь хоол хүнс хүрэлцэхгүй гэж санаа зовсон,
- 40 хувь нь эрүүл, шим тэжээлтэй хоол хүнс идэх боломжгүй үе байсан,
- 42 хувь нь цөөн хэдхэн нэр төрлийн хоол хүнс хэрэглэсэн,
- 28 хувь нь хоол идэж чадахгүй өнгөрөөсөн,
- 23 хувь нь бага хоол идсэн байна гэж хариулсан байна.

Өрхүүдийн хүндрэл бэрхшээлийг даван туулж буй байдал нь,

1. Хотын өрхүүд хүнс болон хүнсний бус хэрэглээгээ багасгах хандлагатай,
2. Харин хөдөөгийн өрхүүд зээл авах, мөн гэр бүл, найз нөхдийнхөө

10 БСШУСЯ-ны үйл ажиллагааны 3 сарын мэдээ, 2020 он,

11 БСШУСЯ-ны Үйл ажиллагааны 4 дүгээр сарын мэдээ

тусламжид найдсан хандлагатай байна хэмээн судалгааны үр дүнгээр гарсан.

Мөн Боловсрол эвслийн 4-6 сард хийсэн Үйл ажиллагаанд суурилсан залуусын судалгаанд¹² оролцсон маргинал бүлгийн залуус "... Өдөрт хоёр удаа хоол иддэг байсан бол талх масло өдөртөө идээд оройдоо нэг удаа хоол хийж идэж байгаа... Хүнсний талон манай өрхийн санхүүд маш их дэмжлэг болж байна.", "Хөдөлгөөн хомс учраас жингээ үзэх болгонд л нэмэгдсэн байдаг. Гэхдээ биеийн жин нэмэгдэж байгаа ч хоолноосоо хангалттай хэмжээгээр шим тэжээл авч чадахгүй байгаа. Би асрамжийн газар амьдардаг бөгөөд бидний хоолны мөнгөөс илүүчлэн ариутгалын бодис, маск зэргийг авдаг болсноор хоолны орц багассан." зэргээр хариулснаас анхаарал татаж байна.

Налайх дүүргийн Гэр Бүл Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн хэлтэсээс авсан мэдээлэлд "Налайх дүүргийн гамшгийн үеийн гэр бүлийн эрсдлийг үнэлэх түргэвчилсэн үнэлгээ хийсэн бөгөөд 10880 өрх судалгаанд хамрагдсан байна. Үнэлгээгээр хоол хүнс тэжээлийн дутагдалтай 10 өрх айлыг илрүүлжээ. Мөн ярилцлагын судалгаанд оролцогч хэлэхдээ,

"Бид сургууль гэдэг ухагдахууныг ойлгохдоо очоод хичээл хийдэг газар гэж явцуу хүрээнд ойлгодог байсан бол корона вирусын халдвар гарснаар сургуулийг өөр олон үүрэг гүйцэтгэдэг газар байсан гэдгийг ойлгож эхэлж байна. Сургууль хүүхдэд шаардлагатай хоол тэжээлээр хангадаг газар байж, найз нөхөд, багш нартайгаа харилцах сэтгэл зүйн хэрэгцээг нь хангадаг газар байж, гэр бүлийн хүчирхийллээс ангид тайван байх, хүйтэн гэрээс дайжин дулаан байх боломжоор хангадаг газар байжээ гэдэг нь сургууль хаагдсан хэдэн сард тодорхой харагдсан." гэв.

Налайх Дүүргийн Эрүүл Мэндийн Нэгдэлийн зарим удирдлага, бүх өрхийн эмнэлгүүдийн дарга, нийгмийн ажилтан, эмч нартай уулзаж ярилцан 2020 гарсаар коронавирус цар тахлын хорио цээрийн үед боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоосноор хүүхдийн эрүүл мэнд, хоол хүнсний дутагдал, жингийн бууралт, өвчлөлийн талаар ямар түвшинд байв гэдгийг тандсан. Ярилцлагын үеэр 7-р хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Их эмч Б.Баатарсайхан, Их эмч Х.Цолмонжаргал нар дараах асуудлыг хөндөж байв.

12 "Ковид 19 цар тахал тодорхой бүлгийн залууст хэрхэн нөлөөлсөн бэ?" Үйл ажиллагаанд суурилсан залуусын судалгаа, Бүх нийт боловсролын төлөө Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2020 он

Манай хороонд карантины үед жилийн жилд. томуугийн өвчлөл өндөр байдаг байсан. Гэтэл 1-р улиралд буурсан. 2019 онд 176 байсан, 2020 оны 5 сард 130 болж буурсан үзүүлэлттэй. Халдварт өвчин 2019 онд 15 байсан бол 2020 онд 8 болсон байх жишээтэй. Гэхдээ нөгөө талаар энэ үеэр ядуурал, ажилгүйдэл ихэсч дийлдэхгүй үр дагавар гарч байна. Хүүхдүүд л их хохирч байна. Чанаргүй, тэжээл муутай хоол хүнс идэж дархлаа суларч, эцэг эхийн архидалт, хоосон хонох, халдварт өвчинд нэрвэгдэх хандлага, халууны улиралд нэмэгдэх шинжтэй байна. Жишээ нь, 0-5 насны хүүхдийн 96.5% нь одоогоор хэвийн өсч байгаа үзүүлэлт байгаа ч 4.5% нь суурь өвчлөлтэй, туранхай, рахиттай гэх мэт. Хүүхдүүд гадуур хараа хяналтгүй тоглодог, тэнэдэг учраас хөл гараа хугалах, дугуйнаас унах бэртэх зэрэг мэдээ их байна. Бүгдэд нь үйлчилгээ үзүүлдэг.

Мөн Налайх дүүргийн 4-р хороонд байрлалтай “Суварга-Налайх” ӨЭМТөвийн дарга ерөнхий эмч Б.Динара, нийгмийн ажилтан Номиншагай нартай уулзаж мэдээлэл авахад,

Коронавирусийн хорио цээр олон сараар /өвөл, хавар дамжсан/ хязгаарлагдсан нь нэг талаар сайн байв. Учир нь хүүхдийн томуу, томуу төст өвчний үзүүлэлт өмнөх жилтэй харьцуулахад 2 дахин багассан, харин суурь өвчлөл хэвээрээ, хүүхдүүдийн дархлаа суларсан. Энэ нь эцэг эхийн хараа хяналт сул, архидалт 2 дахин нэмэгдсэн, гэр бүлээрээ архичин өрхийн тоо нэмэгдсэн зэрэг шалтгаантай. Мөн эдийн засгийн хувьд жижиг дунд үйлдвэрлэл болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс ажилгүй болж, уурхай зогссон, тоосго төмрийн үйлдвэр хаагдсан зэрэг явдал айл өрхийн орлогын 50% байхгүй болсон гэсэн үг. Хараа хяналтгүй, эрсдэлт бүлгийн хүүхдүүд, ялангуяа хоолны чанар муу, хоолтой хоолгүй явснаас тураалтай, туранхай, өсөлтийн хоцрогдол, суурь өвчнүүд нь сэдэрч халдварт өвчинд өртөх аюулд хүргэж байна. Бусад хороонд гараагүй сүрьеэ өвчний халдвар манайд саяхан гарлаа. Энэ тохиолдлын талаар хэлэхэд, нэг айлын 2-6 насны 5 хүүхэд сүрьеэгийн халдвар авсан. Эцэг эх нь архины хамааралтай. Хөрш айлын хүүхдүүд нь халдвар авсан хүүхдүүдтэй хамт тоглодог учраас 9 хүүхэд хавьтал авсан. Хүүхдүүд бөөгнөрөл үүссэн мөн гэр бүлээрээ удаан хугацаанд хамт байсны улмаас /карантины үед/ сүрьеэ өвчин богино хугацаанд хүчтэй тархсан тохиолдол гарлаа. Сүрьеэ өвчин дархлаа суларбал маш аюултай өвчин.

КОВИД 19 ЦАР ТАХЛЫН ҮЕ ДЭХ ХҮҮХДИЙН НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Коронавируст цар тахлын улмаас боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоож, үүнтэй зэрэгцэн бага насны хүүхэдтэйгээ олон нийтийн газраар зорчих, худалдаа үйлчилгээний төвөөр хүүхэдтэйгээ үйлчлүүлэхийг хорьсонтой (төрөөс албан ёсны шийдвэр гараагүй ч тухайн байгууллагын бодлогоор бага насны хүүхэдтэй хүмүүст үйлчлэхгүй, хүүхдүүдийг оруулахгүй байсан тохиолдол) холбоотой хүүхдүүдэд сэтгэлзүйн болон нийгэмшлийн асуудлууд ямар байсныг

бид судалж үзсэн юм. Энэ үед хэд хэдэн олон улсын байгууллага, судалгааны байгууллагууд коронавирусын нөхцөл байдал хүүхдийн нийгэм - сэтгэл зүйн байдалд хэрхэн нөлөөлсөн талаар судалгаа¹³ хийсэн байна. Бид энэхүү мониторингийн тайландаа Боловсрол эвслийн гишүүн байгууллагууд болон бидэнд албан ёсоор судалгаагаа хуваалцсан байгууллагуудын мэдээллийг оруулсан болно.

Японы “Хүүхдийг ивээх сан”-гаас “Ковид-19” цар тахлын үед хэрэгжүүлсэн хүмүүнлэгийн арга хэмжээний хүрээнд Зорилтот бүлэгт тулгамдаж буй асуудлыг мэдэх зорилгоор 2 асуулга бүхий цахим судалгааг 2020 оны 04 сарын 2-6-ны хооронд явуулсан байна. Зарим үр дүнгээс дурдвал,

Хорио цээрийн энэ үед гэртээ байхад эцэг, эх, асран хамгаалагч таны сэтгэлийг ямар асуудал зовоож байна вэ?	Хорио цээрийн энэ үед таны хүүхдэд ямар бэрхшээл тулгарч байна вэ?
Хүүхдийн цахим хэрэглээ нэмэгдсэн нь түгшээж байна – 76 хувь	Гэртээ тоглох, хөдөлгөөнтэй байх орчин байхгүй байгаа нь - 74 хувь
Хүүхдийнхээ хичээлийг хийлгэх, хөгжүүлэхэд хүндрэлтэй байна – 56 хувь	Хүүхдүүд гэртээ хийх юм байхгүй, уйдаж байна – 35 хувь
Хүүхдийнхээ найз нөхдийн асуудалд санаа зовж байна – 14 хувь	ТВ хичээлээ ойлгохгүй, хичээл хийхэд хүндрэлтэй байна
Гэр бүлийн гишүүдийн стресс нэмэгдэж байна – 13 хувь	Найзуудтайгаа уулзахгүй байгаа учраас стресс нэмэгдэж байна.
Өсвөр насны хүүхэдтэйгээ харилцахад хэцүү байна – 13 хувь	Гэрийнхнийгээ өвдөхөөс айж, түгшиж байна - 21 хувь
Хүүхэдтэйгээ харилцаж, хүмүүжүүлэхэд бэрхшээлтэй байна – 12 хувь	Хүүхэд маань гэрийнхэндээ уурлах, бухимдах нь их болсон – 10 хувь

Боловсрол эвслийн Үйл ажиллагаанд суурилсан залуусын судалгаанд¹⁴ 15-18 насны залуус оролцсон бөгөөд нийгэм-сэтгэл зүйн хувьд дараах өөрчлөлт гарч байна хэмээн хариулсан байна.

“Өсвөр насны хүүхдүүдэд нийгэмшлийн хэрэгцээ хамгийн чухал байдаг бөгөөд энэ үедээ найз нөхөд, үе тэнгийнхэнтэйгээ уулзаж чадахгүй байгаа нь стресс, сэтгэл гутрал цаашлаад бусадтай харилцах харилцаанд сөргөөр нөлөөлж байгаагаа хэлж байсан.Охид гэртээ ихэнх цагийг өнгөрөөж байгаа тул гэрийн ажил олон цагаар хийх болжээ. Ялангуяа малчин айлын охид өмнө нь дотуур байранд амьдарч хичээлээ хийдэг байсан бол, гэрээсээ хичээллэх үед дүү нарынхаа хичээлийг хийлгэх, хонь хариулах, гэр орноо цэвэрлэх гээд ачаалал нэмэгдсэн байна. Эцэг эхчүүд хүүхдүүдийг гэрээсээ гарахгүй байхаар нийгмээс тусгаарлагдан, сурч хөгжих нь хязгаарлагдмал болж байгаад санаа зовж байгаагаа илэрхийлсэн.

13 НҮБ-ын Хүүхдийн сан, АШУҮИС, Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн гэх мэт

14 “Ковид 19 цар тахал тодорхой бүлгийн залууст хэрхэн нөлөөлсөн бэ?” Үйл ажиллагаанд суурилсан залуусын судалгаа, Бүх нийт боловсролын төлөө Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2020 он

Өсвөр насны хүүхэд, залуус өөрсдийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа, дугуйлан, клубт хамрагдаж чадахгүй болсондоо санаа зовж байв. Мөн ЛГБТИК+ хүүхдүүдийн хувьд хомофобик гэр бүлийхэнтэйгээ байнгын хамт байснаар хувийн аюулгүй байдалдаа санаа зовох, стресстэх зэрэг сэтгэл зүйн хувьд айдастай байснаа хэлж байв.”

Энэ үед хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлдэг үндэсний 12 ТББ-ууд төсөлд хамрагддаг 400 орчим хүүхдийн гэр бүлд очиж нөхцөл байдлын үнэлгээ хийсэн¹⁵ байна. Тэдний нэг болох “Өсвөр үеийнхний хөгжлийн төв” ТББ 2020 оны 4 дүгээр сард 7 хоногийн турш төсөлд хамрагдсан насанд хүрээгүй 30 охидын гэр бүлээр биечлэн очиж үнэлгээ хийн, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллажээ. Уг үнэлгээгээр хорио цээрийн өндөржүүлсэн нөхцөл байдлын үед ядуу эмзэг өрхийн амьдралын нөхцөл байдал маш хүндэрснээс гэр бүл бүр ямар нэгэн байдлаар хямралд орсон байв. Үүнд:

- 15 хүүхдийн ээж, аав болон асран хамгаалагч нар нь ямар нэгэн шалтгаанаар ажилгүй болсон.
- Ядуу тул гэрт телевиз байхгүйгаас хичээлээ хийж чадахгүй.
- Багш нар цахимаар даалгавар өгч шалгадаг тул гар утас байхгүй, байсан ч дата авч чадахгүй учраас хичээл даалгавар, багшийн зөвлөгөө зөвлөмжийг хүлээн авах талаар байнгын харилцаанд орж чадахгүй.
- Гэр орон тухгүй, хүйтэн тул хашаанаасаа гарч ойролцоо талбайд найз нараараа цугладаг. Хорооны эргүүлүүд хөөдөг.
- Гэртээ байхад байнга том хүн байхгүй тохиолдолд ойр орчны архидалт, ажилгүй хүмүүс айлгадаг.
- Гэр автобусны буудлаас хол, 2-3 зам гарч явдаг, харанхуй, мухар гудамж ихтэй, гэрийн ойролцоо далан барьж, хашаандаа орохын тулд мухар гудамжаар орж, даланг дамжиж ордог болсон. (Тухайн айлын хашааны орж гарах хэсгийг хаасан байсан)
- Түрээсийн мөнгөө өгч чадахгүйн улмаас ах дүү нар хэд хэдэн гэр бүлээр нэг гэрт амьдрах тохиолдол таарч байв. Нэг тохиолдол 0,05 га газартай хашаанд ах дүүсийн нийт 5 өрх амьдардаг байсан.
- Өрх толгойлсон эмэгтэйн гэр бүл (судалгаанд хамрагдагсдын 90%) дийлэнх нь байгаа ба заримынх нь ээж архины хамааралтай бөгөөд насанд хүрээгүй хүүхэд нь сургуулиас гарч асардаг гэх мэтчилэн нөхцөл байдалтай нүүр учирчээ.

15 Уг судалгааг Дүфресне Готтерийн сангийн дэмжлэгээр хийжээ.

Манайх ам бүл зургаа, 4 охин хүүхэдтэй, Нөхөр бид 2 хувиараа оёдол хийж Нарантуул зах дээр зардаг. Корона гараад хүмүүсийн худалдан авах чадвар суларснаар оёсон хувцас зарагдахгүй байгаа. Гэрийн хажууд далан барина гээд орох гарах хаалгыг шороогоор түрж хаасан. Манайх явган хаалгаар орж гарч байна. Замын ажил хийгдэж байгаа болохоор сургууль хаагдсан үед хүүхдүүдээ хашаандаа эзэнгүй орхиж явж чаддаггүй. Энд далангийн ажилд дан эрэгтэйчүүд ажилладаг, тэд манай хашаан дээгүүр өнгийж үргэлж юм асуух, юм гуйх зэргээр айлгаастай. Дан охидуудтай болохоор айдастай л байна.

Үнэлгээнд хамрагдсан охины ээжтэй хийсэн ярилцлагаас

Хүүхдийг Ивээх Сангаас хийсэн түргэвчилсэн үнэлгээгээр¹⁶ эцэг эх, асран хамгаалагчид цар тахлын хөл хорионы үед өөрсдөө сэтгэлзүйн хувьд тогтвортой байх нь үр хүүхдээ хэвийн асарч хамгаалахад чухал нөлөөтэйг харгалзан, эцэг эхчүүдэд сэтгэл санааны өөрчлөлт гарч буй эсэхийг лавлахад 64.7% нь буюу гурван хүн тутмын хоёр нь ТИЙМ гэж хариулсан нь хотод 79.3%, хөдөөд 58.6% нь байжээ. Нийт оролцогчдын бараг тал орчим нь буюу 48.6% нь санхүүгийн хүндрэлээс, 46.9% нь янз бүрийн асуудал бодогдож сэтгэл санааны байдал нь өөрчлөгдөж байгаа гэв.

Энэ үед сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг анхааран иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх чиглэлээр олон улсын байгууллагууд, төрийн байгууллага, төрийн бус байгууллагууд болон бизнесийн байгууллагууд ажиллаж байсан. Жишээлбэл, “Хүүхдийг ивээх сан”¹⁷, Хөөрхөн зүрх ТББ¹⁸, ЭКПАТ Монгол үндэсний сүлжээ¹⁹, ГБХЗХГ²⁰ зэрэг байгууллагуудаас хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран цахим болон биечлэн эцэг эх (эерэг хүмүүжийн арга, стресс менежмент), хүүхэд (нас насаар нь), олон нийтэд хандан зурагт хуудас, зөвлөгөө мэдээллүүдийг түгээжээ. Мөн тусгаарлагдсан иргэд болон тусгаарлагдсан хүүхдүүдэд зориулсан сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл боловсруулж түгээжээ²¹.

Хот суурин газрын иргэдийн хувьд санхүүгийн хүндрэл бэрхшээлээс болж сэтгэл санааны тогтворгүй байдалд орсон бол орон нутгийн иргэдийн хувьд харьцангуй бага байна. Санхүүгийн бэрхшээлээс үүдэлтэй сэтгэл санааны хямрал нь эргээд архидалт, хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллийг бий болгож байна.

16 “Коронавируст цар тахлын түргэвчилсэн үнэлгээ” Хүүхдийг ивээх сан, 2020 он

17 Боловсруулсан зурагт хуудас бүхий 4 зөвлөмжийг хамгийн өндөр хандалттай www.gogo.mn, www.ikon.mn, www.maamu.mn, www.yolo.mn цахим хаягаар “онцлох мэдээ”-гээр тус бүр 50 хувийн хөнгөлөлттэй үнээр байршуулж, олон нийтэд түгээжээ.

18 Хөөрхөн зүрх ТББ Ковид 19-ийн үеийн хөл хорионы үеийн сэтгэлзүйн зөвлөгөө, мэдээллүүдийг сошиал платформуудаараа дамжуулан “Зүрхээ сонс” подкаст (3 удаагийн дугаар), зурагт хуудас зэргээр олон нийтэд түгээжээ.

19 ОУШХБ-ын дэмжлэгээр Нийслэлийн ЗДТГ-тай хамтран “Ковид-19” цар тахлын үед иргэдэд нийгэм - сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, иргэдийн сэтгэл зүйн дархлааг дэмжих арга зүй” сэдэвт сургалт зохион байгуулж, нийслэлийн алслагдсан захын хороодод ажилладаг 80 нийгмийн ажилтныг хамруулсан байна.

20 ГБХЗХГ-ийн бүх аймаг, дүүргийн нийт 228 холбогдох мэргэжилтэн, ажилтнуудад зориулан цахим сургалтыг боловсруулан хүргэжээ.

21 ХИС-гаас ирүүлсэн мэдээлэл

ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, САЙН САЙХАН БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮСЛЭН АРГА ХЭМЖЭЭ

Гамшиг, хямралын үед насанд хүрсэн хүмүүсээс илүүтэй хүүхдүүд гэр бүлээсээ хагацаж, гэр оронгүй болж, ялгаварлан гадуурхагдан, бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх эрсдэл нэмэгдэж төдий чинээ урт хугацаандаа хор уршиг нь арилах амаргүй болдог билээ. Хүүхдийг Ивээх сангийн түргэвчилсэн үнэлгээгээр “эцэг эхчүүдийн 92% нь цар тахлын үед хүүхдийнхээ талаар санаа зовж байна гэсэн ба байршлаар харвал Улаанбаатар хотын судалгаанд оролцогчдын 92%, хөдөөгийн 91.7% нь санаа зовниж байна”²² гэсэн байв. Коронавируст цар тахлын үеийн хөл хорио, боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоосноор хүүхдийн эрхийн ноцтой зөрчил хэд хэдэн удаа олон нийтийг цочирдуулсан билээ.

Монгол улсын Засгийн газраас Ковид-19 халдварын тархалтаас сэргийлэх бэлэн байдлыг хангах, халдвар тархсан тохиолдолд тархалтыг зогсоох зорилгоор цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг хаах арга хэмжээг авсан. Энэ нь хүүхдийн боловсролд нөлөөлөхийн зэрэгцээ хүүхдүүд гэр бүлийн орчинд харгалзах хүнгүйгээр үлдэж байгаа нь хүүхдийн аюулгүй байдлыг хангахад эрсдэлийг нэмэгдүүлсэн байна. Гарч болзошгүй эрсдэлүүдийг бууруулах үүднээс Засгийн газраас болон шат шатны төрийн байгууллагууд тогтоол шийдвэр, зөвлөмж албан тоотуудыг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллажээ. Үүнд:

- 2020.01.24 Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар харьяа байгууллагууддаа 2020 оны үйл ажиллагааны төлөвлөлтөндөө баримтлах чиглэл хүргүүлэх тухай албан тоот
- “Гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй осол гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний удирдамж”²³
- “Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах”²⁴ тухай
- “Гамшиг Онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал батлах тухай”²⁵ чиглэл
- “Аймаг нийслэл дүүргийн хүүхэд хамгааллын мэрэгжлийн ангийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлын ерөнхий төлөвлөгөө”²⁶

22 “Коронавируст цар тахлын түргэвчилсэн үнэлгээ” Хүүхдийг ивээх сан, 2020 он

23 2020.01.26-нд Дэлхийн улс орнуудад Корона вирус дэгдсэнтэй холбогдуулан халдвар авах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улс орон даяар их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргасантай холбогдуулан ХНХын сайд, БСШУС сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан арга хэмжээний төлөвлөгөө

24 2020.02.06-нд ГБХЗХГазар харьяа байгууллагууддаа өгсөн чиглэл

25 2020.02.06-нд Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын тушаал

26 2020.02.18-нд Засгийн Газрын 2019 оны 05 сарын 22-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Онцгой байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах тусламж дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу батлагдсан томоохон баримт бичгүүдийг гарган шат шатны байгууллагууд хэрэгжүүлэн ажилласан байна.

зэрэг баримт бичгүүдийг гарган шат шатны байгууллагууд хэрэгжүүлэн ажилласан байна.

Хэдийгээр холбогдох байгууллагуудын бодлогын баримт бичиг, удирдамж, чиглэл гарсан ч 2020 оны эхний улирлын байдлаар Үндэсний Статистикийн Хороо болон Цагдаагийн Ерөнхий Газрын мэдээллээс харвал:

- Улсын хэмжээнд 2020 оны эхний 3 сард 8003 гэмт хэрэг бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 279 гэмт хэрэг байгаа нь өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар буурчээ. Тус төрлийн гэмт хэрэгт 273 иргэн өртөж, хохирсон байгаа нь өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар өсжээ. Нэг цэгийн үйлчилгээний төвд 2020 оны эхний 3 сарын байдлаар, нийт 920 хүн үйлчлүүлсэн (618 нь эмэгтэй, 114 эрэгтэй, 274 хүүхэд) нь өмнөх оны мөн үеэс 76.6 хувиар нэмэгдсэн байна.
- 2020 оны эхний 3 сард 545.9 мянган зөрчил бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас 3131 зөрчил шалган, 2244 зөрчлийг шийдвэрлэжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт зөрчил 15.0 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдсэн зөрчил 61.6 хувиар тус тус өсжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо буурсан хэдий ч үүний улмаас гарсан хохирол нэмэгдсэн, нөгөө талаас энэ төрлийн зөрчлийн тоо нэмэгдэж байгаа нь анхаарал хандуулах асуудал болохыг харуулж байна. Учир нь гэр бүлийн хүчирхийлэл нь далд явагдахын зэрэгцээ, давтагддаг, давтагдах бүрдээ шинж чанарын хувьд улам ноцтой болдог өвөрмөц шинж бүхий үйл явц юм. Нөгөө талаас нийтийг хамарсан цар тахал дэгдсэн энэ цаг үед олон нийтийн дунд бухимдал стрессийн түвшин нэмэгдсэний улмаас гэр бүлийн хүчирхийлэл өсөх зүй тогтол мөн илэрч байна.

Улаанбаатар хотод гарсан гэмт хэргийн дуудлагын тоо мэдээлэл²⁷

Цагдаагийн хэлтэс	Нийт дуудлага мэдээлэл	Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл	Үүнээс					Гэр бүлийн хүчирхийллийн
			Хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн	Давхардсан	Харьяаллаар шилжүүлсэн	ЗТХ-иар торгосон	Гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй	
Улаанбаатарт	130726	14724	14724	14724	14724	14724	14724	14724

Налайх дүүргийн 7-р хорооны өрхийн эмнэлгийн эмч нартай хийсэн ярилцлагын үеэр, “Архидалт, гэр бүлийн хүчирхийллээс хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ихээхэн эрсдэл учирч байна. Ажилгүйдэл, ядуурал ихэссэн. Төрөөс

27 “Хөөрхөн зүрх” ТББ-аас авав.

хүүхдийн мөнгө, халамжийг нэмсэн ч тэр нь хүүхдэд хүрч чадалгүй эцэг эх нь архи ууж, эсрэгээр нь хүүхдээ хүчирхийлдэг, дарамталдаг. Идэх хоолгүй болгодог зэрэг нь халдварт өвчин тусах, дархлаа сулрах нөхцөл нь болж байна.” хэмээн ярьж байсан юм.

Гэмтэл Согогийн Үндэсний төвийн 2020 оны эхний хагас жилийн “Осол гэмтлийн тандалт”-ын эргэн мэдээллийн судалгаа²⁸наас харахад 0-14 насны хүүхдийн гэмтэл, хордлого, гадны шалтгаант шинэ тохиолдлын тоо өмнөх оны мөн үеийнхээс 27 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Тухайлбал, 0-4 насны хүүхдийн хувьд 10320, 5-9 насныхны хувьд 6249, 10-14 насны хүүхдийн хувьд 4745 тохиолдол бүртгэгджээ. Хүүхдийн осол гэмтлийн тэргүүлэх шалтгаануудыг дурдвал, өндрөөс унах, амьтай амьгүй механик хүчин зүйлд өртөх (муур, нохойнд хазуулах гэх мэт), түлэгдэлт, зам тээврийн осол зэрэг багтдаг байна. Энэ оны хувьд боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа зогссон байсан үе тул дээрх тохиолдлууд дээр нэмэгдээд амьсгал боогдох, түлэгдэлт, байгалийн хүчин зүйлд өртөх, санамсаргүй хордох ба хорт бодист өртөх шалтгааны тохиолдлын тоо нэмэгдсэн байна. Эдгээр нь цэцэрлэг, сургууль хаагдсанаар хүүхдүүдэд тавих хараа хяналт суларч, хүүхдүүдийг эрсдэлд байдалд оруулжээ гэж үзэж болохоор байна.

Нэгэн харамсалтай жишээг татахад, 2020 оны 2 сарын 5-нд Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар баг, Их сургуулийн 4 дүгээр гудамжинд 1-5 насны гурван хүүхэд хэрэглээний халуун усанд түлэгдэж харамсалтайгаар нас барсан хэрэг гарсан билээ. Тухайн үед сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон байсан бөгөөд асран хамгаалагчийг нь ажил руу нь дуудсанаар хүүхдүүд хараа хяналтгүй үлджээ. Энэ харамсалтай явдлаас үүдэн 0-12 настай хүүхэдтэй ээжүүдэд цалинтай чөлөө олгохыг төрийн байгууллагуудад даалгаж, бусад байгууллагуудад уриалж байсан билээ.

Дараагийн нэг харамсалтай тохиолдол бол коронавируст цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлгөөн хязгаарласан үед буюу боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг 9 сарын 1-ыг хүртэл сунгах шийдвэрийг УОК, БСШУСЯ 4 сарын 14-нд гаргасан үед тохиолдсон байдаг. 2020 оны 5 сарын 27-нд Нийслэлийн Баянзүрх дүүрэгт харьяалагдах Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн ойролцоох усан толионд өсвөр насны дөрвөн хүүхэд амь насаа алдсан харамсалтай хэрэг гарсан. Хүүхдүүд амьдардаг орчинд нь (Дэнжийн мянга орчим) хүүхдүүдэд зориулсан тоглох талбайгүйн улмаас Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд очиж тоглож байхдаа осолджээ. Хөл хорио тогтоосон энэ үед хүүхдийн тоглоомын талбайг хаах, түгжих, сагсан бөмбөгийн шийдийн кольцог угаар нь тасалж авах, агаар салхинд гарах зорилготой иргэдийг хотын ногоон бүсэд оруулахгүй байх зэрэг арга хэмжээ авч байсан нь хүүхдийн эсэн мэнд байх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, чөлөөт цагаа өнгөрөөх зэрэг

28 <https://gemtel.mn/uploads/Осол%20гэмтлийн%20тандалтын%202020%20оны%20эхний%20хагас%20жилийн%20эргэн%20мэдээлэл.pdf>

үндсэн эрхийг нь ноцтойгоор зөрчсөн, хүүхдийн эрхийн мэдрэмжгүй шийдвэрүүд байлаа.

Хүүхдийн тусламжийн 108 дуудлагын утсанд ирсэн мэдээллээс харвал

№	Дуудлагын ангилал	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар
1	Нийт дуудлага	9331	7692	10127	9354	9640
2	Зорилтод	4952	3998	6859	5390	5484
3	Хүүхэд хамгаалал	1591	1524	1341	1657	1719

Дээрх судалгаа, тоо баримтуудаас харахад хүүхдэд хамгийн ээлтэй байх гэр бүлийн орчинд хүчирхийлэл дарамт их байгаа нь, боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа зогссоноор хараа хяналтгүй хүүхдүүд нэмэгдэж, осол гэмтэлд өртөх, хүчирхийлэлд өртөх нь ихэсч эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байгаа нь батлагдаж байна. Мөн нөхцөл байдлыг үндэслэн дүгнэхэд зөрчил гаргасан тохиолдлыг дахин давтагдуулахгүй байх, урьдчилан сэргийлэх талаас нь үе шаттай, уялдаатай холбоотой, олон талын оролцоог хангах, богино хугацаанд үр ашигтай байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хүүхдүүдийн сайн сайхан байдлыг хадгалах зорилгоор дэмжлэг үзүүлсэн талаар

Коронавируст цар тахлын үр нөлөөг бууруулах, цаашдын үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор Хүүхдийг Ивээх Сангийн хийсэн судалгаанд хамрагдсан өрхийн 37.9 хувь нь ковид 19-ийн үед төрийн болон бусад байгууллагаас ямар нэг тусламж авсан гэж мэдээлжээ. Үүний 26.6 хувь нь хотод, 43.3 хувь нь орон нутгаас судалгаанд оролцогчид байжээ.

Боловсрол эвслийн судалгааны мэдээлэл цуглуулсан газруудын өрхийн эмнэлэг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, төрийн бус байгууллагууд болон олон улсын байгууллагууд коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх болон өрхийн нийгэм, эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг бууруулах чиглэлээр тодорхой бүлгийн өрхүүд, хүүхдүүдэд материаллаг болон материаллаг бус дэмжлэг, тусламж үзүүлжээ. Жишээ нь зөвхөн Налайх дүүрэгт гэхэд,

- **Good neighbors** ТББ Ковид19-өөс урьдчилан сэргийлэх²⁹
- **“Сайн хүүхэд”** -ТББ 100 хүүхдэд бэлэг өгсөн. (амьжиргааны баталгаажих түвшинөөс доогуур орлоготой өрхийн)
- **“Амин хүүхдүүд”**- төрийн бус байгууллага 100 хүүхдэд бэлэг өгсөн.
- **Цвайцарын Хөгжлийн Агентлаг** - 188 өрхөд тусламж өгсөн.
- **“Лантуун дохио” ТББ** - 100 хүүхэд богц гэх мэт аян зохион байгуулсан байна.

29 Гүүд Нейборс ТББ-ын мэдээлснээр 925 өрхийн 1343 хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийсэн аж. ЭМН-тэй хамтарч /хүүхдийн эмнэлэгтэй/ Гарын эрүүл ахуй аяныг санаачлан зорилтот бүлгийн 350 өрхөд зочлон саван санитол тарааж өгөх зөвлөмж материал хүргэсэн. Мөн НДЗДТГазар, УОК-той хамтарч Ковид-19 тусламжийн аяныг зохион байгуулсан бөгөөд 1 айлд 30.000 төгрөг, нийтдээ 4.600,000 төгрөгийн тусламж үзүүлсэн байна.

Харин өрхийн эмнэлгүүд, эмч, эмнэлгийн ажилтнууд хоёр сар хагас хугацаанд эргүүл хийж, гэрээр явж үзлэг зөвлөгөө өгсөн байна. Мөн 200 өрх айлаар явж, ялангуяа амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой айлуудыг сонгож, хоолой амаа зайлах, гараа угаах арга зэрэг сургалт явуулж, мэдээллийн хуудас, саван, санитол, шүдний ОО зэргийг тараасан байна. Хүүхдүүдийн дархлааг дэмжих зорилгоор хүүхдүүдийг жинлэх үйл ажиллагаа явуулсан. (туранхай, тураалтай хүүхдүүд 0-5 насны хүүхдүүд) Үүний мөрөөр хороодын ӨЭМ-ийн төвүүд 3-4 хоног тус бүр 10 хүүхдийг чийрэгжүүлэх зорилгоор 0-12 насны эдгээр хүүхдүүдийг өдөрт хооллож витаминжуулдаг.

Мөн ГБХЗГ-аас Гамшгийн үеийн гэр бүлийн эрсдлийг үнэлэх түргэвчилсэн үнэлгээ хийсэнд 10880 өрх судалгаанд хамрагдсан. Үнэлгээгээр хоол хүнс тэжээлийн дутагдалтай 10 өрх айлыг илрүүлсэн. Мөн гэр бүлийн хүчирхийллийн мэдээлэл нийтдээ 76 ирсэн бөгөөд цагдаа, Эрүүл мэндийн нэгдэл, Мэргэжлийн хяналт, хороод, Хамтарсан багтай хамтраад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Хүүхэд хамгаалаллын чиглэлээр үйл ажиллагаа явуулсан. Энэ үед эцэг эхийн хараа хяналтгүй 17 хүүхдийг асрах газар хүргэж өгсөн байна. Мөн хүүхдийн хөдөлмөр (гар дээрээс худалдаа эрхлэх) сургууль хаасантай холбоотой ихэссэн байна.

Төрийн зүгээс хүүхдийн мөнгө, хоолны талон, зээлийн царцаалт зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ч зорилтот бүлгийн хүүхэд, эмэгтэйчүүд, ахмадуудад чиглэсэн газар дээрх үйл ажиллагааг төрийн бус байгууллагуудын санаачлагаар ихэвчлэн зохион байгуулсан харагдаж байна. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудаас нийгэм эдийн засгийн статус доогуур өрхөд амьдарч буй эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд хоол хүнс, эрүүл мэнд, охидод ариун цэврийн хэрэглэл, хичээлийн хэрэглэл зэргийг тарааж төрийн зүгээс орхигдоод байсан ядуу эрсдэлт бүлгийн өрх, ялангуяа хүүхдүүд, хүчирхийллийн хохиргчдод чиглэсэн үйл ажиллагааг цаг алдалгүй шуурхай хийсэн нь үр дүнтэй байв.

ДҮГНЭЛТ

Коронавируст цар тахлын хөл хорионы үед боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоосноос үүдэн хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудалд онцгой анхаарах хэрэгцээ шаардлага тулгарсан юм. Засгийн Газрын зүгээс хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, бодлогын баримт бичиг цөөнгүй байгаа ч хөл хорио тогтоосон хугацаанд хүүхэд хамгааллын олон асуудал хөндөгдөж, хүүхдүүд хараа хяналтгүй болж, аюул эрсдэлд өртөж байсан нь харамсалтай.

Цэцэрлэг, ЕБС болон бусад боловсрол сургалтын байгууллагууд нь зөвхөн сургалт, төлөвшлийн үйл ажиллагаа эрхлэх бус хүүхэд, гэр бүлийн хувьд хоол тэжээл, нийгэм-сэтгэл зүйн, эрүүл мэнд, аюулгүй байдлын, хүүхэд хамгааллын зэрэг олон талт үйлчилгээ үзүүлдэг газар болохыг энэ цар тахалын нөхцөл илрүүлэн гаргаж ирлээ.

Сорилтууд

- Цар тахлын улмаас хөл хорио тогтоосон хугацаанд хүйтний улирал таарсантай холбоотой маргинал бүлгийн айл өрхүүд түлээ, ундны ус, мах, хүнсний ногооны хэрэглээгээ бүрэн хангаж чадахгүй байгаа нь хүүхдийн хоол тэжээлийн хангамжинд хүндээр тусч байна. Хоол хүнсний Дэлхийн хөтөлбөрийн тооцоолсноор өдөр тутмын авдаг шим тэжээлээ гагцхүү сургуулийнхаа хоолноос олж авдаг байсан дэлхийн 368 сая гаруй сурагчид сургууль хаасны улмаас хоолгүй болсон.
- Хөл хорионы үед ард иргэд, хүүхэдтэй хамгийн ойр ажиллах ёстой нийгмийн ажилтнууд хорио цээрийн үеийн мэдээ тайлан, хүн олноор цугласан эсэх талаар эргүүл хийлгэх зэрэг ажлаар дарагдснаас иргэдтэй ажиллах, хүүхэд хамгаалал ялангуяа ядуу эмзэг гэр бүлд амьдарч буй хүүхдийн хоол хүнсний хангамжинд анхаарч туслах, холбон зуучлах цаг, боломж байхгүйн дээр ажлын байран дээрээ аюулгүй ажиллах хамгаалах хувцас, ариутгалын бодис, маскаар хангахгүй байсан нь сэтгэл зүйн хувьд их дарамттай байжээ.
- Ковид-19 цар тахлын үед хүүхэд, өсвөр үеийнхэнд тулгарсан нийгэм - сэтгэл зүйн таагүй байдал дараах нөхцлөөс үүдэн гарсан байна. Үүнд сургууль, цэцэрлэг болон бусад арга хэмжээ хаагдсан, гэртээ хорио цээрийн нөхцөлд амьдарсан, ковид-19-ийн талаарх өдөрт 2 удаа явдаг УОК, ЭМЯ-ны мэдээлэл, цахим орчин дахь цуурхал, цахим хүчирхийлэл, таагүй мэдээллүүд, гэр бүлийнх нь орлогын бууралт, ядуурал, орчны архидалт, хүчирхийлэл зэрэг хүчийн зүйлээс нөхцөлдсөн байна.
- Хүүхдийн 100.000 төг олгож эхэлсэнтэй холбоотой эмзэг бүлгийн хүүхдүүдийн эцэг, эх хүүхдийн мөнгөөр архидах, хүүхдэд зориулахгүй байх эрсдэл үүссэн бол нөгөө талаараа өсвөр насныхан хүүхдийн мөнгөө өөрөө зарцуулах эрхтэй болж, түүгээрээ РС тоглоомонд донтох, РС тоглоомын газар насанд хүрэгч залуучуудтай тоглон тэдний хараа нөлөөнд орж өрөнд орох, өрөө төлөх зорилгоор гэртээ ирэхгүй шөнийн цагаар ажил хөдөлмөр хийх, цахим сургалт хичээлээ таслах, үүнээс улбаалж гэр бүлийн гишүүдтэй зөрчилдөх зэрэг сөрөг үйлдлүүд гарчээ.
- Мөн хүүхдүүдийн хоол тэжээлийн дутагдал, жинлэлтийн асуудал нь учир дутагдалтай, зөвхөн дөнгөж төрсөн нярай хүүхдүүдийг Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар жинлэдэг боловч бусад цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийг жинлэх ажил хийгдээгүйн улмаас тодорхой мэдээлэл олж чадаагүй нь харамсалтай байлаа.
- Цар тахлын үед Ерөнхий боловсролын сургуулийн эмч, нийгмийн ажилтан нар ажлын орчин, санхүү мөнгөний дутагдал зэргээс үүдэн сургуулийнхаа хүүхдүүдийг эргэж тойрох, үзлэг хийх, зөвлөгөө зөвлөмж, мэдээлэл өгөх, тараах талаар дутмаг ажилласан нь харагдаж байлаа.
- Мөн цар тахлын үед сурагчдын үдийн цайны хоолны үйлчилгээг зогсоож, төсвийг буцаан татсан явдал маш буруу шийдвэр байсныг багш, эцэг

эхчүүд, сургуулийн удирдлагуудын ярианаас харагдсан. Мэдээлэл цуглуулах судалгааны явцад өдөртөө сургуулийн үдийн хоол, оройдоо сүмийн хоол идэж өдрийн хэрэгцээгээ хангадаг эмзэг бүлгийн хүүхдүүд их байлаа.

Боломж

- ЕБС-иуд үдийн цай, хоолыг бэлтгэн хүүхдийг гэр бүлдээ байх хугацааны хоол тэжээлийн хангамжинд нэмэрлэх зорилгоор түгээх.
- Хоол хүнс үйлдвэрлэдэг, тариалдаг, махан бүтээгдэхүүн нийлүүлдэг худалдаалдаг аж ахуйн нэгжүүд эмзэг бүлгийн ард иргэдийг хоол хүнсээ нөөшлөх, хямд боломжтой уламжлалт хоол хүнс, ногоо жимсийг гэр бүлийн амьдрал хоол хүнсэндээ зориулж авахын тулд нээлттэй ажлын байранд татан оролцуулж ажиллуулах, нээлттэй зарлах, ажлын хөлсөнд бүтээгдэхүүнийг зах зээлээс хямд үнээр өгдөг байх хэвшил тогтоох,
- Сургууль, хороо, эрүүл мэндийн нийгмийн ажилтнууд, ТББ-ын ажилтнууд, сайн дурынхан, орон нутгийн бүлгүүд цар тахлаас урьдчилан сэргийлэх, бүх нийтийн хөл хорионы үед хэрхэн хамтарч ажиллах талаар, хүүхэд гэр бүлд хэрхэн нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг алсын зайнаас хүргэж болох талаар арга зүйн зөвлөгөө сургалтыг цахимаар явуулж, шуурхай удирдлага, зөвлөмж мэдээллийг цахим орчинд явуулах боломжтой.
- Хүүхэд хамгааллын асуудалд иргэний идэвх, оролцоотой иргэдийг татан оролцуулах, мэдээлэлжүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд төр төрийн бус байгууллагууд хамтран бодлогоо тодорхойлж ажиллах бүрэн боломжтой байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГА БА КОВИД 19

(Сэдэвчилсэн мониторингийн тайлан)

Нийгмийн эгэх хариуцлага гэдэг нь иргэн, иргэний нийгмийн байгууллага төрөөс хариуцлага нэхэх, төрд хяналт тавих, төрөөр хариу үйлдэл хийлгүүлэх, зарим асуудлыг хамтран шийдвэрлэх бүтээлч хамтын ажиллагааг багтаасан үйл явц гэж судлаачид тодорхойлдог бөгөөд дараах 3 үе шаттай өрнөдөг. Үүнд:

1-р үе шат буюу тайлагнах. Төр засгийн байгууллага, албан тушаалтнууд өөрсдийн хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний үр дүнг олон нийтэд тайлагнаж мэдээлэх, мөн иргэдэд тухайн мэдээлэл нь ил тод нээлттэй байх тухай юм.

2-р үе шат буюу хэлэлцэх. Төр засгийн байгууллага, албан тушаалтнууд ажил үүргийнхээ биелэлтийн талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх, хийсэн ажлаа үндэслэл нотолгоотой тайлбарлах, иргэдийн санал бодлыг сонсох хэлбэрээр тэдэнтэй харилцах, ярилцах үйл явц

3-р үе шат буюу хариуцлага тооцох. Төр засгийн байгууллага, албан тушаалтнууд албан үүргээ сайтар биелүүлээгүй бол тэдэнд алдаагаа засах боломж олгох, эсхүл хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаа.

Боловсролын салбарт бий болсон сорилтыг даван туулах, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах нь зөвхөн төр засаг, сургуулийн удирдах албан тушаалтан, багш, ажилтнуудад хамаатай ажил бус харин боловсролын үр шимийг хүртэгч эцэг эх, бусад оролцогч талуудад ч хамаатай асуудал юм. Үндсэндээ 2019-2020 оны хичээлийн жилд 4 сар танхимаар, үлдсэн бүх хугацаанд хичээлийг зайн сургалтаар үзэж байгаа юм. Иймд боловсролын салбарын нийгмийн эгэх хариуцлагын байдлыг төрөөс авсан арга хэмжээ, иргэд, ИНБ-уудын оролцоо, гаргасан санал хүсэлт, гомдол, түүнийг төрөөс хэрхэн шийдвэрлэсэн байдал, иргэдэд хүргэсэн мэдээлэл, хамтран ажилласан байдал гэсэн хүрээнд авч үзлээ.

Мониторинг хийх хүрээ:

- Гарсан тушаал шийдвэр
- Боловсролын оролцогч талуудад өгсөн удирдамж, чиглэл
- Зохицуулалт, хэрэгжилтийн байдал
- Тулгамдсан асуудлууд/сорилтууд
- Боломжууд
- Цаашид авах ёстой арга хэмжээний зөвлөмж

Бид мониторингийн хүрээнд боловсролын 4 түвшинг (СӨБ, ЕБС, мэргэжлийн боловсрол, их, дээд сургууль) хамрах зорилт тавьсан боловч мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал ХНХЯ-д харьяалагддаг, их, дээд сургууль, коллежийн төсөв, санхүүжилт салбарын яамны түвшинд шийдэгдэггүй тул мэдээлэл хомс, судалгааны хувьд хязгаарлагдмал үр дүн гарлаа.

Гарсан тушаал шийдвэр

Коронавирусын цар тахлын үед боловсролын салбар дахь нийгмийн эгэх хариуцлагын анхдагч гол бүрэлдэхүүн хэсэг нь төрийн үйлдэл бөгөөд энэ тохиолдолд төрөөс оюутан, сурагчдын сурч боловсрох үйл ажиллагааг тасалдуулахгүй үргэлжлүүлэхийн төлөө хийж байгаа үйлдлийг авч үзсэн.

Хятад улсад коронавирусын халдвар тархсан, ДЭМБ-аас Монгол улс өндөр эрсдэлтэй гэж дүгнэсэн үед хийсэн төрийн үйлдэл нь 2020 оны 1-р сарын 26-нд Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, сургууль, их, дээд сургууль, коллеж, хүүхэд харах төвийн үйл ажиллагааг 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл түр зогсоож, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын хөтөлбөрийн агуулгаар сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах арга хэмжээ авах явдал байв. Уг шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр БСШУСЯ-наас 2020 оны 1-р сарын 27-нд шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай сайдын тушаал гарсан байдаг. Үүгээр хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоох, нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүй байх, дараах холбогдох арга хэмжээг авахыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, хүүхэд асрах төв, ерөнхий боловсролын сургууль, коллеж, их дээд сургуулийн холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосон шийдвэр гарсан.

№	Авах арга хэмжээ	Үүрэг хүлээсэн
1	Оюутан, суралцагч, багш ажилтанд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах	Байгууллагын дарга, захирлуудад
2	Байгууллагуудад ариутгал, халдваргүйтлийг тогтмол хийлгэх	Байгууллагын дарга, захирлуудад
3	Оюутан, сурагч, багш, эцэг эхчүүдэд зөвлөмж чиглэл боловсруулан хүргэх зохицуулалтыг хийх	Яамны СӨБ, ЕБ ба ДБ-ын бодлогын газрын дарга, Боловсролын хүрээлэн, БМДИ-ийн захирлуудад
4	Сургуулийн өмнөх ба бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгаар теле хичээл зохион байгуулах	Яамны СӨБ, ЕБ ба ДБ-ын бодлогын газрын дарга, Боловсролын хүрээлэн, БМДИ-ийн захирлуудад

5	Их, дээд сургууль, коллежийн сургалтыг цахимаар хэрэгжүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулах	Их дээд сургууль, коллежийн захирлуудад
6	Хичээл сургалтын үйл ажиллагааг зогсоосонтой холбоотойгоор хүүхдийг хараа хяналттай байлгах, аюулгүй байдлыг хангах, мэдээлэл хүргэх	Аймаг, нийслэлийн засаг дарга нарт
7	Цэцэрлэг, бүх шатны сургуулиудад тушаалын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийж, мэдээг 7 хоног тутамд танилцуулах	Хяналт шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газрын даргад
8	Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Төрийн нарийн бичгийн даргад

Аймгийн БСУГ, нийслэлийн БГ-ын дарга нарт дээрх тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх:

- Теле хичээл зохион байгуулах
- Багш ажлын байранд ажлын цагаар байх, гар утас, цахим сүлжээгээр зааварчилгаа өгөх, хариу мэдээлэл авах-файл, мэйл илгээх
- Сургууль дээр интернэт ашиглах боломж бүрдүүлэх
- Теле хичээлийг бататгах үйл ажиллагаа зохион байгуулах
- Малчдын хүүхдэд хүрэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах
- Төгсөх ангийн сурагчдад шалгалт өгөхөд дэмжлэг үзүүлэх-давтлага
- ЭЕШ-тай холбоотой мэдээллийг Боловсролын үнэлгээний төв хариуцан ажиллах
- Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг цахимаар хийх

2. Халдвараас урьдчилан сэргийлэх

- Эрүүл мэндийн чиглэлийн мэдээллийг өгөх-анги даасан багш нар сурагчдад
- Ариутгал халдваргүйжүүлэлт хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

Шинэ төрлийн коронавирусийн дэгдэлт дэлхийн улс орнуудад хурдтай тархаж байгаагийн улмаас Монгол Улсын Засгийн газраас цэцэрлэг, сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан боловсролын асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах чиглэлийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 1а/867 дугаар албан бичгээр орон нутагт хүргүүлээ.

Шинэ коронавирусийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор

Монгол Улсын Засгийн газраас улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан БСШУС-ын сайдын 2020 оны А/118 дугаар тушаалыг баталлаа. Энэхүү тушаалаар ЕБС-ийн суралцагчийн 2019-2020 оны хичээлийн жилийн анги дэвших болон улсын шалгалтыг цуцалж, шалгалтын дүнг жилийн эцсийн дүнгээр тооцох, нэгдмэл агуулга бүхий шалгалтын үнэлгээ /дүн/-г тооцох аргачлал, хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсролын үнэлгээний байгууллагаас боловсруулж хүргүүлэх зохицуулалтыг хийлээ.

Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаас Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн чиглэл, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтэд үндэслэн бүх шатны сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон хугацааг энэ хичээлийн жил дуустал буюу 2020 оны 6 сарын 1-ний өдрийг хүртэл сунгаж шийдвэрлэв.

2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай УИХ-ын тогтоол гарсан.

Засгийн газрын 2020 оны 139 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” БСШУС-ын сайдын 2020 оны А/194 дүгээр тушаалын төслийг боловсруулж, батлууллаа. Уг тушаалаар (i) цэцэрлэг, сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн үргэлжлэх хугацааг 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөр дуусгавар болгох, (ii) ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийг 100 хувь анги дэвшүүлэх, төгсгөх, (iii) жилийн эцсийн үнэлгээ гаргахад хагас жил /II улирал/-ийн үнэлгээ болон зайнаас суралцсан байдлыг харгалзан багшаас өгсөн онооны нийлбэрээр тооцож, сурлагын амжилтын өмнөх үнэлгээг бууруулахгүй байх, (iv) цэцэрлэгийн бүртгэл, суралцагч элсүүлэхтэй холбогдох үйл ажиллагааг 2020 оны 8 дугаар сарын хоёрдугаар хагаст зохион байгуулах зэрэг элсэлт, төгсөлттэй холбогдон үүсэх асуудлыг тус тус зохицуулжээ.

БСШУС-ын сайдын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн “Их, дээд сургууль, коллежийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зарим зохицуулалт хийх тухай” А/195 дугаар тушаал гарч, тушаалыг Монголын их, дээд сургуулиудын консорциум, Хувийн их, дээд сургуулиудын холбоо болон их, дээд сургууль, коллежийн захирлуудад хүргэж, шуурхай зохион байгуулалтыг хангаж ажиллав.

2020 оны 4 дүгээр сарын 29-нд “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг баталсан. Хуульд: Засгийн газраас боловсролын салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээг “өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны хичээл, сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулах, сургалтын төлбөрийг хөнгөлөх, дараагийн төлбөрт шилжүүлэх;(7.1.8.) бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулсан, хязгаарласан

тохиолдолд цахим, эсхүл бусад хэлбэрээр зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй хүргэх, багш болон суралцагчийн оролцоо, түүнд тавих хяналтыг сайжруулах; (7.1.9.) гэж тодорхойлжээ.

Боловсролын Хүрээлэнгийн захирлын гаргаж байсан тушаал шийдвэрүүд

№	Хугацаа	Гаргасан шийдвэр	Товч агуулга
1	2020.01.27-ны өдөр	Телевизээр явуулах хичээлийн агуулга, хуваарийг батлах тухай А/03 тоот тушаал	Орох хичээл бүрийн үргэлжлэх хугацаа, давтамж, сэдэв, суралцахуйн зорилт, анхаарах зүйл, гарын авлага зэргийг нарийвчлан заасан.
2	2020.02.28-ны өдөр	Теле хичээлийн агуулга хуваарийг батлах тухай А/06 тоот тушаал	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан 2020.03.30-ны өдөр хүртэл явуулах хичээлийн хуваарь, агуулга, мөн ЭЕШ-д бэлтгэх теле хичээлийн агуулга, хуваарийг нэмж баталсан.
3	2020.03.08-ны өдөр	Теле хичээлийн агуулга, хуваарийг батлах тухай А/08 тоот тушаал	4-р сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд явагдах хичээлийн агуулга, хуваарь, тусгай хэрэгцээт боловсролын теле хичээлийн агуулга, хуваарийг нэмж баталжээ.
4	2020.04.03-ны өдөр	Сургалтыг үргэлжлүүлэх агуулга, арга зүй ба “Багшийн журнал” хөтлөх заавар хүргүүлэх тухай Боловсролын хүрээлэнгийн захирлын албан тоот	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах бага, суурь болон бүрэн дунд боловсролын агуулга, арга зүйн матриц Багшийн журнал хөтлөх заавар
5	2020.04.20-ны өдөр	Теле хичээлийн агуулга, хуваарийг батлах тухай А/10 тушаал	сургалтын үйл ажиллагааг 09-р сарын 01 хүртэл зогсоосонтойгоор холбоотойгоор 05.29 хүртэл явагдах хичээлийн агуулга, хуваарь

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын жилийн эцсийн дүнг 2019-2020 оны хичээлийн жилд танхимд хичээллэсэн үе буюу II улирлын эцэст гаргасан үнэлгээгээр тооцож, анги дэвших, төгсгөх үйл ажиллагааг зохицуулсан. Дараагийн хичээлийн жил буюу 2020-2021 оны хичээлийн жилийн цэцэрлэгийн бүртгэл, нэгдүгээр анги болон бусад элсэлтийн үйл ажиллагааг 2020 оны 8 дугаар сарын хоёрдугаар хагаст зохион байгуулахаар хойшлуулсан.

Цэцэрлэг, сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг бүрэн зогсоох болсонтой холбогдуулан гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, түлш халаалт зэрэг байр ашиглалттай холбоотой зардлыг хэмнэж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, холбогдох чиглэлийг хүргүүлжээ.

2020-2021 онд их дээд сургууль, коллежид элсэн оролцох суралцагчдаас авах Элсэлтийн ерөнхий шалгалтыг 2020 оны 7 дугаар сарын 2-5-ны өдрүүдэд зохион байгуулахаар Улсын онцгой комиссын хуралд танилцуулсны үндсэн дээр шийдвэрлэсэн. Мөн их, дээд сургууль, коллежийн элсэлтийг 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор цахимаар хийсэн.

Бүх шат түвшний боловсролын хөтөлбөрийг цахимаар хэрэгжүүлэх бэлтгэл ажил

Манай улсын хувьд зайн сургалтыг 2000 оны эхэн үеэс хөгжүүлж эхэлсэн байдаг. Төр засгийн түвшинд хэд хэдэн хөтөлбөр гаргаж хэрэгжүүлсэн.

- 2002 оноос “Зайн сургалтын үндэсний хөтөлбөр”
- 2005-2012 оны хооронд хэрэгжүүлсэн “Цахим Монгол үндэсний хөтөлбөр”
- 2012-2016 оны хооронд “Нэг Монгол санаачилга”

Гэвч нийтээр зайны сургалтад шилжих шийдвэр гарах үед орчин үеийн түвшинд суралцагчдын эрэлт хэрэгцээг хангахуйц хууль эрх зүйн орчныг ч, хэрэгжүүлэх системийг ч цогцоор нь бий болгож хараахан чадаагүй байна. Жишээлбэл, зайн болон цахимаар сургалтыг зохион байгуулах иж бүрэн платформыг бий болгож чадаагүй, мөн зайн сургалтаар судалж мэдсэн зүйлийг баталгаажуулах, кредит тооцох гэх мэт асуудлууд шийдэгдээгүй байна.

Их дээд сургуулиуд өөрсдийн хэмжээнд цахим болон зайн сургалтуудыг хөгжүүлэх, нэвтрүүлэх талаар олон ажлуудыг энэ хугацаанд хийж байсан боловч цогцоор нь арга зүйн болон технологийн шийдлийн хувьд бүрэн шийдэж, одоогийн үүсээд байгаа нөхцөл байдалд 100 хувь зайн сургалтад шилжин ажиллахад бэлэн бус байсан гэж мэргэжилтнүүд үзэж байна.

Мөн тухайн үеийн зайн сургалтыг зохион байгуулах техникийн нөхцөл байдал хангалтгүй, хүртээмжгүй байсан нь дараах мэдээллээр харагдаж байна:

- Төрийн өмчийн сургуулиудын 48.2, хувийн өмчийн сургуулийн дөнгөж 6.1 хувь нь мэдээлэл зүйн сургалтын танхимтай байна.
- Сумын сургуулиудын 68.8 хувь нь зориулалтын мэдээлэл зүйн кабинетгүй байна.
- 2018-2019 оны хичээлийн жилд ЕБС-ийн сургалтад нийт 32,660 компьютер ашиглагдаж байгаагаас 60 хувь нь зөөврийн, 37 хувь нь Пентьюм IV ба түүнээс дээш, үлдсэн 3 хувьд нь түүнээс бага үзүүлэлттэй компьютерүүд хэрэглэгдэж байна.
- Сургалтад хэрэглэгдэж буй нийт компьютерийн 58.6 хувь нь интернетэд холбогдсон байна.
- 2017 оны байдлаар ЕБС-д 572,752 суралцагч суралцаж, сургалтын үйл ажиллагаанд ашиглагдаж буй компьютерийн тоо 45,836 байна. Нэг компьютерт ногдох сурагчийн тоо 12.5 байна.
- 2018-2019 оны хичээлийн жилд ЕБС-д 30411 үндсэн багш ажиллаж,

багшийн хөгжлийн болон багшийн албан хэрэгцээний үйл ажиллагаанд ашиглагдаж буй компьютерийн тоо 20346 байна. Нэг компьютерт ногдох багшийн тоо улсын дунджаар 1.5 болжээ.

ИРГЭД, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Нийгмийн эгэх хариуцлагын бас нэг гол бүрэлдэхүүн **иргэдийн үйлдэл** (citizen action) бөгөөд мэдээлэл, тайлбар хүлээн авах, хариуцлага тооцох; шударга бус үйлдлийг эсэргүүцэх; төрийн үйлчилгээг сайжруулахыг шаардах зэрэг хэрэглэгч талаас буюу иргэдийн санаачилсан оролцоо, үйл ажиллагааг хамааруулна. Мөн **олон нийтийн идэвх санаачилга/иргэний хөдөлгөөн** (civic mobilization) иргэд тэр дундаа эмзэг, орхигдсон бүлгийн дуу хоолойг хүргэхийн тулд иргэд өөрсдийгөө дайчлан нийгмээ сайн сайхан болгохын төлөө төрийн хийх ажлыг сануулах, хийхийг шаардахын төлөө хамтран ажиллах үйл явц байдаг.

Иргэдийн зүгээс тухайлбал, Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо (СБХЭЭХ)-ноос теле хичээлийн дохионы хэлний орчуулга чанаргүй байгаа талаарх эцэг эхчүүдийн гомдлыг уламжилж өгөхийг “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэлд (Боловсрол эвсэл) хандсан билээ. Энэ талаар Боловсрол эвслээс БШУЯ-нд албан бичиг хүргүүлэхэд теле хичээлийг зохион байгуулж байгаа Боловсролын хүрээлэн, БМДИ-ийн захиралд уламжилснаа хариу мэдэгдсэн. Боловсролын хүрээлэн болон БМДИ-ийн захирал нар Боловсрол эвслийн Ерөнхий зохицуулагчтай утсаар холбогдон дохионы орчуулгын чанарыг хэрхэн сайжруулах талаар зөвлөлдсөн. Хариу арга хэмжээ авсан эсэх талаар СБХЭЭХ-ны гүйцэтгэх захирал О.Амаржаргалаас тодруулахад: Хүүхдүүд теле хичээл үзээд ойлгохгүй байсан. Тусгай сургуулийн 9-р ангийн хүүхдүүд ЕБС-ийн 7-р ангийн хичээлийг үзэх түвшинд байдаг. Анги дотроо хүүхдүүдийн түвшин нь янз бүр байдаг. Сургуулийнх нь багш нараас ямар ч чиглүүлэг өгөөгүй. Энэ талаар телевизийн нэвтрүүлэгт ярилцлага өгч оролцоход багш нар нь өөрсдийгөө өмөөрч над уруу утсаар холбогдсон. Сургуулийн захирал нь ирж уулз гэж дуудсан, очоогүй. Орчуулгын чанар дорвитой сайжраагүй” гэж ярьсан.

Монголын оюутны холбооноос 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдөр их, дээд сургуулиудын цахим хичээл, төлбөр, оюутны байрын талаар оюутнуудад тулгамдаж байгаа асуудлыг тусгаж, шийдлийн хамт албан бичгээр БСШУСЯ-нд хүргүүлсэн. Үүнд:

- Хүртээмжгүй: цахим сургалт, техник хангамж, интернет сүлжээгүй, хурд удаан, багтаамжгүй, давтан үзэх боломжгүй
- Чанаргүй: сургалтын арга зүй, стандарт, агуулга
- Цаг үетэй зохицоогүй: уян хатан бус, амьдралын бололцоо, боломжийг харгалзахгүй байх, орон нутаг, алслагдсан байдлыг тооцохгүй цаг хугацаагаар шахах

- Хүрэлцээгүй: оюутан бүрд цахим сургалтын гарын авлага, ном, товхимол, техник хэрэгсэл байхгүй

Монголын оюутны холбооноос БСШУСЯ-нд цахим сургалттай холбоотой асуудлаар 2020 оны 04 дугаар сарын 28-ны өдрийн 1/А 22 тоот албан бичгээр дахин шаардлага хүргүүлжээ. Уг бичигт цахим сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, оюутны сургалтын төлбөрийн зарцуулалтыг шилэн дансжуулах, зарцуулагдаагүй төлбөрийг буцаан олгох, цахим сургалттай холбоотой үзэл бодлоо илэрхийлсэн оюутнуудыг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах, айлган сүрдүүлэхтэй холбоотой хариу арга хэмжээ авах талаар тодорхой саналуудыг тусгаж хүргүүлсэн байна. Хувийг Хүний Эрхийн Үндэсний Комисс, Хүний эрхийн Форум, Монголын Эмнести Интернэшнл, Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, Монголын их, дээд сургуулиудын консерциум, Монголын их дээд сургуулиудын холбоо зэрг байгууллагуудад хүргүүлэв.

Албан бичигт хариу арга хэмжээ хэрхэн авч ажилласан талаар МОХ-ны Ерөнхийлөгч Г.Сүхбаттай утсаар холбогдож лавлахад (2020.07.01): 4-р сарын 28-нд БШУСЯ-д цахим сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, оюутны сургалтын төлбөрийн зарцуулалтыг шилэн дансжуулах, зарцуулагдаагүй төлбөрийг буцаан олгох, цахим сургалттай холбоотой үзэл бодлоо илэрхийлсэн оюутнуудыг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах, айлган сүрдүүлэхтэй холбоотой хариу арга хэмжээ авах тухай албан бичиг хүргүүлсэн. Албан бичгийн хариуд 100 хувь хангалттай сайн ажиллаагүй ч зарим их, дээд сургуулиуд арга хэмжээ авч ажилласан. Тухайлбал, сургуулиуд дотроо цахим сургалтын хүртээмж, чанарыг сайжруулах талаар хэлэлцүүлэг хийсэн, дотуур байрын үлдэгдэл мөнгийг буцаасан гэж хариулсан.

“Шударга ёсны манаанд” ТББ 2020 оны 3 сарын 23-нд БСШУС-ын сайд Ё. Баатарбилэгт хандан хувийн болон төлбөртэй цэцэрлэг, ЕБС, коллеж, их дээд сургуулиудад 2019-2020 оны хичээлийн жилд төлсөн сургалтын төлбөрөөс 2020-2021 оны хичээлийн жилд 30-50 хүртэлх хувиар дүйцүүлэн хөнгөлөлт үзүүлэх шаардлагыг тухайн байгууллагуудад хүргүүлэх хүсэлт гаргасан байна. Сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх шаардлагыг хувийн их, дээд сургууль, коллеж, цэцэрлэг, сургуульд хүргүүлсэн.

Албан бичгийн хариуд БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгийг эцэг, эхчүүдтэйгээ зөвшилцөх, тэдний саналыг авч төлбөрийн асуудлыг шийдвэрлэх чиглэл өгсөн байна.

2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Сангийн сайдын шийдвэрээр хувийн цэцэрлэгүүдийн тавдугаар сарын хувьсах зардлыг олгохгүй байх, өмнө нь өгсөн зардлыг буцааж татах шийдвэр гарсан байна. Гэтэл Боловсролын сайд төрийн ба төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн багш нарт цалинг нь олгоно гэдэг шийдвэр гаргасан байсантай зөрчилджээ.

Уг шийдвэрийг эсэргүүцэн хувийн цэцэрлэгийн багш нар 2020 оны 5 сарын 19-ны өдөр Сангийн яамны гадна жагсаал зохион байгуулж, Ерөнхий сайд, Сангийн сайд, Боловсролын сайдад санал, шаардлага хүргүүлжээ.

Сургуулийн эцэг эх, багшийн үндэсний нэгдсэн холбоо (СЭЭБҮНХ)-ноос гишүүн байгууллагууд болох 8 аймгийн 31 сумын Сургуулийн эцэг эх, багшийн холбоо (СЭЭБХ)-ны гишүүдтэй цахимаар холбоотой ажилласан. СЭЭБХ-д Удирдах зөвлөлийн хурал, эцэг эхчүүдтэй уулзалт, сургалтыг онлайнээр зохион байгуулахад суралцан тогтмолжуулсан.

Сумын СЭЭБХ-ны гишүүн эцэг эх, багш нар багийн Засаг дарга нартай хамтран ажиллаж, ковидоос урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар мэдээлэл бэлтгэн хэвлэж, сумын төвийн болон алслагдсан малчин айлуудаар тарааж, мэдээлэл хүргүүлж ажилласан. Мөн сурагчдад гэртээ ажиллах даалгавар, дасгал хэвлэн хүргүүлсэн, хүүхдүүд гэрийнхэнтэйгээ хамтдаа хийх дасгал хөдөлгөөн зэргийг цахимаар түгээж, хийсэн бичлэгээ ангийнхандаа явуулж багш, сурагч, гэр бүлийн гишүүд хамтран ажилласан.

Боловсрол эвслээс БСШУЯ-нд 2020 оны 6-р сарын 10-нд дараах асуудлаар хандаж албан бичиг хүргүүлсэн.

- 2020 оны 1-р сарын 26-наас өмнөх хугацаанд теле хичээл болон цахим сургалтанд шилжихээр хангасан бэлтгэл ажил,
- СӨБ болон бага, дунд боловсролын суралцагчдын теле хичээлд хамрагдалтын мэдээг сүүлийн 5 сараар аймаг, сум, хот хөдөөгөөр ангилсан байдлаар, төрийн өмчийн их дээд сургуулиудын онлайн хичээлд хамрагдалтын тоон мэдээлэл,
- сургалт зайн хэлбэрт шилжсэнтэй холбоотой гарсан боловсролын салбарын төсвийн хэмнэлт, хэтрэлт, дахин хуваарилалттай холбоотой мэдээлэл,
- боловсролын салбарын халдварт өвчний үеийн бэлэн байдлыг хангах, хариу үйлдэл үзүүлэх, сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, боловсролын байгууллагын үйл ажиллагаа эхлэхэд аюулгүй байдлыг хангах чиглэлээр авсан гадаад зээл тусламж, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн нэгдсэн мэдээлэл авахыг хүссэн.

Энэхүү албан бичигт 6-р сарын 30-нд цахимаар хариу өгсөн ч дээрх чиглэлээр бүрэн мэдээлэл өгөөгүй. Удаа дараа шаардаж, хариу авч чадаагүй учир Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу дээд шатны албан тушаалтанд хандсанаар БСШУСЯ-наас 7-р сарын 29-нд хариу ирүүлсэн. Боловсрол эвсэл мониторингийн тайлан бэлтгэхээр хэд хэдэн төрийн болон олон улсын байгууллагад хандахад Харилцаа холбооны зохицуулах газар, Хүүхдийг ивээх сан, ҮСХ, НЭМХ зэрэг газрууд хуулийн хугацаанд хүссэн мэдээллийг гаргаж өгсөн бол Сангийн яам, НХХЯ зэрэг төрийн байгууллагууд хүссэн мэдээллийг гаргаж өгөөгүй, туйлын хойрго хандсан гэдгийг тэмдэглэх нь

зүйтэй.

ИНБ-ууд, Хүний эрхийн ТББ-уудын форумаас УИХ-ын дарга Г.Занданшатар болон Монгол улсад суугаа 16 орны Элчин сайдын яамдад коронавирусын халдварт цар тахлын үед Монгол улсад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах талаар санал хүргүүлэхэд Боловсрол эвсэл идэвхтэй хамтран ажиллаж, санал боловсруулахад оролцсон. Үүнд:

- Хүний эрхийн ТББ-уудын Форумаас Монгол Улсын Их Хурлын Дарга Г.Занданшатарт санал хүргүүлсэн 2020.04.17 №4

Саналын агуулга нь: Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын хүний эрхийн гэрээний дагуу онц болон дайны байдал зарласан тохиолдолд ч хязгаарлаж үл болох туйлын эрхүүд бий тул эдгээр эрхийг цар тахлын үед ч мөн хязгаарлаж, зөрчиж болохгүй болохыг тодорхой хуульчлах шаардлагатай. Мөн Үндсэн хуульд заасан бүх гол нөхцөлийг нэгэн зэрэг хангасан зайлшгүй тохиолдолд туйлын эрхээс бусад үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлаж болох хэдий ч (1) үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах; (2) хязгаарлалт нь үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн хэв журмыг хамгаалах гэсэн ашиг сонирхлын төлөө байх; (3) хязгаарлалт нь гагцхүү энэ зорилгод хүрэхэд зайлшгүй бөгөөд тохирсон байх; (4) ялгаварлан гадуурхахгүй байх; (5) хараат бус шүүхээр хянагддаг байх Үндсэн хуулийн зарчмыг шинээр батлах гэж буй Цар тахлын эсрэг хуульд анхаарч тусгахыг санал болгож байна. Мөн Гамшгаас хамгаалах тухай болон Онц байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд ч эдгээр шаардлагыг тусгах нь зүйтэй.

Мөн тус хуулиар нийгмийн эмзэг бүлгийн наад захын хэрэгцээ шаардлагыг анхаарч үзсэн, эрхийн байдлыг дордуулахгүй байх үүднээс тэдний эрүүл, аюулгүй хоол хүнс, ундны цэвэр усаар хангагдах, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох, орон байртай байх, мэдээлэл олж авах, шийдвэр гаргах үйл явцад оролцох, ялгаварлан гадуурхагдахгүй байх эрхийг баталгаажуулсан зохицуулалтыг онцгой анхаарч үзэх шаардлагатай байна. Мөн Ковид 19 цар тахлын дэгдэлтийн үед эмэгтэйчүүдийн эрхийг дордуулсан шийдвэр гаргахгүй байх үүднээс жендэрийн тэгш байдлыг тусгасан зарчим, зохицуулалтыг хуульд тусгахыг зөвлөж байна. Мөн хөл хорионы дэглэмээс үүдэлтэй гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил өсч байгааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх шуурхай хариу үйлдлийг хуульдаа тусгах нь зүйтэй гэж үзэж тодорхой саналууд хүргүүлсэн.

- Хүний эрхийн ТББ-уудын Форумаас Монгол Улсын Их Хурлын Дарга Г.Занданшатарт санал хүргүүлсэн 2020.04.23 №5

2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хүргүүлсэн саналыг тусгасанд талархаж, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуулийн төсөл болон Гамшгаас хамгаалах тухай, Зөрчлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд хүний эрхийн хязгаарлалтад тавих зарчмыг тусгайлан

тусгасныг тун чухал алхам хэмээн үзэж байна. Харин тодорхой зүйл заалт дах хүний эрхийн хязгаарлалт, ногдуулах хариуцлага нь хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд үл нийцэж байгааг дурдан, тодорхой саналууд хүргүүлсэн.

- Хүний эрхийн ТББ-уудын Форумас Монгол Улсад суугаа 16 орны Элчин сайдад албан бичиг хүргүүлсэн 2020.6.18 №11

Монгол Улсад ирж буй тусламжийн дийлэнх хэсэг нь мөн л зээлийн хэлбэрээр олгогдож байгаа тул энэхүү хөрөнгийг эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой зайлшгүй хэрэгцээ, КОВИД-19 тархахаас сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах, тус хөрөнгийг салбарын бүтцийн өөрчлөлт, засаглал, төр-хувийн хэвшлийн түншлэл хөгжүүлэх зэрэг шууд хамааралгүй үйл ажиллагаанд зарцуулахгүй байх,

Санхүүжилтийг үр ашигтай зарцуулах, санхүүжилтийн ил тод байдлыг хангах замаар авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахи арга хэмжээ авахад нь техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх,

КОВИД-19-ийн үеийн эдийн засгийн бодлого тодорхойлохдоо хүний эрхэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийх, хэрэгжүүлэх явц болон хэрэгжиж дууссаны дараа хүний эрхийн чиглэлээр тавьсан зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх шаардлагатай. Бодлогоо тодорхойлохдоо “хэнийг ч ардаа орхихгүй” гэсэн Тогтвортой хөгжлийн зорилгод нийцүүлэх, тиймээс нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөнд хамгийн ихээр өртөж буй эмзэг бүлгийн иргэдэд зориулсан “ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР” боловсруулан хэрэгжүүлэх, ингэхдээ хөтөлбөрийг төлөвлөх, батлах, гүйцэтгэх, хяналт тавих бүхий л шатанд иргэд, иргэний нийгмийн эрх тэгш оролцоог хангах, үүний тулд дараах асуудалд түлхүү анхаарч оролцох, ажиллах:

- Эмзэг бүлгийн иргэд, хүүхэд, эмэгтэйчүүдийг хоол хүнс, эрүүл ахуй, халдвараас сэргийлэх хамгаалах хэрэгслээр хангах;
- Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах байрны санхүүжилтийг яаралтай шийдэх зохион байгуулалтыг хийх;
- Өрх толгойлсон, орлого багатай зэрэг эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн ажлын байрыг хадгалах, түрээсийг шийдэх, бизнес нь шинэ нөхцөлд дасан зохицоход зориулсан сан ажиллуулах;
- Эмзэг бүлгийн иргэдийн ус, цахилгааны төлбөрийг төлөөгүй гэсэн үндэслэлээр таслахгүй байх, бусад шаардлагатай хамгаалах арга хэмжээ авах.
- КОВИД-19-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх явцдаа НҮБ-ын хүний эрхийн механизмуудаас гаргаж буй зөвлөмж, удирдамжийг судалж, бодлогодоо тусгах,

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Нийгмийн эгэх хариуцлагын зорилгод маш өргөн хүрээний мэдээлэл (Information)-ээр хангах шаардлагатай бөгөөд энэ нь мэдээллийг бэлтгэх, хэрэглэгчдэд ойлгомжтой хэлбэрт оруулах, олон нийтэд дэлгэх зэрэг үйлдлийг агуулсан цогц систем юм. Мэдээлэл нь бодит, хүртээмжтэй, хэрэглэгдэхүйц байх шаардлагыг хангасан байх шаардлагатай.

БСШУЯ-ны вебсайтад тоон мэдээлэл байнга байршдаг. Үүнээс үзэхэд, ковидын үед Монгол улсад 1,059,145 хүүхэд залуус буюу хүн амын 1/3 нь боловсролын үйлчилгээ авч байна.

Салбарын ерөнхий мэдээлэл (БШУЯ, БМДИ)

- СӨБ – 263,333 хүүхэд; 12,617 багш; 1.439 байгууллагад
- ЕБС – 640,449 суралцагч; 32,800 багш; 803 сургуульд
- НТБ – 6,917 хүүхэд (дүйцсэн хөтөлбөр); 388 багш;
- Дээд боловсрол – 148,446 оюутан; 7,315 багш; 95 сургалтын байгууллагад

Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтийн цар тахлын үеийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг фейсбүүк хуудаснаас нь харахад дараах мэдээлэл байсан. Үүнд:

2019 - 2020 оны хичээлийн жилд 10 дахь жилдээ ажиллаж буй ЕБС, цэцэрлэгийн багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын онлайн хэсэг нь явагдаж дуусаад, танхимын сургалтууд явагдаж 999 суралцагчдад батламж олгоод байсан юм. Харин Шинэ төрлийн коронавирусийн халдвар дэлхий нийтэд хурдацтай тархаж буйтай холбогдуулан Улсын онцгой комиссоос хорио цээрийн дэглэм тогтоож, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 64 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, “Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг онлайн хэлбэрт шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/105 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд 2020 оны Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн танхимын сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулахаар болсон.

Энэхүү цахим сургалтыг Эй Плас интернэйшнл компанийн aplus.mn систем дээр танхимын сургалтад заах байсан нийтлэг гурван агуулгыг бэлтгэн зохион байгуулсан юм. Үүнд:

- Судалгааны арга зүй
- Мэдээлэл харилцааны технологи
- Хичээл төлөвлөх арга зүй (ЕБС эсвэл СӨБ)

Суралцагч, эцэг, эхээс элсэлтийн ерөнхий шалгалтад оролцох суралцагчдад танхимаар давтлага өгөх асуудлыг боловсролын яаманд удаа дараа хандан

хүсэлт гаргасан тул Боловсролын үнэлгээний төвөөс 2020 оны 4 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд онлайн санал асуулга авсан. Энэхүү санал асуулгад 14094 суралцагч, 10711 эцэг эх оролцож, 81.2 хувь нь 12 дугаар ангийн суралцагчдад танхимаар давтлага авах саналыг дэвшүүлсэн байна.

Энэ асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны тавдугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж зөвшөөрсний дагуу элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдын эцэг, эхийн хүсэлтийг үндэслэн, зөвхөн сургуулийн орчинд халдвар, хамгааллын дэглэм баримтлан 2020 оны тавдугаар сарын 11-ний өдрөөс эхлэн нэг сарын хугацаатай зохион байгуулж эхлүүлээд байна.

Коронавируст халдвар (COVID-19)-ын тархалтын үед улс, орнуудын боловсролын салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг хайх, орчуулах, цахим хуудаст байрлуулах ажлыг 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс эхлүүлж өдөр бүр гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар гадаад улс, орнуудад авч, хэрэгжүүлж буй арга хэмжээ, судлаач, эрдэмтдийн байр, суурь, ЮНЕСКО-гийн цахим хурлын талаар нийтдээ 31 мэдээ буюу 34 хуудас орчуулгын материал бэлтгээд байна.

БСШУСЯ-наас цахим хуудсандаа үйл ажиллагааны тайлан мэдээллийг 1-7 сарын хугацаанд тавьж, Ковид-19 халдварын үеэр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа тайлагнаж, олон нийтэд нээлттэй ажилласан байна.

ТӨР-ИРГЭНИЙ ХАРИЛЦААНЫ ТАЛБАР

Нийгмийн эгэх хариуцлагын үйл явц нь маш цогц ба төр, иргэн гэсэн талуудын хооронд үүсэх иж бүрэн харилцааг хамаардаг. Энэ нь **төр – иргэний харилцааны талбар** (citizen – state Interface)-т хэрэгжинэ. Төр иргэн хоёр харилцах талбартай байж сая нийгмийн эгэх хариуцлагын санаачилга хэрэгжих боломж бүрдэнэ. Төр - иргэний харилцааны энэ чухал талбарт онцгой байдлын үед Боловсролын кластер (Education Cluster) бүтэц ажиллаж байна. Боловсролын кластер бүтэц үндэсний түвшинд ажиллаж байгаа талаар ИНБ-ын төлөөллөөр оролцдог. Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг (БХАН)-ийн захирал Б.Батжаргалаас мэдээлэл авахад дараах хариултыг өглөө. Үүнд: Дэлхийн хэмжээнд хүмүүнлэгийн баг ажилладаг, үүнд олон улсын байгууллагууд болох ЮНИСЕФ, Хүүхдийг ивээх сан зэрэг байгууллагууд ордог. Энэ бүтэц улс үндэсний түвшинд бууж ажилладаг бөгөөд Монгол улсад 14 кластер байдаг. Үүний нэг нь Боловсролын кластер бүтэц ба энэхүү үндэсний НҮБ-ын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг Ивээх Сан, БШУЯ, Улаан загалмай нийгэмлэг, Онцгой байдлын газар, Дэлхийн зөн, ГБХЗГ (төлөөлөл ирдэггүй), ИНБ болон сүүлд нэмэгдэж орсон НҮБ-ын Хүн амын сан хамтран ажилладаг. БХАН 2015 оноос энэ бүтэцэд ажиллаж байна. Улиралд 1 удаа хуралддаг байсан, ковид гарснаас хойш сар бүр хуралддаг болсон. Хурлаар онцгой байдлын үед хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлж байна. Бид

ковидын үед хариу арга хэмжээ авах ажлын хэсэгт орж саналаа тусган ажиллаж байна. Үүнд боловсролын яамнаас гаргах шийдвэр, журамд санал өгсөн. Бусад орны туршлагыг судлах, хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, маргинальчлагдсан бүлгийн хүүхдүүдийн эрхийг хамгаалах талаар илүү санал хэлж тусгадаг. Мөн нөхцөл байдлыг үнэлэх, ямар арга хэмжээ авахад саналаа хэлж, дүрэм журам боловсруулах зэрэг ажлын хэсэгт орж ажиллаж байна.

Ковид 19-ын үед Хүүхдийг Ивээх Сан НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран Боловсролын бүлгийн (кластер) үйл ажиллагааг удирдан, нэгдсэн зохицуулалтаар хангаж ажиллав.

Боловсролын салбар дах төр-иргэний нийгмийн болон бусад оролцогч талуудын хамтрах нэг талбар бол «Боловсролын салбарын зөвлөлдөх бүлэг» (Local Education group) нь Боловсролын хандивлагчдын зөвлөлдөх механизмын жишгээр байгуулагдсан юм. Тус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бүлэг нь хөгжлийн түнш байгууллага (ХТБ), иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) болон төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн, 2018 оны 2-р сараас хойш тогтмол уулзаж, Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (БСДХХТ) боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэж, салбарын дүн шинжилгээ хийх, төлөвлөгөөг боловсруулах бүх үе шатанд оролцжээ.

Боловсролын салбарын зөвлөлдөх бүлгийг тодорхой гишүүнчлэлтэй болгон (Төр, ХТ, ИНБ), заасан хугацаанд тогтмол хуралддаг эсвэл шаардлагатай үед илүү ойрхон хуралддаг байх албан ёсны зөвлөл болгохыг бусад талууд Боловсролын яаманд зөвлөсөн.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих ба тодорхой хугацаанд хяналт үнэлгээ, шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд нэмэлт судалгаа хийх, жил бүр бүх оролцогч талуудын төлөөллийг оролцуулсан төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх хурлыг зохион байгуулах бүтцийг БСДХХТ-нд тусгасан бөгөөд хүлээх үүрэг хариуцлага, үйл ажиллагааны хүрээг тусгасан баримт бичгийг яамнаас батлан гаргах гэж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хэмжээнд ажиллах шуурхай ажлын хэсгийг байгуулж, тус яаманд хандан иргэд, аж ахуй нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах 1800-1209 дугаарын утас, 1209@mes.gov.mn и-мэйл хаягийг шинээр байгуулан иргэд, олон нийтийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.

ДҮГНЭЛТ

- Бага, дунд боловсролын тухай хуулийн “нутаг дэвсгэрийн...нийтийг хамарсан гамшигтай холбогдуулан онцгой дэглэм, хорио цээр тогтоосон нөхцөлийг харгалзан ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацааг аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан

боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн үед нь өөрчилж болно.” (15.3.) гэсэн заалт; СӨБ-ын тухай хуулийн “... нийтийг хамарсан гамшигтай холбогдуулан тогтоосон онцгой дэглэм, хорио цээрийг харгалзан цэцэрлэгийн хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацааг аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухай бүрд нь өөрчилж болно. (9.3.) гэсэн заалтуудыг үндэслэн бүх шатны боловсрол сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоож, цахим болон теле хичээл зохион байгуулах төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан байна.

- Зөвхөн цахим хичээл сургалттай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах бус салбарын хэмжээнд СӨБ, БДБ-ын дэд салбартай холбоотойгоор авч үзэхэд зохицуулалт хийх маш олон асуудлууд гарч ирж байсан байна. Тухайлбал, олимпиад, уралдаан, тэмцээнийг цуцлах, 1 ба 10-р ангийн элсэлт, анги төгсөлт, анги дэвших, багшид мэргэжлийн зэрэг олгох, зун явагддаг албан бус сургалт, хувилбарт сургалтыг түр зогсоох, улсын шалгалт болон ЭЕШ-ыг зохион байгуулах, боловсролын чанарын судалгаа үнэлгээ хойшлуулах, дотуур байрны үйл ажиллагаа, багш нарын амралт, цалин хөлс, сургуулийн засвар үйлчилгээ, сурах бичиг, номын сан, хувийн хэрэг, журнал хөтлөлт зэрэг олон асуудлуудыг шийдвэрлэх, заавар, удирдамж гаргах зэргээр ачаалал нэмэгдсэн байна.
- Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгаар теле болон цахим хичээл бэлтгэн зохион байгуулах бэлтгэл хангагдаагүй байсан. 2020 оны 4 сарын 29-нд батлагдсан “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулсан, хязгаарласан тохиолдолд цахим, эсхүл бусад хэлбэрээр зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй хүргэх арга хэмжээг боловсролын салбарт авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосноор эрх зүйн орчин бүрдсэн.
- Манай улсын хувьд дээр дурдсанчлан, зайн сургалтыг 2000 оны эхэн үеэс хөгжүүлж, 2002 оноос “Зайн сургалтын үндэсний хөтөлбөр”, 2005-2012 оны хооронд хэрэгжүүлсэн “Цахим Монгол үндэсний хөтөлбөр”, 2012-2016 оны хооронд “Нэг Монгол санаачилга” зэрэг хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн байсан боловч нийтээр зайны сургалтад шилжих шийдвэр гарах үед орчин үеийн түвшинд суралцагчдын эрэлт хэрэгцээг хангахуйц хууль эрх зүйн орчныг ч, хэрэгжүүлэх системийг ч цогцоор нь бий болгож хараахан чадаагүй, одоогийн үүсээд байгаа нөхцөл байдалд 100 хувь зайн сургалтад шилжин ажиллахад бэлэн бус байсан гэж мэргэжилтнүүд үзэж байна.

- Мөн зайн сургалтыг зохион байгуулах техникийн нөхцөл байдал хангалтгүй, өөрөөр хэлбэл сургууль, багш болгонд зайн сургалтын тоног төхөөрөмж, хэрэгсэл хүртээмжгүй байсан ба интернетийн сүлжээний хурд хангалтгүй байсан гэж үзэж болохоор байна.
- Цахим болон теле хичээлийн мэдээ мэдээллийг гаргах, сургалтын үйл ажиллагаанд хэн хамрагдаж чадахгүй байгааг судлаагүй, хариу арга хэмжээ аваагүй байна. Тухайлбал, ЭЕШ-ын дүнд үзүүлсэн нөлөө, теле хичээлийн үр дүнгийн үнэлгээ, шинээр гарсан Ковидын хуулийн холбогдох заалтын хэрэгжилт, хэрэгжилтийн үнэлгээ, алслагдмал нутагт амьдарч байгаа хүүхэд, нийгэм-эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхдэд чиглэсэн арга хэмжээний талаар мэдээлэл байхгүй байна.
- Боловсролын салбарт гарсан тушаал шийдвэрүүдийг харахад зөвхөн салбарын ажилтнуудад хандсан биш эцэг эх, оюутан суралцагч, гэр бүлд хандсан удирдамж, зөвлөмж гарсан нь талархууштай. Гэвч ковидын үед гарсан салбарын хүрээнд хэрэгжих шийдвэр, зөвлөмж, чиглүүлгийг нэг дороос авах боломжгүй, энэ үеэр авч хэрэгжүүлсэн төсөв санхүү, үйл ажиллагааны мэдээлэл ил тод, нээлттэй биш байна.
- Боловсролын бүх шат түвшинд сургалтын үйл ажиллагаа жигд явагдсан гэсэн хангалттай нотолгоо олдсонгүй. Их дээд сургуулиуд, коллеж, төрийн бус өмчийн бүх шатны боловсрол сургалтын байгууллагууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг хамарсан тушаал шийдвэр, зөвлөмж гарсан эсэх, шаардлагатай дата мэдээллийг цуглуулж чадсан эсэх, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд бүрэн хяналт тавьж чадсан эсэх, зохих дэмжлэгийг үзүүлж чадсан эсэх нь эргэлзээтэй байна. Боловсролын салбарт хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний ямар нэг тайлан цахим хуудсанд байхгүй байна.
- Боловсролын кластер, Боловсролын салбарын зөвлөлдөх бүлэг зэрэг боловсролын оролцогч талуудтай зөвлөлдөх механизмууд ажилласан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хэмжээнд ажиллах шуурхай ажлын хэсгийг байгуулж, тус яаманд хандан иргэд, аж ахуй нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах 1800-1209 дугаарын утас, 1209@mecs.gov.mn и-майл хаягийг шинээр байгуулан иргэд, олон нийтийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэн ажиллаж байгаа нь сайшаалтай.
- Цахим болон теле сургалтын чанар, хүртээмжийг шаардсан ИНБ-уудын хүсэлт, шаардлага цөөнгүй гарсан боловч тэдгээр талуудын өгсөн мэдээллээс харахад төрийн хариу үйлдэл буюу, асуудлыг шийдвэрлэхээр авсан арга хэмжээ хангалтгүй байсан гэж дүгнэж болохоор байна. Энэ нь боловсролын үйлчилгээг хүртэгч талууд нэг талаар тогтолцооны асуудлыг хөндөж, урт хугацаанд хөрөнгө мөнгө

дайчилж шийдэхээр асуудлууд гаргаж тавьсан байтал боловсролын салбарын хэмнэгдсэн төсвийг өөр салбар руу татсантай холбоотой байх магадлал байна.

- Сургууль, сургалтын үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо туйлын хангалтгүй байсан нь илэрч, гэрээр хичээллэх үед эцэг эхчүүд бэлтгэлгүй, тэдэнд олон асуудал тулгамдаж байхад хангалттай зөвлөгөө, дэмжлэг, чиглүүлэг өгөгдсөнгүй.
- ЕБС-ийн багш нар цахим хэрэглээг бие даан эзэмшиж сурагчид, эцэг эхчүүдтэй харилцах сайн тал ажиглагдаж байгаа ч багш нарыг цахим хичээл бэлтгэх, зайнаас сурагч, эцэг эхчүүдтэй харилцах нэгдсэн чиглүүлэг, сургалт зохион байгуулсан мэдээлэл байхгүй байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН САНХҮҮЖИЛТ БА КОВИД 19

(Сэдэвчилсэн мониторингийн тайлан)

Боловсролын төсөв санхүүжилтийн хүрээнд тусгайлан танхимаар хичээл ороогүйтэй холбоотой хэмнэгдсэн зардлууд юунд зарцуулагдсан болон 2020 оны боловсролын төсөвт төсөвлөгдөөгүй зайн сургалттай холбоотой зардлуудыг хаанаас санхүүжүүлж байгаа талаар судаллаа. Тухайлбал теле хичээл зохион байгуулсан зардал, хувийн сургуулиуд, МСҮТ, их дээд сургуулиудад гарсан санхүүжилтийн хүндрэлийн талаар, хандивлагчдаас зарцуулсан хөрөнгийн байдалд мониторинг хийхээр шийдсэн юм.

Мониторинг хийх хүрээ:

- Гарсан тушаал шийдвэр
- Боловсролын оролцогч талуудад өгсөн удирдамж, чиглэл
- Зохицуулалт, хэрэгжилтийн байдал
- Тулгамдсан асуудлууд/сорилтууд
- Боломжууд
- Цаашид авах ёстой арга хэмжээний зөвлөмж

Мөн боловсролын санхүүжилтэд цаашид гарч болох эрсдлүүд, тухайлбал ашгийн төлөөх салбар түрж орж ирсэн эсэх, боловсролыг хувьчлах, цахим сургалтыг дэлгэрүүлэхээр лоббидох, боловсролын үндсэн үйл ажиллагааны төсөв хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулах зэрэгт анхаарал хандуулсан. Бид боловсролын 4 шат түвшинг хамрах зорилт тавьсан боловч мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал ХНХЯ-д харъяалагддаг, их, дээд сургууль, коллежийн төөв, санхүүжилт салбарын яамны түвшинд шийдэгддэггүй тул мэдээлэл хомс судалгааны хувьд хязгаарлагдмал үр дүн гарлаа.

Гарсан тушаал шийдвэр

2020 оны 2-р сарын 19-ний өдөр Засгийн газар “Халдварын тархалт буурахгүй” байгаатай холбогдуулан “Бэлэн байдлын шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64-р тогтоолын 2.1-д “Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг түр зогсоох хугацаанд хүүхдийн хоол, үдийн цайны зардлаас хэмнэгдсэн хөрөнгийг бямба гаригт хичээллэх багш, ажилтны цалин хөлс болон тухайн байгууллагад ариутгал, халдваргүйтгэлийн материал худалдан авахад зарцуулах” 2.2-д “ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан теле хичээлийг үргэлжлүүлэх, багш нарын 1, 5, 10 дахь жилийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулахад шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө зохицуулалт хийж шийдвэрлэх” гэж заажээ.

2020 оны 4-р сарын 15-ны өдөр ЗГ коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах” зорилгоор “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 139-р тогтоолоор бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалтын үйл ажиллагааг 2020 оны 9-р сарын 1-ний өдрийг хүртэл зогсоохыг заасан. Мөн тогтоолд “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, сургалтын төвийн, их, дээд сургууль, коллежийн суралцагчдад зориулан зохион байгуулж байгаа теле болон цахим хичээлийг 2020 оны 6-р сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэх”, ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг зохион байгуулах арга хэмжээ авах”, “сургалтын үйл ажиллагааг зогсоосон хугацаанд боловсролын байгууллагын гэрэл, цахилгаан, цэвэр, бохир ус, түлш халаалт зэрэг байр ашиглалттай холбоотой зардлыг хэмнэх зорилгоор шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай” гэжээ.

Цэцэрлэг, сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг бүрэн зогсоох болсонтой холбогдуулан гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, түлш халаалт зэрэг байр ашиглалттай холбоотой зардлыг хэмнэж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, холбогдох чиглэлийг хүргүүллээ.

2020 оны 04 сарын 29 өдөр “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг УИХ-аас батлан гаргасан ба “цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, хямралын эсрэг холбогдох санг арвижуулах зорилгоор жилийн батлагдсан төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх;” (7.1.2. заалт) заалт туссанаар теле хичээл болон бусад зайны сургалттай холбоотой үйл ажиллагаануудыг санхүүжүүлэх албан ёсны хууль эрх зүйн үндэслэл бий болсон гэж үзэж болно.

Мөн түүнчлэн боловсролын төсөв санхүүжилттэй холбоотой дараах зохицуулалтуудыг уг хуулиар хийжээ. Үүнд:

- Энэ хуулийн 7.1.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. (7.3. заалт)
- Өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны хичээл, сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулах, сургалтын төлбөрийг хөнгөлөх, дараагийн төлбөрт шилжүүлэх; (7.1.8. заалт)
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, гадаад улс

орноос өгч байгаа хандивыг Улсын онцгой комисс бүртгэж, зарцуулалтыг олон нийтэд ил тод байлгаж, нэн шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна. (15.1. заалт)

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улсын хувьд ДНБ-д боловсролын салбарын төсвийн эзлэх хувь сүүлийн 10 жилийн дунджаар 4.3-6.5 хувьтай байна. Боловсролын санхүүжилтийн хувьд хэрэглэж болох нэг жишиг бол Засгийн газрын зардлын (төсвийн зардлын) 15-20 хувийг боловсролд зарцуулахыг зөвлөсөн Ослогийн тунхаглал юм. Сүүлийн жилүүдэд дунджаар Монгол улс боловсролын салбарт нэгдсэн төсвийн орлого, зарлагын дунджаар 15-16 хувийг зарцуулж ирсэн байна.

2018 оны байдлаар боловсролын салбарын төсвийн бүтцийг дэд салбараар авч үзвэл 46 хувийг ЕБС, 23 хувийг СӨБ, 18 хувийг боловсролын салбарын удирдлагын зардал, 9 хувийг ДБ, 4 хувийг ТБМБ-ын байгууллагын зардал тус тус эзэлж байна. Боловсролын төсвийн дийлэнх буюу 90 орчим хувь нь урсгал зардалд зарцуулагдаж байна.

Сүүлийн 5 жилийн төрийн өмчийн СӨББ-ын санхүүжилтийн бүтцийг авч үзвэл үндсэндээ 100 хувь төсвийн хөрөнгөөр санхүүжиж байна. Мөн СӨББ-ын хувьсах зардалд голлох хувийг хүүхдийн хоолны зардал эзэлж байна. Одоогийн байдлаар төрийн өмчийн цэцэрлэгт хүмүүждэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардалд төрөөс 1650 төгрөг, 24 цагаар ажилладаг цэцэрлэгийн нэг хүүхдийн нэг хоногийн хоолны зардалд 2400 төгрөгийг төсөвлөн олгож байна. СӨББ-ын урсгал зардлын бүтцийг сүүлийн 10 жилийн байдлаар авч үзвэл дунджаар 88 орчим хувийг хувьсах зардал, 12 орчим хувийг тогтмол зардал эзэлж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар ЕБС-ийн зардлын 98 орчим хувийг зөвхөн улсын төсвийн санхүүжилт бүрдүүлж байна. Боловсролын салбарын төсвийн зарлагын бүтцийг эдийн засгийн ангилалаар авч үзвэл нийт төсвийн 85 орчим хувь нь урсгал зардал, 15 гаруй хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна. Урсгал зардлын бүтцээс харахад ЕБС-ийн хувьсах зардал 84-90 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар урсгал зардлын дийлэнх буюу 77 хувь нь цалин хөлстэй холбоотой зардлууд, 13 хувь нь тогтмол зардал байгаа бол бусад зардал 10 хувийг эзэлж байна. 2018 оны байдлаар 60 орчим хувь нь цалин хөлстэй холбоотой зардлууд, 21.8 хувь нь түлш халаалтын зардал, 4.5 хувь нь гэрэл цахилгаан, цэвэр, бохир усны зардал эзэлж байгаа бол бусад урсгал зардал, эд хогшил худалдан авах зардал, хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, ном, хэвлэл худалдан авах зардлууд нь маш бага хувийг эзэлж байна.

Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэг хүүхдэд ногдох хувьсах зардалд шинжилгээ хийх ажлын удирдамжийг боловсруулан 1 сарын 22-ны өдөр Төрийн нарийн бичгийн

даргаар баталж, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын тооцоо, төлөвлөлт, хэрэгжилтийн бодит нөхцөлийг судлан хуваарилалтын тэгш байдлыг хангуулах зорилгоор 6 сарыг дуустал хугацаанд ажиллах зөвлөх багийг шалгаруулсан боловч өнөөдрийг хүртэл үр дүн нь гараагүй байна

Теле хичээлийн санхүүжилт

Өнөөдрийн байдлаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын байгууллагуудын нийт 32 төрлийн судлагдахуунаар 4800 гаруй цагийн хичээлийг 426 гаруй багш ажиллагсад зааж бэлтгэн Монгол Улсын өргөн нэвтрүүлгийн 18 телевизээр нэвтрүүлж байна. Олон нийтийн дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “Теле хичээлийн эргэн тойронд” нэвтрүүлэг болон 10 төрлийн шторк бүтээн олон нийтэд сурталчлан түгээж байна. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд нэг, тав, арав дахь жилдээ ажиллаж байгаа 5791 багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг онлайн хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулсан. Теле хичээл зохион байгуулах, түгээх, багш нарын онлайн сургалтад шаардагдах зардлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын төсвийн багцад багтаан зохицуулалт хийж, холбогдох шийдвэрийг гарган ажиллаж байна.

Шинэ төрлийн коронавирустай холбоотойгоор өндөржүүлсэн бэлэн байдлын үед зохион байгуулсан теле болон онлайн хичээл, төгсөх ангийн буюу 12-р ангийн сурагчдад элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэхэд зориулсан DVD гарын авлага боловсруулахад шаардагдах 638.7 сая төгрөгийн санхүүжилтийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын төсвийн багцын “хөтөлбөр, арга хэмжээний зардал”-аас 6 удаагийн тушаалаар санхүүжүүлж ажилласан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд Г.Ганбаяр Монголын телевизүүдийн холбооны гүйцэтгэх захирал Т.Ганзул нар 2020 оны 1-р сарын 24-ний өдөр уулзан, Монголын телевизүүдийн холбооны гишүүн 18 телевиз нийгмийн хариуцлагын хүрээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн анги тус бүрээр хуваарилан авч, теле хичээлийн бичлэг хийх, монтажлах, эфирт бэлтгэх, нэвтрүүлэн ажиллахаар тохиролцсон байна. Монголын үндэсний олон нийтийн телевиз өөрийн сувгуудаар бэлтгэсэн теле хичээлийг нэвтрүүлж хамтран ажилласан. Боловсролын чиглэлээр контент бэлтгэдэг 4 байгууллагатай үнэ төлбөргүйгээр өөрсдийн хөгжүүлдэг вэб хуудасд байршуулах саналыг ирүүлснээр мөн хамтран ажилласан. Иймд теле хичээлийг зохион байгуулахад ямарваа нэг зардал төсвөөс гараагүй гэж үзэж болохоор байна.

Суралцагч, эцэг, эхээс элсэлтийн ерөнхий шалгалтад оролцох суралцагчдад танхимаар давтлага өгөх асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны тавдугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж зөвшөөрсний дагуу элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдын эцэг, эхийн хүсэлтийг үндэслэн, зөвхөн сургуулийн орчинд халдвар, хамгааллын дэглэм баримтлан 2020 оны

тавдугаар сарын 11-ний өдрөөс эхлэн нэг сарын хугацаатай зохион байгуулсан байна.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТӨВ, ИХ ДЭЭД СУРГУУЛИУДЫН ТӨСӨВ САНХҮҮЖИЛТ

Дээд боловсролын түвшинд их дээд сургууль, коллежууд өөрсдийн байгууллагын түвшинд төсвийн зохицуулалт хийж, зохих шийдвэрийг гаргаж ажилласан байх магадлал байна. Тухайлбал, МУИС-ийн захирал 2020 оны 3 сарын 31-нд шуурхай зохион байгуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэх тухай тушаал гаргаж, гарах нэмэлт зардлуудын төсвийг батлан зарцуулах, шуурхай арга хэмжээний үед илүү цагаар ажиллаж байгаа ажилтнуудад илүү цагийн хөлс олгохоор шийдвэрлэж ажилласан байна. Тус цахим сургалттай холбоотойгоор БСШУС-ын яамнаас оюутан залуучуудын сурч боловсрох эрх зөрчигдөхгүй байх журам, шийдвэрийг гаргаагүй бөгөөд оюутнуудад сонголтыг нэг талыг харан, их, дээд сургуулиудад хяналт тавьж ажиллахгүй байна.

Монголын оюутны холбооны зүгээс 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдөр 1а/013 тоот албан бичгээр БСШУСЯ-нд цахим сургалтыг сайжруулах болон оюутан суралцагчдын эрх нь зөрчигдөхгүй байхаар шийдвэр, арга хэмжээ авах шаардлага хүргүүлсэн бөгөөд төлбөрөө төлөх бололцоогүй оюутнуудын хувьд Боловсролын зээлийн сангийн тавигдах шаардлагыг уян хатан болгож, 2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улиралд зээл авах нөхцөл боломжийг бий болгох хүсэлт багтсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд зайн сургалтад шилжсэнтэй холбоотойгоор МСҮТ-ийн төсвийн хэтрэлт, хэмнэлтийн талаар мэдээлэл өгөхийг хүсч албан бичиг өгөхөд хариу ирүүлээгүй юм.

“ХУВИЙН ХЭВШЛИЙН ЦЭЦЭРЛЭГ, ЕБС, КОЛЛЕЖ, ИХ ДЭЭД СУРГУУЛИУДЫН ТӨСӨВ САНХҮҮЖИЛТ”

Хэрэглэгчдээс ирэх санал хүсэлт, гомдлыг шуурхай авч шийдвэрлэх, хариу өгөх зорилгоор 1209@mecs.gov.mn цахим хаяг болон 1800-1209 тоот шуурхай утсыг ажиллуулж байна. 4-р сарын байдлаар 1209@mecs.gov.mn цахим хаягт 4, 1800-1209 тоот шуурхай утсанд 150 санал хүсэлт, гомдол ирснээс 80 дуудлага буюу 55 хувийг иргэдийн гомдол хүсэлт эзэлж байна. Нийт гомдлын 80 хувийг их, дээд сургууль болон төрийн бус өмчийн ЕБС-ийн сургалтын төлбөр төлөхтэй холбоотой гарч буй хүндрэлийг багасгах талаар бол 20 хувийг улсын сургуулиудын гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөрийн төлбөр болон багш нарын цалин, анги засварын мөнгөтэй холбоотой гомдол эзэлж байна.

“Шударга ёсны манаанд” НҮТББ-ын 2020 оны 3 сарын 23-нд БСШУС-ын сайд Ё. Баатарбилэгт хандан хувийн болон төлбөртэй цэцэрлэг, ЕБС, коллеж, их дээд

сургуулиудад 2019-2020 оны хичээлийн жилд төлсөн сургалтын төлбөрөөс 2020-2021 оны хичээлийн жилд 30-50 хүртэлх хувиар дүйцүүлэн хөнгөлөлт үзүүлэх шаардлагыг тухайн байгууллагуудад хүргүүлэх хүсэлт гаргасан байна. Тэд хувийн цэцэрлэг, сургуулиудын олох ашгийг судлан тооцоолж гаргаад, онцгой дэглэмийн нөхцөл байдлыг далимдуулан хувь хүн, ААНБ өөрсдөдөө давуу байдал олгох нь хууль, шударга ёсонд үл нийцнэ гэж үзэж байгаагаа илэрхийлжээ.

Тус байгууллагын сүүлийн 2 сард хийсэн тойм судалгаагаар цэцэрлэг (ЕБС)-ийн төлбөрийн зарцуулалт

Зардлууд	Хувийн цэцэрлэг	Хувийн ЕБС	Хувийн ИДС, коллеж
Байр ашиглалт	30-35%	(40-50%)	40-50%
Хүүхдийн хоол цай	20-25%	(10-15%)	-
Цалин хөлс, НД	25-30%	25-30%	20-25%
Сургалтын хөтөлбөрийн зардал	10-15%	10-15%	10-15%
Ашиг, хөрөнгө оруулалт	10-20%	10-20%	15-20%

**Төрөөс олгодог хувьсах зардал дээрх тооцоонд ороогүй.*

БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгийг эцэг, эхчүүдтэйгээ зөвшилцөх, тэдний саналыг авч төлбөрийн асуудлыг шийдвэрлэх чиглэл өгсөн байна.

2020 оны 04 сарын 10-нд тус төрийн бус байгууллага Монголын хувийн хэвшлийн бага дунд сургуулийн холбоо, хувийн/төлбөртэй ЕБС, цэцэрлэгүүдэд хандан шаардлага хүргүүлжээ. Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгүүдэд цахим сургалт явагдаж байгаа саруудад цахилгаан, цэвэр бохир ус, сургуулийн цэвэрлэгээ, ашиглалтын зардал үлэмж хэмнэгдсэн, хүүхдийн хоолны зардал огт гараагүй, Засгийн газрын шийдвэрийн дагуу байгууллагын төлдөг НДШ-ийг тэглэсэн, төрөөс хувьсах зардлын санхүүжилтыг бүрэн олгосон нөхцөлийг харгалзан нийгмийн хариуцлага, ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагааг дээдлэн сурагчдад 30-50 хувийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэхийг шаардсан байна.

Хувийн сургууль, цэцэрлэгийн захиргаа эцэг эхчүүдтэй огт зөвшилцөөгүй бөгөөд сайдаас өгсөн чиглэлийг хэрэгжүүлээгүй байна. Сургуулиудын зарим нь төлбөрөөсөө зөвхөн хоолны мөнгийг хассан хөнгөлөлт үзүүлсэн ба сургууль, цэцэрлэгүүдийн 50 хувь нь ирэх хичээлийн жилийн төлбөрөө урьдчилан төлөхийг шаардсан байна.

Асуудал шийдэгдээгүй тул 2020 оны 04 сарын 29-нд Шударга, өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газарт хувийн сургууль, цэцэрлэгт хүүхдээ өгдөг эцэг, эхчүүдийг төлөөлөн гомдол гаргажээ. Цахим хэлбэрийн сургалтын чанар, хүрэлцээ, анги танхимд хичээллэснээс тааруу байгаа талаархи эцэг эхчүүдийн гомдол, гэрээр хичээллэх тохиолдолд эцэг, эхийн оролцоо багш нараас илүүтэй болж, хүүхдийнхээ сурлагад цаг зарцуулж байгаа болон төлбөр төлж асрагч

хөлслөх зэргээр нэмэлт зардал гарч байгааг дурдаад, дуу хөгжим, биеийн тамир, гимнастик, урлал гэх мэт хичээл бүрэн орохгүй байгаа тул эдгээр хүчээлүүдэд ногдох төлбөр, холбогдох хэрэгслийн зардлуудыг хасч тооцох, батлагдсан сургалтын хөтөлбөр, хичээлийн хуваарьт туссан хичээлүүдийн орох цагийн тоо эрс цөөрсөн, урсгал зардал хэмнэгдсэн, болон бусад шалтгаанаар 2020-2021 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийг 40-өөс доошгүй хувиар хөнгөлөх шаардлага байгааг дурджээ. Сургуулиуд яаралтай сургалтын төлбөрийн 50%-ийг урьдчилан төлөхийг шаардаж байгаа нь эцэг эхчүүдэд дарамт учруулж хууль зөрчиж байгааг шалгаж шийдвэрлэж өгөхийг хүсчээ.

Цахим сургалттай холбоотой хэмнэгдсэн зардлууд	
1	Халуун ус, хүйтэн ус, саарал (бохир) ус
2	Дулаан (ашиглагдаагүй барилгын дулааныг бууруулсан бөгөөд 2020.04.15-наас эхлэн бүх шатны сургууль, цэцэрлэгийн дулааныг зогсоосон.)
3	Сургууль, цэцэрлэгийн барилгын цэвэрлэгч, үйлчилгээ (цэвэрлэгээний бодис, ариун цэврийн цаас гэх мэт зардал)
4	Цахилгаан (гадна, дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж)
5	Хүүхдийн хоол, цай
6	Харуул хамгаалалт
7	Сургууль, цэцэрлэгүүдийн менежмент, захиргааны зардал
8	Гадаад багш нарын цалин, байр, унаа, нислэг, хоолны зардал
9	Бичиг хэргийн зардал
10	Сургалтын тоног төхөөрөмжийн зардал

Энэ гомдлыг шийдвэрлэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Бат-Эрдэнэ хувийн хэвшлийн дунд сургуулиудад зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

- Салбарын сайдын баталсан тушаал, шийдвэрийг биелүүлэх
- Эцэг эхчүүдтэй гэрээ байгуулахдаа сургалтын төлбөрийн асуудлаар зөвхөн сургуулийн захиргаанаас урьдчилан бэлтгэсэн гэрээний нөхцөлийг тулгадаг аргыг таслан зогсоох
- Сургалтын төлбөрийн төлөх хэмжээ, хугацааг эцэг эхчүүдийн саналыг үндэслэн харилцан зөвшилцөж гэрээнд тусгах
- Сургалтын төлбөрийн хэмжээг өмнөх жилээс нэмэгдүүлэхгүй байх
- Сургалтын төлбөртэй холбоотой асуудлаас шалтгаалж сурагчийг сургуулиас хасах, завсардуулахгүй байхыг зөвлөмжид дурджээ.

Хэрэв сургуулиуд дээрх зөвлөмжийг мөрдөж ажиллахгүй бол Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас хуульд заасны дагуу хариуцлага тооцож, арга хэмжээ авахаа илэрхийлжээ.

Хувийн хэвшлийн цэцэрлэгүүд

Хувийн цэцэрлэг, сургууль, хүүхэд харах үйлчилгээнд жилдээ 50 орчим тэрбум төгрөгийг төсвөөс шилжүүлдэг. Эрхзүйн үндэслэл нь “Хувьсах зардлын дундаж



Фото зургийг IKON.MN-ээс авав.

норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай” Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоол бөгөөд “Хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу улирал тутам олгоно”.

(4.5.заалт) гэж заасан байдаг. 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Сангийн сайдын шийдвэрээр хувийн цэцэрлэгүүдийн тавдугаар сарын хувьсах зардлыг олгохгүй байх, өмнө нь өгсөн зардлыг буцааж татах шийдвэр гарсан байна. Гэтэл Боловсролын сайд төрийн ба төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн багш нарт цалинг нь олгоно гэдэг шийдвэр гаргасан байсантай зөрчилджээ.

Уг шийдвэрийг эсэргүүцэн хувийн цэцэрлэгийн багш нар 2020 оны 5 сарын 19-ны өдөр Сангийн яамны гадна жагсаал зохион байгуулж, Ерөнхий сайд, Сангийн сайд, Боловсролын сайдад санал, шаардлага хүргүүлжээ.

“Хувьсах зардал бол гүйцэтгэлээр нь олгодог санхүүжилт. Бүх шатны сургалтын үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулж гүйцэтгэлээр нь олгодог уг санхүүжилтийг олгох боломжгүй болсон.

Гэхдээ үүнийг олгохгүй байлаа гээд багш, ажилчдыг орхилгүйгээр нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг нь чөлөөлж, гурван сарын хугацаанд сар бүр 200 мянган төгрөг олгохоор шийдвэрлэсэн.

Бэлэн байдлын зэрэгт шилжсэнээр олон байгууллагын үйл ажиллагаа зогсоод байгаа. Тэр бүрт мөнгөн тэтгэмж өгөөд байх боломж нөхцөл хомс байна.

Сангийн яамнаас төсвийн мөнгийг хамгийн үр ашигтайгаар зарцуулах талаар зохицуулах шийдлээ ярилцаж байгаа. Хувьсах зардлыг зогсоож, хэмнэсэн санхүүжилтийг хүүхдийн мөнгийг нэмэх, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх зэрэгт зарцуулж байгаа.

Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга М.Санжаадорж

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСӨВ САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ЭРСДЭЛ

2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр “Боловсролын санхүүжилт” сэдэвчилсэн баг хуралдан мониторингийн хүрээг гарган 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдөр төрийн холбогдох байгууллагуудад хандан дээрх чиглэлээр мэдээлэл хүссэн.

1. 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 21 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам руу МСҮТ, коллежуудад ямар хэлбэрээр сургалтын үйл ажиллагааны явагдсан, болон МСҮТ-ийн төсвийн хэтрэлт, хэмнэлтийн талаар мэдээлэл өгөхийг хүсэхэд хариу ирүүлээгүй бөгөөд албан бичгийн хариу асуун ярихад санхүү төрийн сан мэднэ гэсэн хариу өгч, дахин шаардсан боловч санхүүжилтын талаарх мэдээлэл ирүүлээгүй.
2. 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 23 тоот албан бичгээр Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны хүргүүлсэн албан бичгээр цахим хичээлд шилжсэнтэй холбоотой мэдээллүүд болон төсвийн хэмнэлт, хэтрэлт болон гадаадын зээл тусламжийн санхүүжилтын мэдээллийг ирүүлэхийг хүсэхэд хариуг мэйлээр 06 сарын 30-ны өдөр ирүүлсэн боловч дээрх мэдээллүүдийг огт багтаагаагүй огт өөр мэдээллүүд ирүүлсэн байсан тул хэд хэдэн удаа утсаар холбогдон тодорхой мэдээлэл хүссэн ч уг мэдээллүүдийг огт ирүүлээгүй, төсвийн талаарх мэдээллийг сангийн яамнаас ав гэсэн хариу өгөв. Иймд 07 сарын 07-ны 38 тоот албан бичгээр Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд хуулийн хэрэгжилтийг хангуулж өгөх тухай албан бичиг явуулсанаар ЗГХЭГ-аас 07 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/1704 тоот албан бичгээр БШУЯ-ны Сайд руу албан бичиг хүргүүлсэн. БШУЯ-ны Сайд 07 дугаар сарын 29-ны өдрийн 1а/95 тоот албан бичгээр хариу ирүүлж, төсвөөс 3 сарын хугацаанд давхардсан тоогоор 18 хүртэлх насны 3 сая орчим хүүхдэд 34 тэрбум төгрөг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэгт багш нарыг 55 тэрбум төгрөгөөр урьдчилан сэргийлэх үзлэг хамруулж, АШУҮИС-н эмнэлэгт 2 тэрбум төгрөг тус тус олгосон тухай мэдээлэл өгсөн. Мөн 12-р ангийн сурагчдад ЭЕШ-д бэлтгэхэд зориулж DVD гарын авлагыг 638.7 сая төгрөгийн санхүүжилтээр сайдын төсвийн багцын “хөтөлбөр, арга хэмжээний зардлаас” 6 удаагийн тушаалаар санхүүжүүлсэн гэж мэдээлсэн.
3. 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 22 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлж зайн сургалтад шилжсэнтэй холбоотой төсвийн хэмнэлт, хэтрэлт болон санхүүгийн зээл тусламжийн нэгдсэн мэдээллийг ирүүлж хамтран ажиллахыг хүссэн бичгийн хариуг ирүүлээгүй бөгөөд хариуцсан мэргэжилтэнтэй утсаар холбогдоход өөрсдийн яамны сайтаасаа тухайн мэдээллийг харчих гэсэн хариу өгөв. Шилэн данс цэсэнд байсан мэдээллийг дор оруулав. Боловсролын салбарт зарцуулсан гадаадын зээл санхүүгийн тусламжийн талаарх мэдээлэл Шилэн дансанд байсангүй.

Төсвийн хэмнэлт ба хэтрэлт, зарцуулалт

Ингээд шилэн данс сайтаас 5 саяаас дээш гүйлгээний зардлуудыг шүүхэд:

- Сар бүр байр ашиглалтын үйлчилгээний 25 сая төгрөгийн зардал гарсан байна.
- 3 сарын 9-өөс 3 сарын 31 өдөр хүртэл Имерж медиа ХХК-тай (ETV) 65 сая төгрөгийн гэрээ байгуулж цахим хичээл явуулж байсан байна. Бусад ТВ-үүдийн гэрээ байсангүй.
- 5 сарын 28-ны өдөр Ай Ти Зон ХХК-тай 5.3 сая төгрөгийн гэрээ байгуулж камерийн хэрэгсэл авсан байна.
- 2 сарын 12-ны өдөр 9 сая төгрөгөөр Натурал текстайл групп ХХК-аас дрож авсан
- 2 сарын 21-ний өдөр Монголиан Контент Девелопмент Фактори ХХК-тай 5 сая төгрөгийн гэрээ байгуулж, ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд хорт зуршлаас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах зардал гарчээ.
- 1, 3 ба 6 дугаар саруудад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээ гараагүй байна.

Шилэн данс сайтад төсвийн хэмнэлт хэтрэлтийн тайлан байх боловч тайлбар гэсэн баганад мэдээлэл оруулаагүй байв.

Шилэн данснаас харахад 5 дугаар сарын хүүхдийн мөнгө 11.8 тэрбум төгрөгийг Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Ерөнхий Газар руу шилжүүлсэн зөвхөн нэг сарын мэдээлэл байлаа. БШУЯ-аас ирүүлсэн мэдээгээр төсвийн мөнгөнөөс давхардсан тоогоор 3 сая хүүхдэд сар бүр 10.000 төгрөгийг 3 сарын хугацаанд олгож, нийт 34.9 тэрбум төгрөг зарцуулсан гэжээ.

“Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг баталж, Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолын “Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотойгоор сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлгийн зардлын хэмнэлтээс 18 хүртэлх насны бүх хүүхдэд сар бүр 100 мянган төгрөгийг гурван сарын хугацаанд олгох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх” Засгийн газрын 2020 оны 98 дугаар тогтоолоор “Шинэ коронавирус /Ковид-19/-ийн цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан боловсролын салбарын багш, алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хэвтүүлэн эмчлэх бэлтгэл ажлыг шуурхай хангах зорилгоор нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хуваарилсан тусгай зориулалттай зардлын хэмнэлтийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэгт шилжүүлэн зарцуулах зохицуулалтын арга хэмжээ авах” арга хэмжээний хүрээнд аймаг, нийслэлээс 54,2 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцоо гарсан. 2020 оны 7 дугаар сарын 9-ний байдлаар 55.3 тэрбум төгрөг хэмнэлтийн 100900015902 тоот дансанд хуримтлагдаад байна. Ерөнхий боловсролын сургуулийн хувьд 2,5 тэрбум төгрөгийг дутуу, хүүхдийн цэцэрлэгийн 3,5 тэрбум төгрөгийг илүү

төвлөрүүлсэн байна. Үүнээс Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Дорнод Дундговь, Завхан, Өвөрхангай, Дархан-Уул, Говь-Сүмбэр аймгууд хуваарийн дагуу бүрэн төвлөрүүлсэн.

Хандивлагчдын мэдээлэл

Шилэн дансны мэдээллээс харахад 4 дүгээр сард НҮБ-ын Хүүхдийн сангаас 140 сая төгрөгийн орлого орсон боловч зориулалт, гэрээ зэрэг дагалдах материал байхгүй.

Тус яамны зүгээс гадаад улсын санхүүжилттэй төсөл, хөтөлбөр, олон улсын байгууллагаас Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор тусгайлан зээл, тусламж санхүүжилт одоогийн байдлаар аваагүй гэдгээ албан ёсоор мэдэгдсэн.

НҮБ-ийн Хүүхдийн Сангийн ковидын үеийн дата цуглуулах, боловсролыг тасралтгүй олгох, хүүхэд хамгаалал, эрсдлийн үеийн мэдээлэл, ариун цэврийн хэрэгсэл, эрүүл мэнд, хоол тэжээлийн үйлчилгээ зэрэгт нийтдээ 2,05 сая ам долларыг зарцуулсан байна. Мөн 178 лам хүүхдүүдийг Энэтхэг улсаас эх оронд нь авчрахад тусламж үзүүлсэн байна. Хүүхдүүдийн 70% гаруй нь онгоцны тийзийн үнэ, тусгаарлах байрын зардлаа даах боломжгүй байсан байна.

Хүүхдийг Ивээх Сангийн өгсөн мэдээллээр 2020.03.01-2020.06.30-ны тайлант хугацаанд КОВИД-19 цар тахлын үед хэрэгжүүлсэн хүмүүнлэгийн үйл ажиллагаанд 30.6 сая төгрөгийг төсөвлөн зарцуулсан байна.

№	Үйл ажиллагаа	Мөнгөн дүн	Хэн
1	2020-2021 оны хичээлийн жилд сургуульд элсэн суралцах хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зориулсан “Та хүүхдэдээ сургуульд орохын өмнө хэрхэн туслах вэ?” гарын авлага хэвлэн тараах 81,000 хувь хэвлүүлэн бүх аймаг, дүүргийн боловсролын газар хэлтсүүдэд тараав.	20 сая төгрөг	Хүүхдийг Ивээх Сан, НҮБ-ын Хүүхдийн сангийн санаачилгаар БСШУСЯ-тай хамтран
2	Зорилтот бүлэгт тулгамдаад буй асуудал, тэдэнд хэрэгтэй байгаа мэдээлэл, зөвлөмжийг мэдэх зорилгоор хоёр асуумж бүхий цахим судалгаа, Олон нийт, эцэг эх, хүүхдэд зориулсан нийгэм-сэтгэлзүйн зөвлөмж, мэдээлэл боловсруулж, цахимаар түгээх	3.7 сая төгрөг	www.gogo.mn, www.ikon.mn, www.maamuu.mn, www.yolo.mn цахим хаягаар олон нийтэд түгээв. Хүүхдийг Ивээх Сангийн өөрийн фейсбүүк хуудас болон Гэр Бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газрын хуудсаар тус тус түгээн дэлгэрүүлэв.

3	Хүүхэд, гэр бүлд нийгэм-сэтгэлзүйн анхны тусламж үзүүлэх хоёр өдрийн үндсэн сургалтын агуулгыг багцлан нийт 6 удаагийн цахим хичээл болон сургалтын туршид ашиглах суралцагчийн дасгал ажлын дэвтэр, сургалтын гарын авлага, 3 төрлийн видео бүхий хэрэглэгдэхүүний багцыг боловсруулав бэлтгэв.	4.3 сая төгрөг	ГБХЗХГ-ийн бүх аймаг, дүүргийн нийт 228 холбогдох мэргэжилтэн, ажилтнуудад зориулан цахим сургалтыг боловсруулан хүргэв. Нэг удаагийн үргэлжлэх хичээл 30-45 минутын хугацаатай, видео болон аудио хэлбэрээр бэлтгэв.
4	Тусгаарлагдсан хүүхэд болон тусгаарлагдсан иргэний гэр бүлд зориулсан нийгэм-сэтгэл зүйн зөвлөмж мэдээлэл боловсруулах	1.8 сая	Зөвлөмж-мэдээллийг дараах 3 бүлэгт хандан боловсруулж ГБХЗХГ-т хүргүүлэв. Тусгаарлагдсан: - 10-аас доош насны хүүхдэд - 10-аас дээш насны хүүхдэд - насанд хүрэгчдэд
5	Бага насны хүүхдэд Ковид-19-ийн талаарх хүүхдэд ээлтэй мэдээлэл бүхий материал бэлтгэн, түгээх Бага насны хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан Ковид-19-ийн талаар энгийн, зөв мэдээлэл өгөх, ойлгуулах, тэдний санаа зовнилыг бууруулах зорилгоор гаргасан дараах ном, материалыг боловсруулан түгээв.	2.6 сая төгрөг	“Чи бол миний баатар” хүүхдэд зориулсан зурагт номыг Хүүхдийг Ивээх Сан албан ёсоор зөвшөөрөл авч орчуулан, 3750 ширхгийг хэвлүүлж ОБЕГ, ГБХЗХГ, өөрийн төсөл хөтөлбөр хэрэгждэг 7 аймаг, 3 дүүргийн сургууль, цэцэрлэг, хамтрагч байгууллагад хүргэв.
6	Ковид-19-ийн гэр бүл, хүүхдэд үзүүлж буй нөлөөг судлах түргэвчилсэн үнэлгээ боловсруулах	0,8 сая төгрөг	Өөрийн төсөл хөтөлбөр хэрэгждэг 7 аймаг, 3 дүүргийг хамруулан түргэвчилсэн үнэлгээг өрх, хүүхэд, салбарт ажиллаж буй талууд гэсэн дараах 3 бүлгийг хамруулан хүүхэд хамгаалал, боловсрол, хүнсний аюулгүй байдал ба амьжиргаа гэсэн гурван салбараас авч ажиллав

Эрсдэл

Бид гамшиг, хямралын үед ч сурч боловсрох эрх хамгаалагдаж, сургалтын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах нь энэ төрлийн болон бусад хямралд авах хариу арга хэмжээний хамгийн чухал стратеги байх ёстой гэж үзэж байна.

Монгол улс зайнаас сурах шийдлийг хэрэгжүүлж байгааг бид дэмжиж байгаа ч боловсролын салбарын хэмнэгдсэн төсвийг өөр яамны зардалд шилжүүлэн зарж байгааг буруушааж байна. Төсвийг танаж байгаа нь боловсролд зориулсан

төсвийн төлөвлөлтөд нөлөөлж болзошгүй байна. Бид энэхүү хямралаас бүрэн гарч, эргэн сэргэхийн тулд эрүүл мэнд, боловсрол болон нийгмийн хамгааллын тогтолцоогоо бэхжүүлэх хэрэгтэй тул нийгмийн салбарын төсвийг хэвээр хадгалах, хамгаалах шийдвэр дээрээ хатуу зогсох шаардлагатай байна

Ихэнх ядуу болон эмзэг бүлгийн өрхүүд телевизгүй, цахилгаангүй, утасны сүлжээгүй, интернетэд холбогдоогүй, технологид холбогдох боломжгүй байгааг ИНБ-ууд онцлон тэмдэглэж байна. Энэ байдал нь яваандаа дижитал ялгаатай байдал/хуваагдлыг гүнзгийрүүлж, боловсролын технологийг ашгийн төлөө хөгжүүлэх явдлыг улам хурдасгах магадлалтай. Одоо ч гэсэн мэдээлэл-харилцааны технологийн хувийн компаниуд дижитал сургалтын модуль болон платформуудыг идэвхтэйгээр сурталчилж, зах зээлд хүч түрэн орж ирж өрсөлдөж байгаад болгоомжтой хандах хэрэгтэй байна.

ДҮГНЭЛТ

- Боловсролын тухай хуульд зайны сургалтад нийтээр шилжих тухай зохицуулалт байхгүй, 2020 оны боловсролын төсөвт зайн сургалттай холбоотой ямар нэгэн төсөв төлөвлөгдөөгүй байсан тул тухай бүрд холбогдох эрх бүхий байгууллагаас шийдвэр гаргаж, батлагдсан төсөвтөө зохицуулалт хийж шийдвэрлэх чиглэлийг Засгийн газраас авч ажиллажээ. Тухайлбал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны хөтөлбөр, арга хэмжээний төсвийн хуваарилалтыг шинэчлэн 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/204 дүгээр тушаалаар баталсан.
- 2020 оны 04 сарын 29 өдөр “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль батлагдсанаар боловсролын сайдын төсвийн багцаас өөр сайдын багц руу шилжүүлэн зарах эрх зүйн үндэслэл тавигдсан нь эрсдэлт хүчин зүйл мөн.
- Боловсролын төсөв санхүүжилтийн талаар, ялангуяа теле болно цахим хичээлийн санхүүжилтийн талаарх мэдээллийг хариуцсан төрийн захиргааны байгууллагууд гаргаж өгөхдөө хойрго байгаа нь Төсвийн тухай хуулийн зарчимд нийцэхгүй байна.
- Боловсролын яамнаас гарч байгаа шийдвэрүүд их дээд сургууль, ялангуяа хувийн хэвшлийн боловсрол, сургалтын байгууллагуудын төлбөр, төсвийн хувьд хангалтгүй байсан нь ТББ-уудын хүсэлт шаардлага болон иргэдээс ирсэн санал гомдлоос харагдаж байна.
- Багш нарын зайнаас ажиллах үеийн ачааллыг тооцолгүй, ажлын үнэлгээний аргачлалдаа өөрчлөлт оруулж уян хатан хандалгүй цалин хөлсний зардлаас ихээхэн хэмнэлт гаргасан байгааг анхаарч үзэх шаардлагатай.

Хавсралт 1. Сошиал мэдээ дүн шинжилгээ

Салбар	Асуудал	Жишээ, үндэслэл	Үр дагавар	Санал
Хувийн сургуулиуд	Төлбөрийн асуудал	Хувийн сургууль төрөөс татаас авна, үдийн цайны санхүүжилт авна, сурах бичгээр хангуулна, бусад дэмжлэг их авдаг татварын маш олон хөнгөлөлт эдэлдэг мөн сургалтын байгууллага төлбөрийн баримт ч өгдөггүй	Ажилгүй болсон эцэг эхчүүд хохирч байна	Хувийн хэвшлийн дунд сургуулийн төлбөрийн асуудал дээр яамнаас нэгдсэн нэг бодлого гаргах хэрэгтэй Хувийн сургуулиуд эцэг эхчүүдэд тодорхой хэмжээний төлбөрийн буцаан олголт өгөх хэрэгтэй Хөл хорионд байсан хугацааны төлбөрийг ирэх жилийн сургалтад суулгах эсвэл хөнгөлөх бодлого Хувийн сургууль хүүхдүүдийнхээ төлбөрийг хойшлуулж тооцох
	Онлайн сургалт үр дүн муу байна	Онлайн сургалт орохгүй, даалгавар өгөхөөс хэтрэхгүй байна	Эцэг эх ах эгч нар нь ойлгоогүйг зааж байна	Нэгдсэн журмаар хичээл орж байгаа учир хувийн сургуулиуд онлайн хичээл оролгүй дараа жилийн төлбөрөөс хөнгөлөх
	Хэт их даалгавар өгөөд хүүхдүүд ойлгохгүй чанар муу байна	Цөөхөн цагийн онлайн хичээл	Хүүхэд эцэг эх л сурах үүрэг хүлээж бна Хүүхдүүд ойлгохгүй байна	Өндөр төлбөр авсан ЕБС-үүд бүтэн цагийн төлбөр аваад онлайнгаар цөөхөн цагийн хичээл орох нь хангалтгүй байна, хувийн сургуулийн төлбөрийг хасах нь зөв

UIH.MN
СУДАЛГААНЫСАН